

**ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ**



# **ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ**

**ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ**

**2019 №1 (67)  
17 дахь жилдээ**

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### ЭРХЛЭГЧ

**Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

### ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**Батбуян БАТ-ЭРДЭНЭ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бөхчулуун Бат-Эрдэнэ**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Бадам БАТЗОРИГ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Баатар БОЛДБААТАР**  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Насанжаргал ГАНБАДРАЛ**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

**Жамсран ДОЛГОРСҮРЭН**  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

**Наваанпэрэнлэй ЖАНЦАН**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Авирмэд ЛХАГВА**  
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

**Ганбат ЭРДЭНЭБАТ**  
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН  
ШАДАР ЗӨВЛӨХ

**Батзэвэг ЭНХБОЛД**  
ДОКТОР (Ph.D)

### НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**Сэнгээ ГАНТУЛГА**  
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

### ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

**Түмэнбаатар БАЯСГАЛАН**  
Магистр LLM (Wuhan University, China)

### ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

**Лхажаа ОДХҮҮ**  
Магистр LLM

## ГАРЧИГ

<b>КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>	
Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаагаар тооцсон байдал.....	Б.Энхболд
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 2018 оны нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам.....	А.Амгалан
Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт хийсэн шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний дүгнэлтийг судалсан нь.....	Б.Мөнхдорж, С.Байгальмаа, Э.Бямбажаргал
Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, агнуурын тухай гэрээ, хэлэлцээрт хийсэн судалгааны тойм.....	Д.Бадамцэцэг
Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт.....	Г.Мөнгөншагай
Хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын үр нөлөөнд “Татгалзуулах онол” (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ.....	Д.Нямбат
Тоглоомын онол ба хууль зүйн шинжлэх ухаан: арга зүйн асуудал.....	Д.Бадамцэцэг, С.Оюунчимэг
Мөрдөгчийн мэдэгдэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах арга, хэлбэр болох нь.....	П.Эрдэнэбаатар
Монгол Улсын гадаад өрийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ.....	Э.Өлзийжаргал
Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого, түүнд хийсэн дүн шинжилгээ.....	Б.Оюунболд
Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал ба Монгол Улсын өнөөгийн байдал.....	Ө.Жаргалан
Олон нийтэд хүргэж буй мэдээлэл аюулгүй байдалд нөлөөлөх нь.....	Б.Цэцэгмаа
<b>ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>	
Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацааны учир холбогдол.....	Ц.Цэлмэг
2002 ба 2015 оны Эрүүгийн хууль дахь эмнэлгийн нэр томъёоны харьцуулалт.....	П.Ариунболд, М.Цэрэнбат, Ж.Эрдэнэбулган
Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хүн барьцаалах гэмт хэргийг хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа .....	Д.Сундуйсүрэн
Аргагүй хамгаалалтын эрх зүйн зохицуулалт, анхаарах асуудал.....	Л.Бат-Очир
<b>ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ</b>	
Цагдаагийн албаны хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалт, чанар, стандарт, анхаарах асуудал.....	Ш.Чулуун

# КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## МОНГОЛ УЛС ДАХЬ НУУГДМАЛ ГЭМТ ЯВДЛЫН ТҮВШИНГ ГЭМТ ХЭРЭГТ ХОХИРОХ ЯВДЛЫН СУДАЛГААГААР ТООЦСОН БАЙДАЛ

Б.Энхболд

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн  
тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

### 1. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИНГ СУДЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Гэмт хэргийн индексийн гаргадаг Олон Улсын байгууллагын судалгаагаар 2016 онд Монгол Улс дахь иргэдийн аюулгүй байдлын түвшин 42.2 хувь, иргэд гэмт хэрэгт өртөх эрсдэл буюу гэмт хэргийн түвшин 57.6 хувьтай байгаа нь дэлхийн 118 улсаас 23 дугаарт байрт орж байсан бол 2017 оны эцсийн байдлаар иргэдийн аюулгүй байдлын түвшин 32.8 хувь, гэмт хэргийн түвшин 66.6 хувьтай болж өмнөх жилтэй харьцуулахад нөхцөл байдал хүндэрч, 12 дугаар байрт оржээ.

Харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд, Монголчуудын 71.1 хувь нь ойрын 3 жилийн хугацаанд гэмт хэрэг өснө гэж санаа зовниж байгаа бол эд хөрөнгөө хулгайд алдана, бусдын халдлагад өртөнө гэхээс 64.8 хувь нь түгшиж байна гэжээ<sup>1</sup>. Дээрх судалгааны дүнгээс иргэдийн аюулгүй байдлыг хангах шаардлага зүй ёсоор гарч байгаа ба үүнд Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлж, нуугдмал гэмт хэргийн түвшинг тооцох шаардлага урган гарч байна.

Судалгааны ажлын зорилго нь бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн түвшинг хохирогчоор дамжуулан тооход чиглэгдсэн.

### 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### Түүвэрлэлтийн техник

Хоёр шатанд энгийн санамсаргүй түүврийн аргыг түүврийн загварт хэрэглэсэн. Түүвэрлэлтийн эхний шатанд хүн амынх нь тоотой шууд хамааралтайгаар Улаанбаатар хотын 9 дүүргээс 8 дүүргийг, 21 аймгаас 14 аймгийг сонгон авсан. Түүвэрлэлтийн хоёр дахь шатанд төлөөлөх чадварыг хангах үүднээс дүүрэг тус бүрээс дунджаар 66 иргэн, аймаг тус бүрээс дунджаар 65 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар тус тус сонгосон болно.

Түүвэр олонлогийн хэмжээг түүврийн зайлшгүй хэрэгцээт тоог тодорхойлох хувийн жингийн аргаар дараах томъёоны тусламжтай тодорхойлов. Үүнд:

$$n = QP \left( \frac{Z_{(1-\alpha/2)}}{e^2} \right)^2 ;$$

Үүнд:

$n$ - Түүврийн зайлшгүй хэрэгцээт тоо

$e$ - Түүврийн алдаа буюу байж болох алдааны түвшин

$P$ - 17 –с дээш насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин

$Z_{(1-\alpha/2)}$  - Хүсэж буй итгэлтэй түвшин дэх статистик хэвийн тархалтын утга

Хүснэгт 1

#### Нийт хүн амд 17–оос дээш насны хүн амын эзлэх хувь, 2017 он

Байршил	Нийт хүн ам		17 –оос дээш насны хүн ам	
	Хүн амын тоо	Хувийн жин	Хүн амын тоо	Хувийн жин
Улаанбаатар хот	1380792	54.9	930166	67.4

<sup>1</sup> “Монгол улс дахь гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаа-2017” УБ., 2018.

<b>Хөдөө</b>	1682776	45.1	1103025	65.7
<b>Улсын дүн</b>	<b>3063568</b>	<b>100</b>	<b>2033191</b>	<b>66.7</b>

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn), УСГ, 2017

Хүснэгт 1-ийн үзүүлэлтүүдийг ашиглаад дээрх томъёоллын дагуу түүврийнхээ хэмжээг тодорхойлохын тулд эхлээд томъёонд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлов.

-  $z$  – ийн 99.9 хувийн ач холбогдлын түвшин дэх  $t$ - статистикийн тархалтын утга 3.29

-  $P$  - 17-с дээш насны хүн амын хувийн жин улсын дүнгээр 66.7 %

-  $e$  – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авдаг бөгөөд практикт 5-15 хувийн алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд харьцангуй алдаа 5%)

Хүснэгт 2

### Түүврийн тооцоолол

Байршил	$z$	$p$	$Q=100-p$	$e$	$n$
Улсын дүн	3.29	66.7	33.3	5	962


Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Эдгээр мэдээлэл болон дээрх томъёог ашиглан түүвэр олонлогийн оновчтой хэмжээг 962 иргэн гэж тодорхойллоо. Түүврийн бус алдаа болон кластерийн нөлөөг хамгийн бага байлгах үүднээс эх олонлогоос нийт 1449 иргэнийг түүвэр судалгаанд хамруулсан.

### Түүвэрийн хэмжээ:

Нуугдмал гэмт хэргийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймгийн иргэд болон Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Багахангай, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх зэрэг 8 дүүргийн иргэдийг оролцуулан нийт 1449 иргэнээс авснаас 916 буюу 63.2 хувь орон нутгаас, 533 буюу 36.8 хувь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын 660 буюу 45.5 хувь эрэгтэй, 789 буюу 54.5 хувь нь эмэгтэй байна. Дээрх иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 21 хувь нь 18-25 нас, 37 хувь нь 26-35 нас, 24 хувь нь 36-45 нас, 12 хувь нь 46-55 насны иргэд байна. /График №1/

График №1. Судалгаанд оролцогчдын насны байдал



Боловсролын түвшингээр нь авч үзвэл, 59 буюу 4.1 хувь нь боловсрол эзэмшээгүй, 210 буюу 14.5 хувь нь бүрэн бус дунд, 463 буюу 32 хувь нь бүрэн дунд, 690 буюу 47.6 хувь нь дээд боловсролтой иргэд байна. /Хүснэгт №1/

Хүснэгт №1 Боловсрол эзэмшсэн байдал

Боловсролын түвшин	Тоо	Хувь
Боловсрол эзэмшээгүй	59	4.1%

Бүрэн бус дунд боловсролтой	210	14.5%
Бүрэн дунд боловсролтой	463	32.0%
Дээд боловсролтой	690	47.6%
<b>Нийт</b>	<b>1449</b>	<b>100.0%</b>

Судалгааны түүврийн хэмжээ, оролцогчдын хүн ам зүйн шинжээс үзвэл судалж буй асуудлын талаар бодитой мэдээлэл өгөх боломжтой нийгмийн гишүүдийн төлөөлөл оролцсон байна.

**Судалгаанд ашигласан мэдээлэл ба асуулт:**

НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх хорооноос гаргасан “Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох” /National crime victimization survey/ аргачлалын зарчимд тулгуурласан. Гэмт хэрэгт хохирох явдлын түвшинг тооцох гэдэг нь гэмт хэрэг, халдлагад өртсөн боловч цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй байгаа нуугдмал гэмт хэргийн түвшинг хохирогчоор дамжуулан тодорхойлох аргачлал.

Энэхүү судалгааг Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, судлаачдын хамтарсан баг 2017 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2018 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд түүвэрт багтсан аймаг, нийслэлийн дүүргийн иргэдийн дунд явуулсан **“Монгол Улс дахь гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа”** суурь судалгааны тайлангийн мэдээллийн сангаас дараах асуултуудыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд: “Та өнгөрсөн 1 жилийн хугацаанд гэмт хэргийн хохирогч болж байсан уу?”, “Өнгөрсөн 1 жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?”, “Хэрэв хохирогч болж байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу?” гэсэн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд чиглэгдсэн өргөн хүрээний асуултууд багтсан.

Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтээс тодорхой төрлийн гэмт хэргийн үзүүлэлтийг авсан болно.

**Үр дүнг тооцсон аргачлал:**

Үр дүнг тооцохдоо дараах шалгуур баримталсан. Үүнд:

1. Судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 13 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асуулгын аргаар тодорхойлсон бөгөөд хариултыг 1=Тийм, 2= Үгүй гэсэн сонголттой байхаар тооцсон; (Хүснэгт №1)
2. Гэмт хэрэгт хохирсон гэж хариулсан оролцогчдын тоог 100 хувь гэж үзвэл тэдний хэдэн хувь нь цагдаагийн байгууллагад энэ талаараа мэдээлэлж байсныг тооцоолсон; (Хүснэгт №2)
3. Судалгааны үр дүнгийн бодит байдлын шалгуурыг түүвэрлэлтийн техник, хэмжээ, оролцогчдын шинж байдал, томъёоллоор тодорхойлсон;
4. Нуугдмал гэмт хэргийн түвшинг улсын хэмжээнд болон тодорхой төрлийн гэмт хэргийн жишээн дээр гаргахдаа дараах томъёоллыг ашиглан тооцоолсон.

**Томьёо 1**

$$y = X \left( \frac{1}{K} - 1 \right)$$

X – Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг

Y - Нийт бүртгэгдсэн байх магадлалтай гэмт хэрэг

K- Гэмт хэрэгт өртөөд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн коэффициент, “K”-г тодорхойлохдоо гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны асуулаад хохирсон гэж хариулт өгөөд, тэднээс цагдаад мэдэгдсэн хүмүүсийн хувь хэмжээгээр (0-1) үнэлгээгээр тодорхойлно.

**Томьёо 2.**

$S=Y-X$
---------

## S- Цэвэр нуугдмал байх гэмт хэргийн тоо

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм ашиглан боловсруулсан бөгөөд судалгааны үр дүн, дүгнэлт нь зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон бодит байдалд үндэслэгдсэн болно.

### 3. НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙГ ТҮВШИН ТООЦСОН БАЙДАЛ

#### 3.1 Гэмт хэрэгт шууд болон шууд бусаар хохирсон байдал:

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 13 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт №3-т гэмт хэргийн улмаас сүүлийн 1 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмбэлэн харуулав.

Судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 257 буюу 17.8 хувь нь эд хөрөнгөө залилан мэхлүүлэх замаар хохирсон гэж тус тус хариулжээ. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байна.

Хүснэгт №3 Гэмт хэрэгт шууд хохирсон байдал:

№	Гэмт хэргийн төрөл	Туйм	(%)	Үгүй	(%)
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	32.0	(%)	68.0	(%)
2	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	17.8	(%)	82.2	(%)
3	Гүтгэгдэж, доромжлогдож	16.3	(%)	83.7	(%)
4	Зам тээврийн осолд өртөж	15.1	(%)	84.9	(%)
5	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	14.5	(%)	85.5	(%)
6	Бусдын халдлагад өртөж	14.3	(%)	85.7	(%)
7	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	10.1	(%)	89.9	(%)
8	Цахим гэмт хэрэгт өртөж	8.0	(%)	92.0	(%)
9	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж	6.5	(%)	93.5	(%)
10	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	6.3	(%)	93.7	(%)
11	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	5.4	(%)	94.6	(%)
12	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	4.8	(%)	95.2	(%)
13	Хууль бус мөрдлөгийн улмаас	4.7	(%)	95.3	(%)

Эх сурвалж: Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, УБ., 2017 он

Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлоход шууд бусаар хохирсон байдлыг тодруулах нь ач холбогдолтой байдаг. Иймээс судалгаанд оролцогчдоос "Өнгөрсөн нэг жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?" гэсэн асуулт тавихад бие махбодын хувьд хохирсон гэж 17.6 хувь нь, авилгын улмаас хохирсон гэж 8.5 хувь нь, эд хөрөнгийн хувьд хохирсон гэж 29.9 хувь нь, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж хохирсон гэж 4.9 хувь нь тус тус хариулжээ. /График №8/

**График №8. Шууд бусаар гэмт хохирсон байдал**



Дээрх судалгаанаас үзэхэд, хулгайлах, бие махбодын хувьд хохирох гэмт хэргийн нуугдмал байх магадлал өндөр байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд авлига, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өсч байгаа талаар эрдэмтэн, судлаачид мэдээлэл хийж байгаа боловч энэ судалгааны үр дүнгээр тийм ч өндөр үзүүлэлттэй биш.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүс ямар арга хэмжээ авсан талаар тодруулах зорилгоор **“Хэрэв та өөрөө эсвэл таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байсан уу?”** гэсэн асуултад судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг Хүснэгт №5-д нэгтгэн харуулав.

**Хүснэгт № 5 Гэмт хэрэгт хохироод мэдээлсэн байдал**

№	Гэмт хэргийн төрөл	Судалгаанд оролцсон иргэд	Хохирсон иргэдийн тоо	Хуулийн байгууллагад мэдэгдсэн иргэдийн тоо	Хувь (%)	Нуугдмал байх магадлалын хувь (%)
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	1449	463	184	39.7 (%)	60.3(%)
2	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	1449	257	62	24.1 (%)	75.9(%)
3	Гүтгэгдэж, доромжлогдож	1449	236	38	16.1 (%)	83.9(%)
4	Зам тээврийн осолд өртөж	1449	218	119	54.5 (%)	45.5(%)
5	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	1449	210	89	42.2 (%)	47.8(%)
6	Бие махбодын халдлагад өртөж	1449	207	44	21.1 (%)	78.9(%)
7	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	1449	146	17	11.7 (%)	88.3(%)
8	Цахим гэмт хэрэгт өртөж	1449	115	22	19.2(%)	80.2(%)
9	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж	1449	94	13	13.6(%)	86.4(%)
10	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	1449	91	53	58.1(%)	41.9(%)
11	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	1449	78	58	74.7.(%)	25.3(%)



12	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	1449	69	10	14.5(%)	85.5(%)
13	Хууль бус мөрдлөгийн улмаас	1449	68	12	18.1(%)	81.9(%)
<b>Улсын хэмжээний дундаж</b>		<b>1449</b>	<b>175</b>	<b>55</b>	<b>31.3(%)</b>	<b>68.7(%)</b>

Эх сурвалж: Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа, УБ., 2017 он

Дээрх судалгаанаас харахад гэмт хэрэгт хохирсон хүмүүсээс дөнгөж 31.3 хувь цагдаа, хуулийн байгууллагад мэдэгдэж байгаа нь нэг талаас нийт гэмт хэргийн 68.7 хувь нь нуугдмал байгааг илэрхийлж байгаа бол, нуугдмал байх хамгийн өндөр магадлалтай гэмт хэргүүдэд Авилга, мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, бэлгийн халдашгүй байдал, гүтгэх, доромжлох гэмт хэрэг, зөрчил хамаарч байна. Харин хамгийн бага түвшинд байгаа гэмт хэргүүдэд хүн барьцаалах, зам тээврийн осол, хилсээр шийдэгдэх, дээрэмдэх зэрэг гэмт хэргүүд хамаарч байна.

Хүснэгт №5-д үзүүлсэн нуугдмал байх магадлалын хувийг 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлттэй харьцуулах байдлаар нуугдмал байх гэмт хэргийн тоон үзүүлэлт, бүртгэгдсэн гэмт хэргээс хэд дахин их байгааг харьцуулан дүн шинжилгээ хийв. Хүснэгт №6-д үзүүлснээр 2017 онд улсын хэмжээнд нийт 20032 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийгэмд бодитоор үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 31.3 хувь гэж дээрх аргачлалын дагуу тооцож болно. Хэрэв 20032 нь нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 31.3 хувь бол 100 хувь нь хэдэн гэмт байх бэ? гэсэн тоон үзүүлэлтийг пропорцын аргаар тооцож, гарсан тооноос бүртгэгдсэн гэмт хэргийг хасах байдлаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлсон болно.

**Хүснэгт №6 Гэмт хэргийн нуугдмал байх магадлал**

№	Гэмт хэргийн төрөл, зүйл анги	Бүртгэгдсэн гэмт хэрэг /2017 он/	Нийт үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн тоо	Нуугдмал байх магадлалтай тоо	Бүртгэгдсэн-ээс хэд дахин их
1	Хулгайлах /ЭХТА 17.1, 17.12/	8379	21105	12726	1.5
2	Залилах /ЭХТА-ийн 17.3/	2020	8381	6361	3.1
3	Авто тээврийн хэрэгслийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих /ЭХТА-ийн 27.10/	754	1383	629	0.8
4	Дээрэмдэх /ЭХТА-ийн 17.2/	1007	2106	1099	1.0
5	Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг /ЭХТА-ийн 10.1, 11.1, 11.5, 11.6 дүгээр /	5040	23886	18846	3.7
6	Авилгын гэмт хэрэг /ЭХТА-ийн 22.1 22.4, 22.5/	18	153	135	7.5
7	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /ЭХТА-ийн 26 дугаар бүлэг/	39	203	164	4.2
8	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэрэг /ЭХТА-ийн 20.7, 20.8/	101	742	641	6.3

9	Хилсээр хэрэгт шийтгэгдэх /ЭХТА-ийн 21.12, 21.14/	74	127	53	0.7
10	Хүн барьцаалах, хулгайлах /ЭХТА-ийн ЭХТА-ийн 13.2, 13.3, 13. 4/	8	11	3	0.3
11	Хүчиндэх, бэлгийн мөлжлөг /ЭХТА-ийн 12.1, 12.2, 12.3/	269	1855	1586	5.8
12	Хууль бусаар мөрдөж мөшгих /ЭХТА-ийн 13.12/	2	11	9	4.5
	<b>Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	<b>20032</b>	<b>64000</b>	<b>43968</b>	<b>2.2</b>

### Дүгнэлт

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Аюулгүй орчинд амьдрах эрхтэй", Арван есдүгээр зүйлийн 1 дахь хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", мөн Гучин наймдугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх" нь засгийн газрын үүрэг мөн гэж тодорхойлсон нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэгжүүлэх, үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох зүй ёсны шаардлагатай холбогдоно.
2. Цаг хугацаа орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсэж бий болсон төрийн бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг нуугдмал гэмт хэрэг гэж тодорхойлж болно. Нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх тусам, иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, нийгмийн дэг журам алдагдаж, иргэд гэмт хэргээс түгших хандлага нэмэгддэг.
3. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох зорилгоор 1449 иргэнээс авсан судалгааны дүнгээс үзэхэд, улсын хэмжээнд нуугдмал байх гэмт хэргийн тоо 45862 гэсэн үзүүлэлт гарч байгаа нь өнөөгийн гэмт хэргийн түвшингээс 2.2 дахин их байгааг илтгэж байна. Монгол Улс дахь гэмт хэргийн нуугдмал байх шинжийг харгалзан гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны асуудлыг шинэчлэн тогтоох шаардлагатай.
4. Тодорхой төрлийн гэмт хэргийн дотроос авлигын гэмт хэрэг 7.5 дахин, хүчиндэх, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 5.8 дахин, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 6.3 дахин, хууль бусаар мөрдөн мөшгих гэмт хэрэг 4.5 дахин, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.2 дахин их байгаа нь анхаарал татаж байна.
5. Монгол Улсын нийт гэмт хэргийн бүтцэд 41.8 хувийг эзэлж байгаа хулгайлах гэмт хэргийн нуугдмал байх магадлал 12726 буюу бүртгэгдсэн гэмт хэргээс 1.5 дахин их, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нуугдмал байх магадлал 18846 буюу бүртгэгдсэн гэмт хэргээс 3.7 дахин их байх боломжтой байна.
6. Хүн барьцаалах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргүүд нуугдмал байх магадлал харьцангуй бага байна.

### Эх сурвалжийн жагсаалт:

1. Сазонова Н.В. "Понятие латентной преступности" Уголовное право и современность: Межвуз. Сб. Науч.тр. Вып. 6. Красноярск: СибУОИ МВД, 2002.-С.8-180-184.
2. Д.Мягмарцэрэн "Нуугдмал гэмт хэрэг, ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал", "Хууль сахиулахуй" сэтгүүл, УБ., 2015. №1
3. Ли.Д.А. Уголовно-статистический учёт: структурно-функциональные закономерности: моногр.М.:Русский мир, 1997. 21 хуудас.
4. Roberson Wallace, introduction to criminology., New York, 2009

5. Цагдаагийн Ерөнхий Газар. *“Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2017”*, УБ. 2018 он.
6. Цагдаагийн Ерөнхий Газар. *“Монгол Улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2003-2013”*, УБ. 2017 он.
7. Хууль сахиулахын их сургуулийн судалгааны баг, *“Монгол Улс дахь гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа-2017”*, УБ., 2018 он
8. [www.1212.mn](http://www.1212.mn), Үндэсний статистикийн газар, 2017

## ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН 2018 ОНЫ МОНГОЛ УЛС ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ



*А.Амгалан  
ЦЕГ-ын Хэрэг бүртгэх албаны дарга,  
цагдаагийн хурандаа*

Цагдаагийн Ерөнхий газрын Хэрэг бүртгэх алба нь 2002 оны Эрүүгийн хуульд хөнгөн хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулдаг байсан. Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн гаралт, албан хаагчдын ажлын ачаалалд судалгаа хийж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/11, Б/35 дугаар тушаалаар Хэрэг бүртгэх алба нь 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг дагнан явуулах, энэ чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэрэг бүртгэх албаны 2018 онд харьяалан шалгасан энэ төрлийн гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд:

### Нэг. Өргөдөл, гомдлын талаар:

Улсын хэмжээнд 2018 онд иргэд, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 12441 бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад 82 нэгжээр буюу 0.1 хувиар өссөн байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд 8850 буюу 71 хувь, орон нутагт 3566 буюу 28 хувийг эзэлж байна.



Улсын хэмжээнд бүртгэгдсэн “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг” гомдол, мэдээлэл нийт гомдол, мэдээллийн 6.3 хувийг, нийслэлийн хэмжээнд 7273 буюу 8.2 хувийг тус тус эзэлж байна.


Нийт 10292 гомдол, мэдээлэл шалгаснаас 7926 буюу 77.0 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 3103 буюу 22.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 143 буюу 1.3 хувийг нь харьяаллын дагуу бусад албадад шилжүүлэн, 305 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

### Хоёр. Гэмт хэргийн талаар:

Улсын хэмжээнд 2018 онд 36220 хэрэг бүртгэгдсэний 9134 буюу 25.2 хувийг нь “Хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” эзэлж байна.

Нийслэлд 5867 буюу 64,2 хувь үйлдэгдэж, улсын хэмжээнд сард дунджаар 761.1 гэмт хэрэг, нийслэлд 488.9 гэмт хэрэг бүртгэгдэж байна. Орон нутагт 164 нэгжээр буюу 4,7 хувиар буурсан байна.

Өмнөх онтой харьцуулсан байдал:



Улсын хэмжээнд нийт гэмт хэргийн илрүүлэлт 36.0 хувьтай өмнөх оны мөн үеэс 0,3 хувиар өссөн бол “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн илрүүлэлт 66.1 хувь, өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт нийслэлд 58.1 хувь, орон нутагт 83 хувьтай байна

Нийслэлийн хэмжээнд 7.0 хувиар, орон нутагт 6.1 хувиар гэмт хэргийн илрүүлэлт тус тус өссөн статистик гарчээ.


#### Бүртгэгдсэн гэмт хэргийг зүйл ангиар нь авч үзвэл:

Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах 11.6 зүйл ангиар бүртгэгдсэн хэрэг өмнөх оны мөн үеэс 657 нэгжээр буюу 8,8 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 65,8 хувьтай өмнөх оны мөн үеэс 6,5 хувиар өссөн ба нийт гэмт хэргийн 88,4 хувийг эзэлж байна.


Эрүүгийн хуулийн зүйл	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Өсөлт бууралтын хувь өссөн	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	2017	2018		
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах /11.6 дугаар зүйл/	7471	8128	8.8% өссөн	88 %
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах /11.4 дүгээр зүйл/	647	401	38% буурсан	4%
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /11.1 дүгээр зүйл/	401	295	26.4% буурсан	3%
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх /11.7 дугаар зүйл/	223	210	5.8% буурсан	2%
Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах /11.5 дугаар зүйл/	30	63	52,3% өссөн	0.6%
Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах /11.3 дугаар зүйл/	35	29	17.1% буурсан	0.3%

Гэмт хэргийн гаралт үндсэн дүнгээрээ өссөн боловч сар тутамдаа буурсан үзүүлэлттэй байна.

Нийслэлийн хэмжээнд 2420 гэмт хэрэг эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байна. Энэ нь нийт хэргийн 13,6 хувийг эзэлж байна.



Гэмт хэргийн гаралтыг дүүргээр нь харьцуулан авч үзвэл:




Дүүргүүдийн гэмт хэргийн гаралтын түвшинг ихээс бага руу харин илрүүлэлтийн түвшинг 1-ээс 17 гэсэн дараалалд оруулсан байдал.

Дүүргүүдийн хувьд энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг харьцуулахад Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн 1-р хэлтэст гэмт хэргийн гаралт бусад дүүргүүдээс өндөр түвшинд байна. Хамгийн өндөр гэмт хэргийн гаралттай Баянзүрх дүүргийн 2-р хэлтэс хамгийн бага Сонгинохайрхан дүүргийн 3-р хэлтсээс 2,8 дахин их байгаа ба Баянзүрхийн Баянцээл төвийг дагасан шөнийн цэнгээний газар, худалдаа үйлчилгээний газар байрлаж байгаатай холбоотой байна.

Орон нутаг: Орон нутгийн гэмт хэргийн гаралтыг ихээс бага руу харин илрүүлэлтийн хувийг 1-20 гэсэн дараалалд оруулсан байдал

Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн гаралтаараа Баянзүрх дүүргийн 2-р хэлтэс өндөр хувийг эзэлж байгаа бол орон нутагт Дархан-Уул аймаг 262 хэргээрээ орон нутагт дээгүүр үзүүлэлттэй

байна. Хэдий дүүргээс бага гэмт хэрэг бүртгэгдсэн боловч гэмт хэргийн илрүүлэлт өндөр үзүүлэлттэй байна.



**Гурав. Хохирсон иргэн, учирсан хохирол, нөхөн төлүүлсэн талаар:**

**Хохирсон иргэн:** Гэмт хэргийн улмаас 7957 иргэн хохирч өмнөх оны мөн үеэс 248 буюу 3,7 хувиар өссөн байна. Хохирсон иргэдийн 6118 буюу 76,8 хувь нь хөнгөн, 1261 буюу 13,5 хувь нь хүндэтэр, 578 буюу 6,2 хувь нь хүнд зэргийн гэмтэл учирсан бол 3526 буюу 37,9 хувь нь эмэгтэй хүн, 0,8 хувь нь 7 хүртлэх насны хүүхэд, 30,7 хувь нь 35-аас дээш насныхан, 17,6 хувийг 25-29 нас, 18,8 хувийг 30-35 нас, 14,9 хувийг 18-24 нас, 5,1 хувийг 8-17 насны насанд хүрээгүй хүүхэд, залуучууд, залуучууд тус тус эзэлж байгаа бол эзэлж байна

**Учирсан хохирол, нөхөн төлүүлсэн байдал:** Гэмт хэргийн улмаас 9347 иргэн хүнд, хөнгөн гэмтэж 10 тэрбум 348 сая төгрөгийн хохирол учирч нийт хохирлын 7 тэрбум 015 сая буюу 67,0 хувийг нь нөхөн төлүүлж, 882 сая төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хохирогчийн эрх ашгийг хамгаалан ажилласан байна.

**Холбогдсон этгээд:** Энэ төрлийн гэмт хэрэгт нийт 7732 иргэн холбогдон шалгагдсан ба 3483 ба 45.0 хувь нь согтууруулах ундаа хэрэглсэн үедээ, 5,2 хувь нь бүлэглэж, 11.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 2.7 хувь нь хүүхэд оролцож үйлдэгдсэн байна.

Холбогдогчийн нас: 1835 буюу 23,7 хувийг 36-45 насны

1721 буюу 22.2 хувийг 26-30 насны

1503 буюу 19.4 хувийг 18-25 насны


1316 буюу 17,0 хувийг 31-35 насны

857 буюу 11,0 хувийг 46-55 насны

215 буюу 2.7 хувийг 7-17 насны 178 буюу 2,3 хувийг 56-73 насныхан эзэлж байна.

Гадаадын иргэн холбогдсон 7 орны 23 иргэн байгаа ба ОХУ-5, Солонгос-1, Унгар-1, БНХАУ-13, Серби, Вьетнам, Австри улсын иргэд холбогджээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 191 этгээд байгаа ба 21-29 насныхан 18.3 хувь, 30-




35 насныхан 29.8 хувь, 36-45 насныхан 65 хувь, 46-57 насныхан 17.8 хувийг тус тус эзэлж байна.

Ажилгүй иргэд 59.6 хувийг, төрийн албан хаагч 5.7 хувийг, хувийн хэвшлийн ажилтан 8.3 хувийг, 11.5 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч үйлдсэн байна.


**Дөрөв. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийн талаар:**

Нийт хэргийн 28,6 хувь нь гудамж талбайд үйлдэгдснээс орон сууцны хороололд 28,4 хувь, 39,9 хувь гэр хороололд үйлдэгдсэн байна. Олон нийтийн газар 16,8 хувь, төрийн байгууллагад 0,9 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.


Хэрэг гарсан газрын онцлог:



Олон нийтийн газар үйлдэгдсэн хэргээс хамгийн өндөр үзүүлэлтэй газар бол баар, ресторан эзэлж байгаа ба нийт гэмт хэргийн 8,8 хувь дангаараа шөнийн цэнгээний газарт үйлдэгдэж байна.




Цаг хугацаагаар нь авч үзвэл: Гэмт хэргийн гаралт 19:00 цагаас 01:00-02:00 цагийн хооронд өссөн байдлаар үйлдэгдээд 03:00-05:00 цагийн хооронд буурч байгаа хэлбэлзэлтэй харагдаж байна. Харин гэр хорооллын хувьд 19:00 цагаас 21:00 цагийн хооронд буураад 22:00-01:00 цагийн хооронд өсч байна. Орон сууцны хорооллынх баарны давтамжтай адилхан хэлбэлзэлтэй харагдаж байна.





Ашигласан багаж, зэвсэг Энэ төрлийн гэмт хэргийн 548 буюу 7 хувийг нь хутга мэс, 139 буюу 2 хувийг архины шил, 105 буюу 1 хувийг чулуу, мод, 15 буюу 0,2 хувийг ташуур, хүрз, 0,01 хувийг галт зэвсгээр тус тус үйлдсэн байна.



Үйлдлийн аргаар нь авч үзвэл: 5691 буюу 62,3 хувь нь цохисон, 617 буюу 6,7 хувийг өшиглөсөн, 175 буюу 1,9 хувийг түлхэж унагаасан, 150 буюу 1,6 хувийг боосон, хутгалсан 615 буюу 6,7 хувийг, 1063 буюу 11.6 хувийг бусад байдлаар гэмтээсэн байна.

**Тав.Гэмт хэргийн хөдөлгөөн, шийдвэрлэлтийн талаар:**



Тус албанаас санаачлан Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран "Гэмт хэрэг, зөрчлийн хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инноваци" нэвтрүүлэх нь шилдэг илтгэлийн уралдаан, "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье" сэдэвт хэлэлцүүлгийг аймаг, нийслэл, дүүрэг, сум, хороодод шат шатны Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг, "Хуулийн хэрэгжилт-2" зэрэг томоохон ажлыг зохион байгуулан, иргэдэд эрх зүйн боловсрол олгох чиглэлээр хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр олон нийтэд сурталчилан, урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгон ажилласнаар "Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах", "Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах", "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" гэмт хэргүүд 5.8-38 хувиар буурсан байна.

2019 онд "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг" ихээр үйлдэгддэг 3 дугаар сарыг сонгон авч ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран нэг сарын хугацаанд "Нэг хором" аяныг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд:

1. 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдөр "Ub Palace-ийн концертын их танхимд 4000 гаруй оюутан залуусыг хамруулсан "Ухаалаг залуус-Амьдрал аварна" сэдэвт уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, урлаг, соёлын од, нийгэмд нэр хүнд бүхий хүмүүсээр ухуулга, нөлөөллийн ажиллагаа явуулж "Нэг хором" аянд нэгтгэсэн.

2.Цагдаагийн ерөнхий газар, Хэрэг бүртгэх алба, Урьдчилан сэргийлэх хэлтсийн website, пейж хуудас болон олон дагагчтай группүүдэд ухуулга нөлөөлөл, сурталчилгааны 7 төрлийн бичлэг, 24 зурагт хуудас, постерийг байршуулж иргэдэд хүргэснээр 844.637 хүний хандалт авч, 332 сэтгэгдэл үлдээж, 11.000 хүн хуваалцсан байна.

3. Их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, Монголын хөл бөмбөгийн холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоо, Монголын үндэсний бөхийн холбоо, олны танил урлаг, спортын алдартнуудыг "Нэг хором" аянд нэгтгэж, олон нийтэд ойлгомжтой шторк, контентуудыг хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ явуулж, иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр холбогдох хуулиудыг сурталчилж байгаа нь ихээхэн үр дүнтэй арга хэмжээ болж байна.

**ХҮЧИНДЭХ, БЭЛГИЙН ДҮР ХҮСЛЭЭ ЁС БУСААР ХАНГАХ, АРВАН ЗУРГААН НАСАНД  
ХҮРЭЭГҮЙ ХҮНТЭЙ БЭЛГИЙН ХАРЬЦААНД ОРОХ ГЭМТ ХЭРЭГТ ХИЙСЭН  
ШҮҮХ СЭТГЭЦ ЭМГЭГ СУДЛАЛЫН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ДҮГНЭЛТИЙГ СУДАЛСАН НЬ**

*Б.Мөнхдорж  
ХСИС-ийн ЭШХ-ийн эрдэм  
шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), цагдаагийн хошууч  
С.Байгальмаа  
Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн  
Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн эрхлэгч  
Э.Бямбажаргал  
ХСИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*


Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1 дүгээр зүйлд заасан хэрэгт 2015-2017 онд 332 шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийсэн байна.

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.2, 12.5 дугаар зүйлээр 2015-2017 онд сэтгэцийн байдлын магадлан шинжилгээ хийгээгүй байна.

Дээрх шинжилгээг хэргийн төрлөөр авч үзвэл,

- 126.1 дүгээр зүйлд заасан хэрэгт 138 буюу 41.5 хувь;
- 126.2 дугаар зүйлд заасан хэрэгт 19 буюу 5.7 хувь;
- 126.3 дугаар зүйлд заасан хэрэгт 90 буюу 27.1 хувь;
- 126.2.4 дүгээр зүйлд заасан хэрэгт 20 буюу 6 хувь;
- 126.2.6 дугаар зүйлд заасан хэрэгт 6 буюу 1.8 хувь;
- 125.1 дүгээр зүйлд заасан хэрэгт 2 буюу 0.6 хувь;
- 125.2 дугаар зүйлд заасан хэрэгт 12 буюу 3.6 хувь;
- 12.1 дүгээр зүйлд заасан хэрэгт 32 буюу 9.6 хувь;
- 12.1.4 дүгээр зүйлд заасан хэрэгт 11 буюу 3.3 хувь;
- 12.1.3 дугаар зүйлд заасан хэрэгт 2 буюу 0.6 хувь.

График.1



Судалгаанд хамрагдагсдыг хүйсээр нь авч үзвэл, эрэгтэй 198 буюу **53.6** хувь, эмэгтэй **134** буюу **40.3** хувь нь байна.


График.2



Гэмт хэргийн хохирогчдыг оноор нь авч үзвэл:

- 2015 онд 41 буюу 26.6 хувь,
- 2016 онд 58 буюу 37.6 хувь,
- 2017 онд 55 буюу 35.7 хувь.


График.3



Гэмт хэргийн холбогдогчдыг оноор нь харьцуулан үзвэл нийт 198 холбогдогч бүртгэгдэж, 2017 онд гэрчээр 1 иргэнд шинжилгээ хийсэн байна.

- 2015 онд 37 буюу 18.6 хувь,
- 2016 онд 94 буюу 47.4 хувь,
- 2017 онд 67 буюу 33.8 хувь.

График.4



**2015-2017 онд дээрх гэмт хэргийн холбогдогч, хохирогчдод шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийсэн дүгнэлтээс харахад,**

2015 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлах шинжилгээ хийлгэгсдийн **21 /7** холбогдогч, 14 хохирогч/ буюу **5.8** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.

Үүнд: **7 /33.3 хувь/ холбогдогчид** “Оюуны хөнгөн хомдол”, “Тархины өвчин, гэмтэл үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний ба зан төрхийн бусад органик эмгэг, харин **14 /66.6 хувь/ хохирогчид** “Төрх үйлийн эмгэг”, “Сэтгэл түгших ба сэтгэл гутрах эмгэг”, “Төрх үйлийн эмгэг давамгайлсан дасан зохицолтын эмгэг”, “Оюуны хөнгөн хомдол”, “Хөнгөн хэлбэрийн сэтгэл гутрал” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

2016 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлах шинжилгээ хийлгэгсдийн **30 /10** холбогдогч, 20 хохирогч/ буюу **8.3** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.


Үүнд: **10 /33.3 хувь/ холбогдогчид** “Оюуны хомсдол, шинж тэмдгийн уналт”, “Сэтгэхүйн хөгжлийн хоцрогдол”, “Тархины өвчин, гэмтэл үйлийн хямралын шалтгаант бие хүний ба төрх үйлийн органик эмгэг шинж тэмдгийн уналт, зан төрхийн өөрчлөлт сэтгэц органик хам шинж”, “Оюуны хөнгөн хомсдол”, харин **20 /66.6 хувь/ хохирогчид** “Оюуны хөнгөн хомсдол, шинж тэмдгийн уналт”, “Бусад бүлэгт ангилагдсан тодорхой өвчний үе дэх хэсэгчилсэн тэнгэрэл”, “Зан үйлийн хямрал давамгайлсан дасан зохицохуйн эмгэг”, “Холимог диссоциатив эмгэг”, “Сэтгэлийн дарамтанд хариулах цочмог хариу урвал” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

2017 онд уг төрлийн гэмт хэрэгт холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлах шинжилгээ хийлгэгсдийн **37 /11** холбогдогч, 26 хохирогч/ буюу **23.7** хувьд нь сэтгэцийн эмгэг оношлогдсон байв.

Үүнд: **11 /33.3 хувь/ холбогдогчид** “Оюуны хөнгөн хомсдол”, “Тархины гэмтлийн шалтгаант уналт зан төрхийн өөрчлөлт”, харин **26 /66.6 хувь/ хохирогчид** “Оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдол”, “Гэмтлийн дараах стрессийн хариу урвал”, “Түгшүүрлэх, сэтгэл гутрал холимог хариу урвал давамгайлсан дасан зохицлын эмгэгт”, “Дасан зохицолтын эхлэл, эзэнгшлийн байдал”, “Гэмтлийн дараах стрессийн эмгэг”, “Сэтгэл гутрал сунжирсан хариу урвал бүхий дасан зохицохуйн эмгэг” зэрэг сэтгэцийн эмгэг оношлогдсон.

“Сэтгэцийн хувьд эрүүл” гэж оношлогдсон:

- 2015 онд 57 буюу 15.9 хувь
- 2016 онд 126 буюу 35.1 хувь
- 2017 онд 87 буюу 24.3 хувь




Хүчиндэх гэмт хэргийн холдбогдогчдын 354 нь сэтгэцийн хувьд эрүүл, хэрэг хариуцах чадвартай.

Хэрэг хариуцах чадвартай:

- 2015 онд 78
- 2016 онд 154
- 2017 онд 122

Хэрэг хариуцах чадваргүй:

- 2015 онд 2
- 2016 онд 2
- 2017 онд 3




Хэрэг хариуцах чадваргүй 3 холбогдогч нь 2015 онд сэтгэцийн эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгосон. Үүнд: “Оюуны хүндэвтэр хомсдол”, “Бие хүний эмгэг зан төрхийн өөрчлөлт, шинж тэмдгийн уналт, тархины өвчин, эмгэг үйлийн хямралын шалтгаант бие хүний ба төрх үйлийн органик эмгэг, шинж тэмдгийн уналт”, “Зан төрхийн сэтгэц органик хам шинж” зэргээр оношлогдсон байна.

Хэрэг хариуцах чадваргүй 1 холбогдогч нь 2016 онд “Тархины өвчин, гэмтэл үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний төрх үйлийн органик”, 1 хохирогч нь “Оюуны хүндэвтэр хомсдол шинж тэмдгийн уналт таталт” зэрэг сэтгэцийн эмгэгийн оношоор оношлогдсон байна.

Хэрэг хариуцах чадваргүй 1 холбогдогч нь 2017 онд “Оюуны хүндэвтэр хомсдол”, 2 хохирогч нь “Шизоаффектив эмгэгийн холимог хэлбэр”, “Оюуны хүндэвтэр хомсдол” оношоор оношлогдсон байна.

**2015-2017 онд сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч, холбогдогч нийт 88, үүнээс 58 буюу 65.9% нь хохирогч, 34% нь холбогдогч байна.**

Хэрэг хариуцах чадвартай хэдий ч сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогч холбогдогч нарыг оноор нь авч үзвэл:



Хохирогчдыг насаар нь харуулбал;

№	Нас	2015 он	2016 он	2017 он
1	0-5 нас	0	5	1
2	6-10 нас	5	9	7
3	11-16 нас	17	27	25
4	17-21 нас	12	5	6
5	22 дээш нас	5	11	11

Холбогдогчдыг насны бүтцээр нь харуулбал;

№	Нас	2015 он	2016 он	2017 он
1	0-5 нас	0	0	0

2	6-10 нас	0	0	0
3	11-16 нас	1	4	1
4	17-21 нас	4	82	51
5	22 дээш нас	35	9	12

#### **Дүгнэлт**

Судалгааны хүрээнд 2015-2017 онд үйлдэгдсэн Эрүүгийн хуулийн 126, 125, 12.1, 12.2, 12.5 дугаар зүйл ангид холбогдсон хэрэгт хийсэн шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээг хийлээ.

Дээрх хэргүүдийн 88 хувийг хүчиндэх (126.1), (12.1) гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийн хохирогчдын дийлэнхийг эмэгтэйчүүд эзэлж, насны хувьд бага насны хүүхэд өртөж байна. Хүчиндэх гэмт хэргийн хохирогчдын 44.8 хувийг 11-16 насны охид эзэлж байна.

Тухайн онуудад нийт 361 хохирогч, холбогдогч шинжилгээнд хамрагдсанаас сэтгэцийн эмгэгтэй гэсэн дүгнэлт гарсан 88, үүнээс 58 /65 хувь/ хохирогч нь эмэгтэй байна.

Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчдын 47.7 хувь нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой байлаа.

Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4 хувь нь 17-21 насны залуус байна.

#### **Санал**

1.Сэтгэцийн эмгэгтэй гэж оношлогдсон хохирогчдын 47.7% нь оюуны хөнгөн болон хүндэвтэр хомсдолтой гэснээс үзэхэд, “Оюуны хомсдол”-той хүмүүсийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгааг харуулж байна. Иймд сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

2.Хүчиндэх гэмт хэргийн холбогдогчдын 53.4% нь 17-21 насны залуус эзэлж байгаа тул өсвөр үе, залуучуудад чиглэсэн хүмүүжил, эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалтыг сайжруулах.

**МОНГОЛ УЛС, ОХУ, БНХАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНД БАЙГУУЛСАН  
ЗЭРЛЭГ АМЬТАН, УРГАМЛЫН ХУУЛЬ БУС ХУДАЛДАА, АГНУУРЫН ТУХАЙ ГЭРЭЭ,  
ХЭЛЭЛЦЭЭРТ ХИЙСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАНГИЙН ТОЙМ<sup>2</sup>**

*Д.Бадамцэцэе  
ХСИС-ийн ЭЗНУС-ийн ахлах багш,  
цагдаагийн хошууч*

**Судалгааны зорилго:** Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар болон тэдгээр харьяа яам, агентлагуудын хооронд байгуулсан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, ялангуяа зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, агнууртай холбоотой асуудлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гэрээ, хэлэлцээрийг судалж, дүн шинжилгээ хийх, цаашид холбогдох талуудтай дээрх чиглэлээр хамтран ажиллах боломжийг тусгасан санал зөвлөмжийг боловруулахад оршино.

**Үндсэн хэсэг**

Төв Азийн элгэнд ОХУ, БНХАУ-тай хил залгадаг дунд орших Монгол Улс нь Сибирийн тайга, Евро-Ази болон Төв Азийг хамран үргэлжилсэн тал хээр, говь цөлийг дамнан оршдог, Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй гурван том ай савын хагалбар нутаг юм. Газарзүйн өвөрмөц тогтолцоо, эртнээс эрхэлж ирсэн нүүдлийн мал аж ахуй, зан заншил, хүн амын сийрэг суурьшил нь Монгол орныг Евро-Ази дахь хүн ба байгалийн зэрэгцэн оршин тогтнох үйл явц, дэлхийд устан үгүй болж буй экосистем, ховордсон ургамал амьтны зүйлийг хамгаалан үлдэхэд нэн чухал орон зай болгожээ. Манай оронд экосистемийн 16 үндсэн төлөөлөл байдаг бөгөөд тэдгээрийн байгаль хамгаалал, хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдааг сайжруулах зорилгоор Дагуурын хээр (нийт нутгийн 28.2 хувь), Хангай (нийт нутгийн 16.4 хувь), Төв Азийн говь цөл (нийт нутгийн 32.3 хувь), Алтай Саяны (нийт нутгийн 23.1 хувь) гэсэн дөрвөн үндсэн эко бүст хуваадаг.

Эрс тэс уур амьсгалтай Монгол оронд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 39 баг, 112 овог, 683 төрөлд хамаарах 3127 зүйл, дэд зүйлийн гуурст ургамал 105 овгийн 288 төрлийн 1400 орчим зүйлийн замаг, 510 орчим зүйлийн хөвд, 10 овгийн 15 төрлийн 7 зүйлийн шивэрсэн хэлбэртэн нэг овгийн нэг төрлийн 9 зүйлийн нийт 556 зүйлийн дээд ургамал, 3 овгийн 6 төрлийн 22 зүйлийн нүцгэн үрт ургамал, 138 зүйлийн хөхтөн, 75 зүйлийн загас, 22 зүйлийн мөлхөгч, 6 зүйлийн хоёр нутагтан, 476 зүйлийн шувуу, 13 мянга гаруй зүйлийн шавж, 516 зүйлийн зөөлөн биетэн амьтны аймагт бүртгэгджээ.

Байгалийн ургамал, амьтны популяцийн байдлын олон жилийн тандалт судалгаанаас үзвэл, тэдгээрийн тоо толгой буурах, нөөц хомсдох, амьдрах, ургах орчин нь доройтон тархац нутаг нь хумигдах хандлагатай байна.

Амьтны тоо толгой буурах, ургамлын нөөц хомсдоход нөлөөлж буй хүчин зүйлийг дараах байдлаар тоймлон авч үзэж болно. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт хуурайшил, ой, хээрийн түймэр зэрэг байгалийн хүчин зүйл;

- Малын тоо толгойн хэт өсөлт, бэлчээрийн талхагдал, хөрсний элэгдэл, уул уурхай, газар тариалангийн үйл ажиллагаа, дэд бүтцийн байгууламж, хотжилт, хууль бус ашиглалт болон нөөцийг ашиглах менежментийг нөхцөлийг бүрдүүлээгүйгээс улбаалсан хэт ашиглалт зэрэг хүний хүчин зүйлээс голлон шалтгаалж байна.

Дээрх хүчин зүйлийн нөлөөгөөр хөхтөн амьтдын зүйлийн 16 хувь нь бус нутгийн хэмжээнд устах аюултай, 2 хувь нь устаж байгаа, 11 хувь нь устаж болзошгүй, 3 хувь нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, шувуудын зүйлийн 4 хувь нь тоо толгой буурсан, нэн ховор, ховор ургамлын зүйлийн 11 хувь нь устаж байгаа, 26 хувь нь устаж болзошгүй, 37 хувь нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15 хувь нь ховордож болзошгүй байна. Мазаалай баавгай, монгол бөхөн, тахь адуу нь зөвхөн Монгол оронд тархсан уугуул амьтад бөгөөд цоохор ирвэс, аргаль хонь, хар сүүлт, хавтгай тэмээний дэлхийн популяцийн тархацын хамгийн хойд зах нь манай улсад оршдог учраас эдгээр амьтдыг илүүтэйгээр хамгаалах шаардлагатай юм<sup>3</sup>.

<sup>2</sup> Энэхүү судалгааны ажлыг ХСИС-ийн CS11-0345: 2015 стандартанд нийцүүлсэн бөгөөд нийт судалгааны ажлын 60 хувийг тоймлон оруулсан болно.

<sup>3</sup> Байгалийн ургамал, амьтны өнөөгийн төлөв байдал, цаашид авах арга хэмжээ. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд тавьсан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын илтгэл. 2013.01.08

Байгалийн ургамал, амьтны популяцийн байдлын олон жилийн тандалт судалгаанаас үзвэл, тэдгээрийн тоо толгой буурах, нөөц хомсдох, амьдрах, ургах орчин нь доройтон тархац нутаг нь хумигдах хандлагатай байна.

2018 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 110 орчим хуульд хүрээлэн буй орчны тухай асуудлыг зохицуулсан байна. Эдгээр 110 орчим хуулиас зэрлэг ан амьтан, ургамалтай холбоотой харилцааг зохицуулсан 11 хууль, түүнтэй нийцүүлэн Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, Ногоон хөгжлийн бодлого зэрэг эрх зүйн актуудыг баталжээ. Мөн ан амьтан, ургамлыг хамгаалах, ашиглахтай холбогдсон олон улсын 6 гэрээ, конвенцид нэгдэн орсон байна.

Байгаль орчин зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нь манай улсын төдийгүй, дэлхийн нийт улс онууд, бүс нутгийн тулгамдсан асуудал болоод байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ”<sup>4</sup> гэж заасан нь хөрш зэргэлдээ БНХАУ, ОХУ хоёр оронтой харилцах үндсэн зарчмыг тодорхойлжээ.

Узбекистаны нийслэл Ташкент хотноо болсон Монгол, БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүнүүдийн гурван талт уулзалтын /2016.06.23/ үеэр гурван улсыг холбосон “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрт Монгол, Орос, Хятадын хил дамнасан экологийн коридоруудыг байгуулах, зэрлэг ургамал болон амьтны аймаг, ус, намгархаг газартай холбогдох эрдэм шинжилгээний хайгуул, хяналт шинжилгээ хийж, зэрлэг ан амьтан, ургамал, нүүдлийн шувуудыг хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэхээр заасан нь энэ салбарт хөрш гүрнүүдтэй гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн үндэс суурийг тавьжээ.

Улаанбаатар хотноо 1990 онд үзэглэсэн “БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, 1994 онд Улаанбаатар хотод байгуулсан “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” зэрэг байгаль орчин, зэрлэг ургамал, амьтныг хамгаалах чиглэлийн суурь гэрээ батлагдсан байна.

Эдгээр гэрээнүүд нь Олон улсын гэрээний тухай Венийн конвенц, 2016 оны Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 5 дугаар зүйлд заасан олон улсын хоёр талт гэрээний хууль зүйн техникийн болон агуулгын стандарт, зарчмыг бүрэн хангасан чухал ач холбогдол бүхий баримт бичиг гэж үзэх үндэстэй юм.

Гэвч эдгээр баримт бичгийг Талууд хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, бараг 20 гаруй жил завсарласан нь судалгааны явцад харагдаж байна. Жишээ нь 2010 онд Улаанбаатар хотод байгуулсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ байгуулагдаж, Монгол Улсын Гаалийн Ерөнхий газар болон БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хооронд хууль бусаар хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Бээжин хотноо үзэглэжээ. 1993 онд Улаанбаатар хотноо байгуулсан Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр, 2010 оны 6 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар хоорондын 1993 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын протокол”, Улаанбаатар хотноо 2011 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан “Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр”-ийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор харилцан тохиролцжээ. Үүнээс үзэхэд 1993 оны хэлэлцээрийг 2010 оны орчим хэрэгжүүлэхээр тохиролцсон нь үүний тод жишээ болж байна. 2010 оноос өмнө ганц нэг салбарын уулзалтыг эс тооцвол ОХУ, БНХАУ-тай байгаль хамгаалах, зэрлэг ургамал, амьтныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх хамтын ажиллагааны орон зай орхигджээ. Энэ нь нэг талаас үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй, тухайлбал хар тамхи, зэр зэвсэг, хүн худалдаалах, терроризм гэх

<sup>4</sup>[http://www.mfa.gov.mn/?page\\_id=25999/](http://www.mfa.gov.mn/?page_id=25999/) Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал/ Монгол Улсын Их хурлын тогтоол. Дугаар 10. 2011 оны 02 сарын 10 өдөр. Улаанбаатар хот



зэрэгтэй тэмцэх олон улсын чиг хандлага давамгайлсан; нөгөө талаас нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал зэрэг объектив субъектив хүчин зүйл нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

1993-2010 хүртэл автомашин, спирт, ноолуур, тарваганы арьс зэрэг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг зонхилж байсан бол 2010-аад оноос алт, үнэт болон хагас үнэт чулуу, хар тамхи, мансууруулах бодис, зэрлэг ургамал, амьтдын эд эрхтэн, мах, арьс зэргийг их хэмжээгээр хил давуулан худалдах, хилийн цаана түүний эрэлт хэрэгцээ нэмэгдэх болсон нь байгаль орчин, зэрлэг ургамал амьтныг хамгаалах журмын эсрэг гэмт явдалтай тэмцэх асуудал түр орхигдож, түүний өсөх нэг шалтгаан болсон гэж үзэх үндэс байна.

Судалгаанаас үзэхэд зэрлэг амьтан ургамал хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн ихэнх нь хувь нь БНХАУ-тай хил залгаа аймгуудад илэрч байгаа нь сонирхол татаж байна. ОХУ-тай хил залгаа аймгуудад энэ төрлийн гэмт хэрэг нутгийн гүнд үйлдэж, энэ гэмт хэрэг БНХАУ-ын хил дээр илэрч байна.

ОХУ-ын хил дээр энэ төрлийн гэмт хэрэг цөөн илэрч байгаа нь нэгдүгээрт, хилийн хамгаалалтын цоорхой их, ой хөвч шууд залгасан, нөгөө талаас ОХУ-ын хил залгаа нутгууд ховор амьтан ургамал ихтэй учраас эрэлт хэрэгцээ бага байж болох юм. Харин ОХУ, БНХАУ нь шууд хиллэдэг учир гэмт этгээдүүд гуравдагч орноор дамжуулан зэрлэг амьтан ургамал, түүний эд эрхтэн, бэлдэцийг нэвтрүүлэхэд эрсдэл ихтэй, сонирхол бага зэргээс үүдэлтэй гэсэн дүгнэлтэд байна.

1990 оны “БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, 1994 оны “Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр” зэрэг тулгуур гэрээг хэрэгжүүлэхэд Засгийн газрын зөвшөөрлөөр түүний яам агентлагуудын хооронд байгуулсан салбарын гэрээ, хөтөлбөр, хамтын ажиллагааны төлөвлөгөө чухал үүрэгтэй билээ.

Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам болон ОХУ-ын Дотоод хэргийн яам хоорондын хэлэлцээрийг 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдөр Улаанбаатар хотод байгуулжээ. Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулалттай үндэстэн дамжсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг олж тогтоох, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон бөгөөд үйл ажиллагааны нэг үндсэн чиглэл нь өмчийн эсрэг, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх практик үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгсөн байна. Гэмт хэрэг үйлдэхээр бэлдэж буй эсхүл гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдолтой хүмүүсийн талаар мэдээлэл, солилцох, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах хүсэлтийг биелүүлэх, оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах гэх зэрэг эрүүгийн процессын тодорхой ажиллагааг харилцан гүйцэтгэхээр тохирсон байна.

2017 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо “Хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Эрүүгийн цагдаагийн алба болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын өөртөө засах орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхим хоорондын ойлголцлын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан. Тодорхой төрлийн зарим гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, туршлага солилцох агуулгатай байна.

Товч дүгнэхэд ОХУ-ын ДЯЯ, Монгол Улсын ХЗДХЯ-ны хамтын ажиллагаа шууд процессын хэлбэрээр хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой байхад, харин Монгол Улсын ХЗДХЯ, БНХАУ-ын НАХЯ-ны хамтын ажиллагаа зөвхөн мэдээлэл солилцох, туршлага судлах, сургалт зохион байгуулах төдийгөөр хязгаарлаж байна.

Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын Гаалийн цагдаагийн газар 2017 оны дугаар сарын 16 өдөр Улаанбаатар хотноо үзэглэсэн “Гаалийн асуудлаар 2018-2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө” батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу Талууд хил дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр хамтарсан ажиллагаа зохион байгуулах хүрээнд тодорхой нэг төрлийн хэрэг зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагааг 2019 оноос зохион байгуулахаар заасан нь байгаль орчин, зэрлэг ургамал аймгийн эсрэг гэмт явдалтай тэмцэх хамтын ажиллагааны нэг шинэ хуудас нээсэн хэрэг болж байна. Энэ талаараа дотоод хэргийн байгууллагуудаас алхам урагшилсан хэрэг мөн.

2010 онд Улаанбаатар хотод байгуулсан Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын засгийн газар хоорондын гэрээний 24 дүгээр зүйлд зааснаар: “Талууд хил зөрчих, хил орчмын нутагт хууль бусаар оршин суух, хөдөлмөр эрхлэх, контрабанд хийх, хар тамхи, мансууруулах бодис, хориотой барааг худалдах, тээвэрлэх зэрэг хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран

тэмцэхэд чиглэсэн хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ. Талууд болон Талуудын эрх бүхий байгууллага энэ талаар холбогдох хэлэлцээр байгуулж болно” гэжээ.

### **Дүгнэлт**

1. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах Ерөнхий газар нь БНХАУ, ОХУ-ын хил хамгаалах байгууллагуудтай хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зэрлэг амьтан, ургамалын хууль бус худалдаа, ан агнууртай холбоотой гэрээг өнөө хүртэл байгуулаагүй нь учир дутагдалтай байна.

2. Монгол-Оросын гэрээ нь хөтөлбөрийн шинж давамгайлсан дэлгэрэнгүй, Монгол-Хятадын гэрээ нь суурь зарчим, ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон тунхагийн шинж давамгайлсан онцлог ажиглагдаж байна.

### **Зөвлөмж**

Монгол Улсын Засгийн газар нь байгаль орчин, зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд дараа арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

1. Монгол Улс нь 1998 оны “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тухай Аархус конвенц”-д нэгдэн орох шаардлагатай байна. Учир нь иргэд байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шаардах эрхээ мэдэхгүйгээс байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд өөрсдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөхгүй байх, улмаар иргэдийн байгаль орчны талаар мэдлэггүйн улмаас энэ талаар гэмт хэргийн субъект болох хандлага шүүхээр шийдвэрлэгдэж буй болон ЦЕГ, ГЕГ, МХГ-аас илрүүлсэн хэргийн материалаас харагдаж байна.

2. Монгол Улсын Засгийн газар, холбогдох яам агентлагууд нь БНХАУ, ОХУ-ын адил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг шинэчлэн байгуулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах замаар зохих шат түвшинд байгуулж, хамтын ажиллагааны практик алхамуудыг хийж эхлэх, мөн ХЗДХБ, Гаалийн байгууллагуудын хамтын ажиллагааны эрх зүй, зохион байгуулалт, санхүүгийн хувьд нэгдмэл (зэрлэг амьтан ургамалыг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх салбар дундын комисс) тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

### **Санал**

1. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд, хоёр болон гурван талт гэрээ, хэлэлцээрүүд, УИХ-ын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан 2007-2021 онд 2 үе шаттайгаар хэрэгжих “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын стратегийн зорилтыг шийдвэрлэх, зэрлэг ургамал, амьтны аймгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэхэд цагдаа хил тагнуул, гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллага дангаараа, эхүл тэдний хамтын ажиллагаагаар хязгаарлахгүй, мөн орон нутгийн төрийн болон өөрөө удирдах ёсны байгууллага, олон нийтийн байгууллага, ард иргэдийн өргөн дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна.

2. “Байгаль орчин, зэрлэг ургамал, амьтаныг хамгаалах журмын эсрэг гэмт явдлыг урьчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

3. Хөрш зэргэлдээ орнуудын манай улстай хиллэж байгаа бүс нутгийн болон манай улсын хил орчмын, аймаг сум, орон нутгын онцлогт тохирсон урьчилан сэргийлэх арга хэмжээг төр, захиргааны болон олон нийтийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

4. Турк-Гүржийн туршлагаар хилийн болон гаалийн нэгдсэн хяналтын тогтолцоог “нэг хил-хоёр улс” зарчмаар бүрдүүлж, хоёр улсын нэг боомтын хяналтанд шилжүүлэх;

5. Монгол Улсын ХЗДХЯ, БНХАУ-ын НАХЯ-ны хооронд хамтран ажиллах харилцан ойлголцлын 2011 оны санамж бичгийн Хамтын ажиллагааны чиглэл гэсэн 3 дугаар зүйлд: “Хил дамнасан, зохион байгуулалттай хэрэг зөрчилтэй тэмцэх чиглэлээр талуудын хил залгаа боомтууд дээр нэгдсэн удирдлага, төлөвлөгөө бүхий хамтарсан ажиллагаа тодорхой төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулах” гэж нэмэх.

### **Ашигласан эх сурвалж**

#### **Нэг. Хууль тогтоомж**

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Амьтны тухай хууль. 2012
- Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт тухай хууль. 2002
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль.

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль. 2012
- Байгалийн ургамлын тухай хууль. 1995
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай. 2012
- Гаалийн тухай хууль. 2008
- Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай. 2002
- Зөрчлийн тухай хууль. 2017
- Эрүүгийн хууль. 2015

**Хоёр. Олон улсын гэрээ, конвенц**

- Биологийн олон янз байдлын тухай конвенц .1993
- Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц. 1999
- Зэрлэг амьтдын ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц. 1996
- Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг, ялангуяа усны шувуу олноор амьдардаг орчны тухай Рамсарийн конвенц .1997
- Халим агнуурыг зохицуулах тухай олон улсын конвенц. 2002
- Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн биоаюулгүй байдлын тухай Картагены протокол. 2003
- Ургамал хамгааллын тухай Ромын конвенц. 2009
- “Байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх тухай конвенц. 1998

**Гурав. Үзэл баримтлал**

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ.,2008
- Амьтан хамгаалах тухай хөтөлбөр УБ., 2008
- Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2002
- Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр УБ., 2008
- Халиу бугын үндэсний хөтөлбөр УБ., 2000
- Засгийн газраас Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр 1996
- Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааны хөтөлбөр УБ., 2002
- Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2003
- Монгол орны цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2005
- Монгол бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2007
- Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2011
- Тул загас хамгаалах үндэсний хөтөлбөр УБ., 2007

**Дөрөв. Судалгааны ажил, тайлан**

- Дэлхийн Байгаль Хамгаалах Сан /WWF/-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой хүргэх замаар ан амьтдын гаралтай эд зүйлсийн хууль бус худалдааг бууруулах нь (Байгаль орчны шинэчлэл II) гүйцэтгэлийн тайлан. Улаанбаатар хот. 2008
- ЦЕГ-ын МДШШУА, Монгол Улсад 2013-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, УБ, 2018
- М.Эрдэнэбаяр. “Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн байцаах, урьдчилан сэргийлэх онол, арга зүйн асуудал” хууль зүйн докторын диссертаци. УБ., 2015

**Тав. Цахим эх сурвалж**

- <http://www.legalinfo.mn/law/details/11634>
- <http://www.mfa.mn>

## ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Г.Мөнгөншагай*  
*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг хянан*  
*шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч,*  
*цагдаагийн ахмад*

**Товч агуулга:** Дэлхийн инновацийн индексийн үзүүлэлтээр хөгжиж буй улсын ангилалд эрэмбэлэгдэж байгаа улсуудын тухайд мэдээлэл, технологийн аюулгүй байдлаар тэргүүлж байгаа улсуудтай ижил түвшинд мэдээллийн аюулгүй байдлаа хангах нь хүндрэлтэй. Гэхдээ Өрнөдийн болон мэдээллийн технологийн өндөр хөгжилтэй, мэдээллийн аюулгүй байдлын салбарт тэргүүлэгч АНУ, ОХУ, БНХАУ, Англи зэрэг улс ч цахим гэмт хэрэг болон цахим халдлагаас ангид бус, манай улстай нэгэн адил энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах талаар сорилтуудтай тулгарч байна.

Энэ өгүүлээр Монгол Улсад цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг хөндөж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Цахим орчин, цахим гэмт хэрэг, мэдээллийн аюулгүй байдал, эрх зүйн зохицуулалт.

### Удиртгал

Сүүлийн жилүүдэд нийгэм бүхэлдээ интернет, мэдээллийн технологи, цахим техник хэрэгслээс хамааралтай болж, нийгмийн хөгжлийг технологийн дэвшилгүйгээр төсөөлөхийн аргагүй боллоо. Нийгмийн олон талт харилцаа болох банк, санхүү, бизнес, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсролын салбар технологийн дэвшилд үндэслэж, маш олон давуу байдал, боломжийг олгосоор байна. Цахим буюу кибер гэмт хэргийн нэгдсэн тодорхойлолт өдийг хүртэл гараагүй байна. Энэ нь магадгүй техник, технологийн үсрэнгүй, хурдацтай хөгжилтэй холбоотой. Манай улсын тухайд цахим гэмт хэрэг гэдэгт “Компьютер, мэдээлэл, интернетийн сүлжээ ашиглан цахим орчинд үйлдсэн бүх төрлийн гэмт үйлдэл”-ийг ойлгосоор ирсэн. Цахим гэмт хэргийг нь дараах байдлаар ангилж болохоор байна. Үүнд: Хувь хүний эсрэг (вирус, залилан, фишинг, спэм г.м), өмчлөх эрхийн эсрэг (бусдын эд хөрөнгийг сүйтгэх, хортой програм тараах г.м), төрийн эсрэг (кибер терроризм, мэдээллийн дайн).

Монгол Улс анх 1994 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр 3 компьютерыг интернетийн сүлжээнд холбон, дэлхийн мэдээллийн сүлжээнд /WWW/ орсон ба 1996 онд интернет хэрэглэгчдийн тоо 500 орчим байсан байна.<sup>5</sup> Энэхүү үйлчилгээ манай улсад анх нэвтэрчээс хойшхи 20 жилийн хугацаанд интернет хэрэглэгчдийн тоо тасралтгүй өссөхийн зэрэгцээ мэдээллийн технологи, интернетийн ололт, давуу талыг ашиглан цаг хугацааг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг өөрчлөлт нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөжиж байна.

2018 оны Олон улсын хүн амын тооллогын судалгаагаар манай улс 3.2<sup>6</sup> орчим сая хүн амд хүрсэн. Мөн Олон улсын хэмжээнд интернет статистикийн талаар судалгаа хийдэг байгууллагаас хийсэн судалгааны дүнгээс үзэхэд, манай улсын нийт хүн амын 64.1<sup>7</sup> хувь нь интернетийн хэрэглэгч гэсэн үзүүлэлтийг олон улстай харьцуулахад өндөр үзүүлэлтэд тооцогдоно. Өөрөөр хэлбэл, 3 хүн тутмын 2 нь интернетийн сүлжээг ашиглаж байна.

Интернет хэрэглэгчдийн тоог одоогоос 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 22-25 хувиар<sup>8</sup> огцом өссөн үзүүлэлттэй байна. Мөн энэхүү байгууллагын судалгаанаас харахад, 2000 онд манай улсын хэмжээнд 30.000 интернет хэрэглэгч байсан бол 2018 оны байдлаар 2.500.000<sup>9</sup> хэрэглэгчтэй болтол өсчээ. Интернетийн хэрэглээ эрс нэмэгдэж, амьдралын олон төрлийн хэрэглээг иргэд болон аж ахуй нэгж, байгууллага интернетийн сүлжээ ашиглан эрхлэн явуулдаг болсон. Тухайлбал, Монгол банкаас гаргасан судалгаагаар, 2017 оны эхний улирлын байдлаар 1.122.833 онлайн банкны үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотын

<sup>5</sup> Л.Цогтбаяр, “Компьютер мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, чиг хандлага” ХСИС, ЭШ-ний эмхэтгэл, УБ, 2012 он.

<sup>6</sup> Монгол Улсын үндэсний статистикийн хороо, <https://www.nso.mn/>

<sup>7</sup> Монголын Харилцаа, Холбооны зохицуулах хорооны тайлан, <http://www.crc.gov.mn/k/2C3/23>

<sup>8</sup> Л.Цогтбаяр, “Компьютер мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, чиг хандлага” ХСИС, ЭШ-ний эмхэтгэл, УБ, 2012 он

<sup>9</sup> Монголын Харилцаа, Холбооны зохицуулах хорооны тайлан, <http://www.crc.gov.mn/k/2C3/23>

хэмжээнд байрлах 110 ширхэг нийтийн лавлагаа мэдээллийн “ТҮЦ” машинаас 34.073<sup>10</sup> ширхэг лавлагаа авсан тоон үзүүлэлтийг мөн онд Үндэсний мэдээллийн төвөөс гаргажээ.

Олон улсын мэдээлэл, цахилгаан холбооны байгууллага нь /ИТО/ дэлхийн 166 улсын мэдээлэл, технологийн салбарын аюулгүй байдал ба цахилгаан утас, компьютер, интэрнетийн хэрэглээ зэргийг 11 үзүүлэлтээр тодорхойлж, үнэлж, дүгнэдэг ба 2017 онд Ирланд улс 8.98 оноогоор дэлхийн 166 орныг тэргүүлсэн ба манай улсын тухайд 4.96 оноогоор 91-т<sup>11</sup> эрэмблэгдсэн байна.

Интэрнетийн сүлжээ болон мэдээллийн технологийн ололт амжилт нь хил хязгаар, газар нутгийн саад бэрхшээлийн тухай ойлголтыг нэг мөр үгүйсгэхийн зэрэгцээ эдийн засаг, мэдээлэл, бараа бүтээгдэхүүний асар өргөн шилжилт хөдөлгөөн, үйлчилгээний хил хязгааргүй орчин гэх зэрэг маш олон давуу байдлыг интэрнет орчинд хүн бүрт бий болгосоор байна. Нөгөөтэйгүүр, технологийн ололт амжилт нь гэмт хэрэгтнүүдэд маш олон шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэх боломж, нөхцөлийг бий болгож байна. Тухайлбал: оюуны өмчийг хууль бусаар тараах, интэрнет луйвар, цахим шуудангийн луйвар, бусдын нэр төрийг гутаан доромжлох, нэр хүндэд халдах, секс сүрдүүлэг, бага насны хүүхдийн садар самуун материал, зохисгүй агуулгатай мэдээлэл түгээх гэх зэргийг нэрлэж болно.

Цахим гэмт хэргийн цар хүрээ, гаралтын хурд, хил хязгааргүй олон үндэстэн дамнасан зэрэг үндсэн онцлог шинжүүд нь одоогийн хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хувьд онлайн ертөнцөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр өөрсдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага, маш том сорилт бий болж байгааг харуулж байна.

### **Цахим гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал**

Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд сүүлийн жилүүдэд гэмт хэрэгтнүүд түүнийг ихээхэн хэмжээний ашиг, орлого олдог хууль бус бизнес болгон өргөжүүлж байна. Кибер буюу цахим гэмт хэрэг нь манай улсын хувьд шинэ төрлийн хэрэг ба “Цахим” гэсэн нэр томъёогоор 2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчилсан. Цахим гэмт хэргийн тухай ойлголт нь маш өргөн хүрээтэй учир энэ төрлийн гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх талаар одоог хүртэл нэг мөр ойлголтод хүрээгүй, цахим гэм хэрэг гэсэн ойлголтод “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах”, “Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах”, “Хор хөнөөл программ хангамж бүтээх, ашиглах, тараах”, түүнчлэн цахим мэдээллийн сүлжээ ашиглан үйлдэгдэх “Хувь хүний нууцад халдах”, “Бусдыг мөрдөж мөшгөх”, “Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах”, “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах”, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих” зэрэг багтана.

Цахим гэмт хэргийг бүх насны иргэд үйлдэж байгаа боловч ихэнх тохиолдолд өсвөр насны хүүхдүүд байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. Манай улсын хувьд цахим гэмт хэргийн “Мөсөн уул”-ын зөвхөн орой хэсэг нь зухуйж байна гэж ойлгож болно.

Цахим гэмт хэргийг дараах төрлийн гаралт манай улсын хэмжээнд өсч байна. Үүнд:

2.1.Банкны салбар дахь цахим гэмт хэрэг: Энэ салбарын мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтын систем нь харьцангуй сайн. Учир нь банкууд энэ төрлийн хэрэгтнүүдийн гэмт үйлдлийн арга, тактикийг судалж, тэдний гэмт халдлагаас үйлчлүүлэгчдийн хувийн мэдээллийг алдагдахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнүүдийг авсаар байгаа хэдий ч цахим гэмт хэрэгтнүүд амжилттайгаар халдлагаа хийж гүйцэтгэж, өөрсдийн хүсэл зорилго биелүүлсээр байгаа нь харамсалтай. Манай улсын тухайд цахим гэмт хэрэгтнүүд банкны харилцагчдын хувийн мэдээллийг олж аван, улмаар дансан дахь мөнгийг нь луйвардах зорилготой гэмт хэргийн гаралт тасралтгүй өссөөр байна.

2.2.Фишинг: Энэ төрлийн цахим халдлага нь манай улсад маш хурдацтай өсч байна. Уг халдлага нь цахим халдлагуудын хамгийн энгийнх нь боловч асар их хор хохирол учруулдаг. Энэ гэмт халдлагын гол зорилго нь тухайн бай болгож буй хүнийг цахим хуудсанд зочилсон тохиолдол бүрт нь хувийн мэдээллийг нь хулгайлж цахим гэмт халдлагынх хохирогч болгодог. Энэ нь хэрэглэгчтэй холбоотой чухал мэдээллийн сэжүүрийг илэрхийлэх гол зэвсэг болгон ашиглан, ямар нэгэн тоног төхөөрөмжөөр дамжуулан, ямар нэгэн зүйл татаж авах болгонд хортой програм хэрэглэгчид рүү явуулдаг байна. Хэрэглэгчийн санхүүгийн өгөгдөл мэдээ, мэдээллийг хулгайлахын тулд фишингийн аргыг ашигладаг нь кибер халдлагын талаарх “Kaspersky”компанийн лабораторын судалгаанаас илэрхий болжээ<sup>12</sup>.

<sup>10</sup> Үндэсний Дата төв, ТҮЦташины үйлчилгээ, <https://datacenter.gov.mn/>

<sup>11</sup> Олон Улсын Цахилгаан холбооны хороо, Мэдээлэл, технологийн хөгжлийн үзүүлэлт, 2017 он, <https://www.itu.int/net4/itu-d/idi/2017/index.html>

<sup>12</sup> Касперскийн лабораторын тайлан, 2015 он.

2.3.Оюуны өмчийн хулгай: Оюуны өмчийг хамгаалах талаархи иргэдийн эрх зүйн мэдлэг хангалтгүй байна. Үүнд зохиогчийн эрх болон түүнд хамаарах бүтээлийг зөвшөөрөлгүй хууль бусаар хуулбарлан нийтлүүлсэн, илгээсэн, борлуулсан ойлголтууд хамаарна. Тухайлбал: Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээл болох ном, зохиол, кино, дуу, видео-дүрс бичлэгийн хуурцагыг маш их хэмжээгээр хууль бусаар, зөвшөөрөлгүйгээр хуулбарлан борлуулах, олон нийт мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, илгээх нь энгийн үзэгдэл мэт маш их газар авсаар байна.

2.4.Интернет орчинд садар самуун сурталчлах: Тухайлбал, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүд өөрсдийн дүрээ халхалж, бага насны охидтой фэйсбүүк орчинд танилцах, тэдгээрийн хувийн мэдээллийг цуглуулах, нүцгэн зургийг нь залилан авах, бусдад тараана гэх мэтээр сүрдүүлж мөнгө авах, бэлгийн харьцаанд орох, өөрийн эрхшээлд байлгах замаар бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах тохиолдлууд гарч байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд секс сүрдүүлгийн халдлага өссөөр байна.

2.5.Сошиал цахим харилцаа: Манай улсын интернет хэрэглэгчийн тоо өсч, энэ нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болсноор "Тоон эдийн засаг" бүрдэж эхлэхээр байна. Үүний нэг жишээ нь иргэдийн цахим харилцаа, холбооны хэрэгслүүдээр "сошиал медиа" дамжин нийгмийн харилцааны шинэ хэлбэр бүрэлдэж, бүх төрлийн банк, санхүүгийн үйлчилгээ онлайн хэлбэрт шилжин, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлчилгээ авч, гар утаснаасаа бүхий л төрлийн үйлчилгээг авдаг, мөн хянадаг болоод байна. Шинэ хэрэглээ үүссэнтэй холбогдон шинэ хэрэглээний соёлыг бүрдүүлэх, түүний аюулгүй байдлыг хангах зэрэг олон сорилт бидний өмнө тулгараад байна.

Харилцаа холбооны цахим хэрэгсэл болох фэйсбүүк, твиттер, инстаграм, линкид-ин зэрэг сайтууд нь гэмт хэрэгтнүүдэд шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэх маш их боломж олгосоор байна. Эдгээр сайт нь манай улсын зүгээс шууд зохицуулалт хийх боломжгүй, гадаад улсад сервертэй системийг ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд тодорхой хүндрэлүүд бий болгодог.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, Дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд 2017 онд 362, 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 409 кибер гэмт хэрэг бүртгэгдсэн тоон үзүүлэлтийг 2016 онд бүртгэгдсэн 136<sup>13</sup> хэрэгтэй харьцуулахад 3 дахин нэмэгджээ. Мөн мэдээллийн аюулгүй байдал, цахим орчинтой холбоотой 395 гомдол, мэдээллийг 2016 онд хүлээж авч шалгаж байсан бол 2017 онд 416, 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 547<sup>14</sup> гомдол мэдээлэл гаргасан нь нэг талаас иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын болон интернетийн зохистой хэрэглээний талаархи мэдлэг, цахим гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт нэмэгдэж байна гэж үзэж болно.

Сүүлийн жилүүдэд интернетийн орчинд компьютер болон бусад технологийн хөнгжлийг ашиглаж үйлдсэн гэмт хэргүүдийн талаарх ойлголтын зөрүүтэй байдал нь шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын шатанд харилцан адилгүй байгаагаас шалтгаалан цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэх хэргийг бусад төрлийн гэмт хэргээр зүйлчлэх тохиолдолууд ихээхэн гарч байна. Тухайлбал: интернет банк руу халдсан гэмт хэргийг хулгайлах гэмт хэрэг, цахим хэрэгсэл ашиглан иргэдийн хувийн мэдээллийг хууль бусаар олж авч, итгэл үнэмшлийг нь төрүүлж, залилсан, эсвэл мөнгөн гүйлгээ, шилжүүлэг хийсэн гэмт хэргийг залилангийн гэмт хэрэг гэх мэтээр бүртгэн шалгаж, шүүхээр шийдвэрлэж байна. Энэ нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийн статистик тоон үзүүлэлт бодитой бус гарч байгаа шалтгааны нэг маргаангүй мөн. Үүнээс гадна, энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд аргаар интернет орчинд үйлдэгддэг ба зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт дээр тулгуурлаж, тодорхой урьдчилан сэргийлэх, тэмцэх ажиллагаа хийх нь учир дутагдалтай. Цагдаагийн байгууллага нь жилд дунджаар 400-500 орчим цахим мэдээлийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг тоон үзүүлэлт байдаг ба үүнээс дийлэнх хувь нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинжгүй болох нь тогтоогдох, зарим ярлах дүгнэлт үйлдүүлэх саналтай хүргүүлсэн хэргүүд нь шүүхэд шилжихээс өмнө прокурорын хяналтын шатанд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх зэрэг байдал ажиглагдлаа.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үйл хэрэгт иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагаа маш чухал. Энэ төрлийн гэмт хэргийн гаралтын тоон үзүүлэлтийг бодитойгоор гаргах нь чухал ач холбогдолтой. Энэ төрлийн гэмт хэргийг холбогдох хуулийн байгууллагад бүртгүүлэхгүй байх хэд хэдэн шалтгааныг дурьдвал: иргэд энэ

<sup>13</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, Дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны гэмт хэргийн тоо мэдээ, 2018 он.

<sup>14</sup> Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, Дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны гэмт хэргийн тоо мэдээ, 2018 он.

төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт дутмаг, интернэт орчин дахь хувийн анхаарал, болгоомж хангалтгүй, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон тухайгаа ч мэддэггүй, зарим тохиодолд мэдсэн ч холбогдох хууль хяналтын байгууллагад бүртгүүлдэггүй, хаана ямар байгууллага дээр бүртгүүлэх талаар ойлголт байхгүй, тодорхой хувь нь хууль хяналтын байгууллагад бүртгүүлж асуудлаа шийдвэрлүүлэх хүсэл эрмэлзэлгүй, хууль хяналтын байгууллагын зүгээс тодорхой арга хэмжээг түргэн шуурхай, цаг алдалгүй авч өгнө гэдэгт итгэлтэй бус, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын чиг үүрэг өөр байдаг зэргээс шалтгаалан, хамтын уялдаа холбоо тааруу, иргэдийг нэг байгууллагаас нөгөө алба нэгжрүү явуулж хүндрэл чирэгдэл их учруулдаг зэрэг нөхцөл байдал нөлөөлдөг гэж үзэх үндэслэлтэй.

Мөн дээрхээс гадна, аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа банк бус санхүүгийн байгууллага болон бизнесийн салбарынхан энэ төрлийн гэмт хэргийн халдагд өртөж хохирсон хэдий ч байгууллагын нэр хүнд, үйлчлүүлэгч, харилцагчийнхаа мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээллийг хамгаалах үүргээ гүйцэтгэж чадаагүй байдлаа ил гаргаж нийтэд мэдээлж чаддаггүй. Учир нь үйлчлүүлэгч, харилцагчийн итгэлийг алдах, улмаар хэрэглэгч, үйлчлүүлэгч, харилцагчаа алдах эрсдэлтэй гэж тооцож тодорхой халдлага болсон баримт, үйлдлийг нуун дарагдуулдаг.

Судлаачдын үзэж байгаагаар, бодит байдал дээр цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт нь одоо бүртгэгдсэн байгаа 400-500 орчим хэргээс 5-10 дахин илүү үйлдэгдэж байгаа, ойролцоогоор 2000 орчим ноцтой төрлийн цахим мэдээллийг аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдэж байгаа гэж тооцсон байна.

Цахим мэдээллийг аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх талаарх нэгдсэн нэг мөр ойлголт дутмаг, мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнийг бодлогоор сургаж бэлтгэх зэрэг асуудал нь нийгмийн шаардлага болж байна.

Манай улсын нөхцөлд цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгаж, прокурорын хяналтад шилжүүлнэ гэдэг маш их хүндрэл, бэрхшээлтэй. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэг нь уламжлалт гэмт хэргийг мөрдөн шалгах аас эрс ялгаатай. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгахад тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийн заримаас дурьдвал: энэ төрлийн гэмт хэрэг нь олон улсын хэмжээнд хууль сахиулах байгууллагуудыг хамтарч ажиллахыг шаарддаг, тодорхой нэр бүхий орнуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан, хамтарч ажиллах эрх зүйн орчин бүрдсэн боловч улс орнууд хоорондын мэдээ, мэдээлэл дамжуулах, хамтын ажиллагаа нь маш муу, хангалтгүй, энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг этгээдүүд нь дэлхийн аль ч улс орноос интернетийн сүлжээ ашиглан цахим халдлага хийх боломжтой, гэмт хэргийн нотлох баримтыг бүрдүүлэхэд мөрдөгчөөс мэргэжлийн өндөр ур чадвар шаарддаг, зарим тохиолдолд прокурор, шүүхээс биелэгдэшгүй ажиллагаа хийхийг даалгадаг, хууль эрх зүйн зохицуулат нь техник, технологийн хөгжлийн ард нь үргэлж хоцорч явдаг, гадны улсын гэмт хэрэгтнүүд нь ерөнхийдөө зохион байгуулалттай бүлгийн хэлбэрт шилжсэн, мөрдөгч нараас компьютер, мэдээллийн технологийн өндөр мэдлэг, мэргэжлийн ур чадвар шаарддаг зэрэг олон олон хүндрэлийг дурьдаж болно. НҮБ-ын 2014 оны тайлангаас үзэхэд: дэлхийн хэмжээнд үйлдэгдэж байгаа цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 80%<sup>15</sup>-ийг зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлддэг болохыг дурьджээ.

### **Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй эрх зүйн орчин**

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа баталж, Монгол Улсын иргэн хүний үндсэн эрхийг баталгаажуулсан. 1994 онд 9 багц асуудлаар “Үндэсний аюулгүй үзэл баримтлал”-ыг баталсан бол 2010 онд шинэчлэн 6 багц асуудлын хүрээг хамааруулан баталсан.

Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор 4 багц асуудлаар “Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр” батлагдаж, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг хэсэг кибер орчны аюулгүй байдлыг хангах, хамгаалах хүрээнд Тагнуулын ерөнхий газрын харьяанд “Кибер аюулгүй байдлыг хамгаалах газар”, мөн Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”-ийг байгуулж, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хэргүүдийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Манай улсын тухайд Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2011 онд баталсан “Тоон контентийн үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, Монголын вэб сайтуудын холбооноос батлагдсан “Вэб сайт эрхлэгчдэд тавигдах нөхцөл шаардлага” зэрэг

<sup>15</sup> НҮБ-ын тайлан 2017 он, <http://www.unodc.org/>

цөөхөн тооны эрх зүйн дагнасан зохицуулалт байгаа боловч “Төрөөс мэдээллийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлого”-ын баримт бичиг, “мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий хууль” бусад салбар хууль, “Оюуны өмчийн зохицуулалт”, “Сөрөг контентийн зохицуулалт”, “Мэдээлэл авах эрх, нууцын зохицуулалт” зэрэг олон зохицуулалт шаардлагатай байна.

Эрүүгийн эрх зүйн системд Эрүүгийн хууль онцгой үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Өнгөрсөн жилүүдэд манай улсын Засгийн газар цахим орчин дахь компьютер, мэдээлэл технологийн салбарын хэрэглэгчид өсөхийн зэрэгцээ цахим халдлагын тоо өсч байгааг анхаарч, 1996 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд “Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 11 дүгээр бүлгийг анх удаа хуульчилж өгсөн байна<sup>16</sup>. Үүний дараа 2002 оны Эрүүгийн хуульд “Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 25 дугаар бүлгийг хуульчилж<sup>17</sup> мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд эрх зүйн хамгаалалттай болсон хэдий ч энэ нь өнөөгийн техник, технологийн хөгжил, хүний хэрэглээ болон сэтгэхүйн хөгжлийн шаардлага, агуулгад нэгэнт тохирохгүй болж, 2015 оны Эрүүгийн хуульд “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэсэн 26 бүлгийг хуульчилсан байна.<sup>18</sup>

### Дүгнэлт

Эрх зүйн орчинд тодорхой зохицуулалт, өөрчлөлт, шинэчлэлтийг хийсээр байгаа хэдий ч эдгээр нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгахад хангалттай бус байна. Цахим гэмт хэрэг нь албан ёсоор үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл болсон төдийгүй, олон улсын хэмжээнд анхаарал татсан, асар их хор уршиг дагуулсан, шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлыг нэг болжээ. Энэ төрлийн гэмт хэрэгтэй ганц улс дангаараа тэмцэх боломжгүй болохыгэнэ төрлийн гэмт хэргийн статистик тоон үзүүлэлт болон эрдэм шинжилгээ, судалгааны олон ажил илтгэсээр байна.

Судалгаанаас үзэхэд, манай улсын 12-оос дээш насны нийт хүн амын 60 хувь нь өдөр бүр интернэтэд холбогдож байгаа нь цаашид энэ төрлийн гэмт хэрэгт өсвөр насны хүүхдүүд ихээр татагдан орох мөн энэ төрлийн гэмт хэргийн золиос болж хохирогч болох магадлалтай байна. Энэ улс орны ирээдүй болсон өсвөр насны хүүхдүүдийн эрх зүй, цахим орчин дахь боловсрол, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг нэмэгдүүлэх нийгмийн шаардлага байна.

Цахим гэмт хэргийн шинж, цар хүрээ, хурд зэрэг нь дэлхийн улс орнуудыг хамтын ажиллагаагаа ахиулж, идэвхжүүлэхийг шаардаж, анхааруулсаар байна. Иймд манай улс тэр дундаа Хууль сахиулахын их сургууль нь энэ салбарын ирээдүйн чадварлаг хүний нөөц бэлтгэх чиг үүрэгтэй их сургуулийн хувьд бусад орны цагдаагийн сургууль болон энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, байгуулсан орнуудтайгаа хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, тухайн улсуудын цахим гэмт хэргийг мөрдөн шалгах тактик, арга зүйд багш, мөрдөгч нарыг суралцуулж, чадварлаг, мэргэшсэн багш, мөрдөгч, мэргэжилтэн бэлтгэх талаар хамтран ажиллах тал дээр идэвх санаачлагатай байх нь зайлшгүй болоод байна. Бусад орны дадлага, туршлага, чадварт багш, мөрдөгч нарыг суралцуулж сургагч багш нарыг бэлдсэнээрээ Олон улсын хэмжээнд цахим гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн нэг ойлголтод хүрч, сургалтын хөтөлбөр боловсруулж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй алба хаагч болон ирээдүйд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхээр суралцаж буй сонсогч нарт түгээх нь чухал юм.

Гадаад, дотоодын хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх нь нэн тэргүүний чухал алхам гэдэг нь маргаангүй. Хамтын ажиллагааны хүрээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй хэлтсийн алба хаагч, болон Хууль сахиулахын их сургуулийн эрдэмтэн, багш, судлаачдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаадын орны туршлага судлуулах, тодорхой төрлийн хэргийг хэрхэн мөрдөн шалгах, уг ажиллагааны үе шат, арга тактик, цахим нотлох баримтыг хэрхэн илрүүлж, бэхжүүлж, шинжилж, үнэлэх гэх зэрэг чиглэлээр сургалт, семинар, практик дадлагыг хамтарч хийхэд Хууль сахиулахын их сургуулийн үүд хаалга үргэлж нээлттэй байх болно.

<sup>16</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 1996 он.

<sup>17</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он.

<sup>18</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015 он.



## ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ОНОГДУУЛАХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨНД “ТАТГАЛЗУУЛАХ ОНОЛ” (DETERRENCE THEORY) -ЫН ҮҮДНЭЭС ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Д.Нямбат

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын хяналтын прокурор,  
хууль цаазын ахлах зөвлөх, докторант

**Товч агуулга:** Хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын үр нөлөөнд “татгалзуулах онол”-ын үүднээс дүн шинжилгээ хийсэн болно.

**Түлхүүр үг:** Эрүүгийн хууль, хулгайлах гэмт хэрэг, ял, криминологийн онол, татгалзуулах, эмээлгэх, эрүүгийн хариуцлага.

### ОРШИЛ

Иргэд бидний эрх, эрх чөлөө, өмч хөрөнгө цаашлаад нийтийн болон үндэсний ашиг сонирхол гэмт халдлагаас хамгаалагдаж чадсан уу?, бид эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдарч, сурч байна уу?, өнөөдрийн байдлаар Эрүүгийн хуулийн дээрх зорилго биелсэн үү?, биелэх үү?, нэг бол ямар түвшинд хүрсэний дараа биелсэн гэж үзэх бэ?, тийм шалгуур үзүүлэлт бий юу?, эсвэл биелэхгүй байгаа бол яагаад гэсэн олон асуулт урган гарсаар байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах, ялын бодлогоор дамжуулан гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн гэмт хэрэг үйлдэхээс айлган татгалзуулж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байх учиртай. Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байгаа, биелэгдэхгүй байгаа шалтгааныг “хулгайлах” гэмт хэрэг”-тэй холбож дараах байдлаар судаллаа.

### СУДАЛГАА, ҮР ДҮН

УИХ-аас Монгол Улсын үнэт зүйл болсон, үнэ цэнэтэй зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилго бүхий Эрүүгийн хуульд 209 зүйл гэмт хэргийг хуульчилсан боловч хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл “хулгайлах” гэмт хэрэг олон мянгаараа бүртгэгдэж байна. Нэг үгээр хэлбэл, нийт гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь “хулгайлах” гэмт хэргийн түвшингээс шууд хамааралтай байгаа нь анхаарал татаж байна.



#### Зураг1. Хулгайлах гэмт хэргийн түвшин


Графикаас харахад, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшин 2008-2011 онд бага зэрэг буурч, сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэргийн түвшинг өмнөх оны түвшинтэй харьцуулан үзэхэд, 2012 онд 990 хэргээр буюу 18.8 хувь, 2013 онд 1621 хэргээр буюу 25.8 хувь, 2014 онд 540 хэргээр буюу 6.8 хувь, 2015 онд 745 хэргээр буюу 8.8 хувь, 2017 онд 3157 хэргээр буюу 34.8 хувиар тус тус өссөн байна.<sup>[1]</sup>

Харин Эрүүгийн хууль /шинэчлэн найруулга/ хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хооронд улсын хэмжээнд хулгайлах гэмт хэргийн 35397 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8390 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх бүр өсч байсан ба 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд мөн л өссөөр байгааг харуулж байна.

Олон удаагийн судалгааны ажлын үр дүнгээс “хулгайлах” гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг:

1. Хүн ам төвлөрсөн, нягтаршил ихтэй газар илүүтэй үйлдэгддэг (Хулгайлах төрлийн гомдол, мэдээллийн 56.7 хувийг Улаанбаатар хотод бүртгэгддэг),
2. Хулгайлах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогын эх үүсвэргүй байдагтай холбоотой (учирсан хохиролын 93.9 хувь нь нөхөн төлөгддөггүй),
3. Бүртгэгдэх үедээ сэжигтэн, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй.

Зураг 2. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг



Улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-ээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд нэг жилийн хугацаанд нийт 1650 хүн хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдснаас 137 буюу 8.3 хувийг эмэгтэй хүн, 1513 буюу 91.7 хувийг эрэгтэй хүн, 199 буюу 12.1 хувийг хүүхэд эзэлж байна. Өөрөөр хэлбэл, цаг хугацаа, гариг, сар нь хулгайлах гэмт хэргийн гаралтад онцгой анхаарал татахаар нөлөөлдөггүй боловч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 10 хүн тутмын 9 нь эрэгтэйчүүд байгаа нь бас л энэ төрлийн гэмт хэргийн уламжлалт онцлог юм.

Харин хулгайлах гэмт хэрэгт оногдуулж байсан одоо оногдуулж болох боломжтой эрүүгийн хариуцлагыг доорх байдлаар харьцуулж үзэж хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэхээс татгалзуулж айлгах, оновчтой тогтоон тэмцэж чадаж байгаа эсэхийг үзье.

### ХАРЬЦУУЛАЛТ

2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйл	2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл
145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл <b>нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</b>	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл <b>зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b>
145.2.Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, <b>машин механизм</b> , тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд <b>нэвтэрч</b> үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин	2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад <b>нэвтэрч</b> ; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

<p>нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, <b>гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b></p>	<p>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, <b>машин механизм</b> ашиглаж үйлдсэн бол <b>хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b></p>
<p>145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг <b>амьдралын эх үүсвэрээс нь салгасан</b> буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшгийг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл <b>таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b></p>	<p>3.1.байнга үйлдэж <b>амьдралын эх үүсвэр болгосон;</b> 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол <b>таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b></p>
<p>145.4.Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, <b>арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</b></p>	

Эндээс үзэхэд, одоогийн Эрүүгийн хуулийн ялын бодлого чангарсан байна. Тодруулбал, 2002 оны Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол 3 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэлтэй байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчоос ялын бодлогоор дамжуулан хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго тавьсан боловч шинэ Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байгааг илтгэж байна.

Түүнээс гадна 2002 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн улмаас 240.000 төгрөгийн хохирол учирсан байхыг шаарддаг байсан бол одоо 300.000 төгрөгөөс дээш хохирол учирсан байхыг шаардаж байна. Хохиролын хэмжээг өсгөж өгсөнтэй холбоотойгоор 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хулгайлах гэмт хэргийн бүртгэгдсэн тоо өссөн байх боломжгүй байна. Нэг үгээр хулгайлах гэмт хэрэг мөн гэж тооцох хохиролын хэмжээг нэмэгдүүлснээр энэ төрлийн гэмт хэргийн тоо өссөн байж болзошгүй гэсэн таамаглал үгүйсгэгдэж байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн сүүлийн хоёр он дамнаж хэрэгжсэн хугацаанд 35397 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол өнгөрсөн 7 жилийн хугацаанд дунджаар жилд 30929 гомдол, мэдээлэл бүртгэж байжээ.

Хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүйсийн харьцаа, үйлдэгддэг цаг, өдөр, гараг гэх мэт шууд болон шууд бус хамаарал бүхий өгөгдлүүд анхаарал татахуйц өөрчлөгдөөгүй мөн нөлөөлөөгүй, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ өдөр тутам цалгардуулалгүйг биелүүлсээр, орчин үеийн техник технологийн шийдэл, шинэ санааг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн тэмцсээр байгаа, эрүүгийн хариуцлагыг чангатгасан хэдий боловч “хулгайлах” гэмт хэрэг яагаад буурахгүй байна вэ?

### ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.Ялтай байдал буюу өмнө нь шийдвэрлэсэн хэргийг сөхөж, ял оногдуулахдаа харгалзан үздэг байдлыг эргэж бий болгосон зохицуулалтыг хулгайлах гэмт хэргийн шинжид тусгаж өгснөөр гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийг гэмт хэрэг үйлдэхээс айлган татгалзуулах боломжтой. Урьд ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш тодорхой хугацаа өнгөрөх хүртэл гэмт хэрэг шинээр үйлдэхгүй байх нь түүнд ашигтай тул түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулж чадах хүчин зүйл нь “ялтай байдал” гэдэг ойлголтыг тусгаж өгөх арга бий боловч энэ нь 2015 оны Эрүүгийн хуульд нэг төрлийн гэмт хэргийг 2 ба түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг давтан үйлдсэн шинжээр нь хүндрүүлэн зүйлчлэхийг хассан шударга ёс, тэгш эрхийн зарчимтай зөрчилдөх тул УИХ-аас давтан гэмт хэрэг, ялтай байдал гэсэн ойлголтуудыг шинэ Эрүүгийн хуульд тусгаж өгөөгүй юм. Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацаа өмнөх Эрүүгийн хуультай харьцуулахад чангарсан боловч энэ нь гэмт этгээдэд нөлөөлөхгүй байна гэсэн үг юм.

2.Эрүүгийн хуульд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах зохицуулалтыг тусгаж өгөхдөө “хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно” гэж үйлдэл тус бүрд ял оногдуулж, ялыг нэмж нэгтгэж нийт эдлэх ялыг тогтоож өгнө гэж зохицуулсан. Жишээ нь: дээрэмдэх гэмт хэргийг хүч хэрэглэн хохирогчид хөнгөн гэмтэл учруулан үйлдсэнийг Эрүүгийн хуулийн 17.2 (дээрэмдэх)+11.6-1(хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах) гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 2 бие даасан гэмт хэрэг гэж давхар зүйлчлэн ял оногдуулж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан “эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчимтай нийцэж байгаа боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Энэ хуулийн тусгай ангид заасан нэг гэмт хэргийн шинжийг хэд хэдэн удаагийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байвал үргэлжилсэн нэг гэмт хэрэг үйлдсэнд тооцно” гэсэн заалтаас шалтгаалж хэрэгжихгүй байна.

Учир нь Эрүүгийн хуулийн гол агуулга болох нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах нь шударга ёсны зарчим гэж заасан, мөн нэг гэмт хэрэгт ял оногдуулсан л бол тухайн ял шийтгүүлсэн байдлыг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж, ялыг хүндрүүлэх нөхцөл байдал болгохгүй байх утга агуулгыг давхар илэрхийлж[1] байгаа боловч хулгайлах гэмт хэргийг 100 ба түүнээс дээш удаа үйлдсэн ч 20 жил, 10 ба түүнээс дээш удаа үйлдсэн ч 20 жил хорих ял оногдуулах нь хууль ёсонд нийцэхгүй, шударга, зөв шийдэл биш байна. Жишээлбэл, уржигдар Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт иргэн А-ыг гэрт нэвтрэн зурагтыг нь, өчигдөр Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт иргэн Б-ийн гражаас тээврийн хэрэгслийг нь, өнөөдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт иргэн С-ийн халааснаас гар утсыг нь хулгайлсан үйлдэл нь цаг хугацааны хувьд тасарсан, өөр өөр газар нутагт үйлдэгдсэн, халдлагын зүйл, хохиролын хэмжээ ялгаатай, бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авахдаа бусдын орон байр, гражид нэвтрэн үйлдсэн учраас хүндрүүлэх шинжтэй боловч гар утасны хулгай нь нэвтрэлтгүй тул хүндрүүлэх шинжгүй, 3 тусдаа хохирогчтой зэрэг олон нөхцөл байдлаас үл хамаарч үргэлжилсэн үйлдэл гэж дүгнэн 3 гэмт хэргийг нэг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хэргүүдийг нэг “малгай”-н дор нэгтгэж шийдвэрлэж байна. Тодруулбал, дээрх 3 үйлдэлд 2-8 жилийн хорих ял, 30 үйлдэлд ч ялгаа байхгүй 2-8 жилийн хорих ял шийтгэгдэж байна.

Тодруулж хэлбэл, Эрүүгийн хуульд нэг гэмт хэрэгт нэг ял шийтгэл гэсэн үзэл баримтлал бий болсон боловч түүнийг хэрэглэх боломжгүй байгаа нь хуулийн мөн чанарыг алдагдуулах, гэмт хэрэгтэнд ял завшуулах, хуулийн байгууллагад зохиомол ачаалал, давхардал үүсгэсэн, хохирсон иргэдийг чирэгдүүлэх, хохирсон дээр нь нэмж хохироох, гэмт хэргийн гаралт буурахгүй байх сөрөг үр дагавар дагуулж байна.

### **ТАТГАЛЗУУЛАХ ОНОЛ (DETERRENCE THEORY)**

Криминологийн шинжлэх ухааны энэ онолыг “эрүүгийн хариуцлагаар эмээлгэх” онол ч гэж орчуулж болох юм. Классик буюу сонгодог онолын гол агуулга нь аливаа хүн үйлдэл хийх, шийдвэр гаргах нь тухайн этгээдийн хийх нь зүйтэй юм, оновчтой юм гэж үзсэн өөрийнх нь чөлөөт сонголт юм. Хувь хүн бүгд хууль тогтоомжоос урган гарч буй боломжит аз жаргалыг хүртэх үү эсвэл зовлогоо зулгаалуулах уу гэдэг эрсдэлээ тооцсоны үндсэн дээр хуулийг сахин биелүүлэх нэг бол хууль зөрчих эсэхээ шийдвэрлэх нь тухайн хүний өөрийнх нь сонголт юм. Гэмт этгээд нь Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн хэмжээ, төрлийг дэнслэхийн зэрэгцээ баригдах эрсдэлээ бас тооцож үзэх ба хэрвээ гэмт этгээд нь хуульд заасан ял шийтгэл нь гэмт хэрэг үйлдэж ашиг хонжоо олохоос илүүтэй намайг зовоох юм байна гэж тооцвол тухайн хүн гэмт хэрэг үйлдэхгүй байх болно.

Иймд Эрүүгийн хуулийн ял шийтгэлийн нэн тэргүүний зорилго бол гэмт хэрэг үйлдэхээс айлгах юм. Улмаар ял шийтгэл нь иргэдийг хууль сахин биелүүлэх сэдлийг өгч байхаас биш хууль зөрчихийг дэмжсэн байж болохгүй. 18 дугаар зууны үед сонгодог онолын гол төлөөлөгчид Чезар Беккари, Жереми Вентон нар ял шийтгэл гэмт хэрэгтээ таарсан байх ёстой гэхээс гадна хатуу ширүүн шийтгэлийг санал болгож байсан юм. Учир нь тэд ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэргээс нь илүү хатуу ширүүн байвал гэмт хэргээс олох олзноос татгалзана гэж үзсэн. Ял шийтгэл нь хэтэрхий хатуу, ширүүн байх нь шударга бус боловч ял шийтгэл нь хатуу байхгүй бол гэмт хэрэг үйлдэхээс татгалзах, айх шалтгаан болж чадахгүй гэж сургасан байдаг.[2]

## ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГААС

*Хүүхэд хулгайлж, хүчиндсэн Ариел Кастро хэзээ ч тэнсэн суллагдах нөхцөлгүйгээр бүх насаараа хорих ял+1000 жилийн ял шийтгүүлээ*[3].

АНУ-д 2009 онд залилах гэмт хэрэгт 150 жилийн, цуврал аллага үйлдсэн этгээдэд 835, 957, 10.0000 жилийн, Испани улсад залилах гэмт хэрэгт 2000 жилийн, 2004 онд Израйлд 63 хүнийг тэсрэх бөмбөгөөр алсан этгээдийг 63 удаагийн бүх насаар нь / 1 удаа нь 25 жилтэй тэнцэнэ/ хорих ял ба дээр нь нэмээд 5200 жилийн, 1996 онд 35 хүнийг алсан этгээдийг 35 удаагийн бүх насаар нь хорих ял дээр нь нэмээд 1035 жилийн хугацаагаар хэзээ ч тэнсэж суллахгүй, эргэлт оруулахгүй нөхцөлтэйгээр хорих ял шийтгүүлсэн олон олон жишээнээс үзэхэд энэ нь гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж түүнийгээ нэмэх хэлбэрээр хүний амьд байх боломжтой биологийн насны хязгаараас хэтэрсэн хугацаагаар ял шийтгэх хэлбэр юм. Яагаад гэвэл түүний үйлдсэн гэмт хэрэг бүрийн ард хохирсон иргэд, гэр бүл нь бий. Энэ нь тэдний эрх ашгийг хохирогч нэг бүрээр хангаж, улмаар цаашдын аюулгүй байдлыг нь хамгаалж байгаа нэг хувилбар юм.

Олон жилийн хугацаагаар хорих ял оногдуулж байгаа бас нэг шалтгаан нь дэлхийн олон оронд эрүүгийн хариуцлагаар эмээлгэх онолын судалгаа олноор хийгдэж үр дүн нь батлагдсан байдагтай холбоотой. Жишээлбэл, судалгаагаар 6-12 сарын хугацаатай хорих ял шийтгэгдсэн этгээд нь 2-4 жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлсэн этгээдээс илүүтэйгээр суллагдаж гарч ирснийхээ дараа дахин гэмт хэрэг үйлддэг гэдгийг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын хугацаа ихсэх тусам дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл буурч байдаг гэсэн үг юм[4]. Манай улсад энэ төрлийн судалгаа хийгдээгүй боловч хууль сахиулах байгууллагын зарим практик ажилтнууд дээрх судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрч, улмаар үнэн эсэх тухай таамаглал дэвшүүлж судалгааны ажлыг эхлүүлээд байна[5].

## ДҮГНЭЛТ

Эрүүгийн хуулийн 209 гэмт хэргийн зөвхөн 1 гэмт хэрэг нь 2015 оны Эрүүгийн хуулийн зорилго биелэхгүй байх шалтгаан, нөхцөл нь болж байгаа манай улсын хувьд хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын нийт нийлбэр буюу дээд хэмжээг хязгаарлан тогтоохгүй байх, улмаар ялын нийт нийлбэр хэмжээг ямар хугацааны дараа хэрхэн бууруулах үндэслэл, журмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Дээрх жишээнээс үзэхэд хулгалах гэмт хэрэг үйлдсэн этгээд 3 үйлдэл тус бүртээ 2-8 жилийн хорих ял шийтгүүлж, түүнийг нь нэгтгэсэнээр 6-24 жилийн хугацаагаар хорих ял шийтгэгдэх юм. Хэдийгээр олон жилийн хугацаагаар хорих ял шийтгэх боловч тухайн хүний нийгэмд аюулгүй болсон, дахин хулгай хийх, хүн алах хүч тамиргүй болох хүртэлх буюу 25-40 жилийн дараа, дэлхийн жишгээр 20, 50, 75, 80 хувийн ялаа эдэлж дууссаны дараагаар суллах боломжтойгоор хуулийн зохицуулалтыг бий болгох юм[6].

Хулгайлах гэмт хэргийг бууруулах, түүнтэй тэмцэх, иргэдийнхээ өмчлөх эрхийг хамгаалах бас нэг хувилбар бол хулгайлах гэмт хэргийг өөр цаг хугацаанд, өөр газар нутаг, объектед халдаж үйлдсэн үйлдлүүдийг үргэлжилсэн нэг гэмт хэрэгт тооцохгүй, харин тус тусдаа нь бие даасан гэмт хэрэг юм гэсэн зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгах эсвэл “үргэлжилсэн” гэмт хэрэг гэсэн ойлголтыг хасч улмаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “шүүх хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахдаа гэмт хэрэг тус бүрд ял оногдуулж нэмж нэгтгэн нийт эдлэх ялын төрөл, хэмжээг тогтооно”, 6.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “хэд хэдэн бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг нэмж нэгтгэсэн нийт хэмжээ нь хамгийн хүнд ялтай бүлгийн хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй”[7] гэж үйлдэл тус бүрт нь ял оногдуулах талаар тодорхой заасныг удирдлага болгон хэрэгжүүлэх боломжтой байна.

2015 оны Эрүүгийн хууль нь криминологийн шинжлэх ухааны сонгодог онол тэр дундаа ял шийтгэл тодорхой, хатуу, түргэн шуурхай байх, нийгэмд хир хэмжээний хохирол учруулж, олон нийтийг түгшээсэн тэр хэмжээгээрээ ял шийтгэлийн тун нь таарч байх тухай сургадаг эрүүгийн хариуцлагаар эмээлгэх онол /deterrence theory/-ын суурь ухагдахууныг үндэслэн “хулгайлах” гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, түүний гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ өмчлөх эрхийг хамгаалахын тулд ял шийтгэлийг чангатгасан нь онолын хувьд үндэслэлтэй байсан боловч хулгайлах гэмт хэргийг хэд хэдэн удаагийн үйлдлээр үйлдсэн бол үйлдэл тус бүрт нь хорих ял оногдуулж нэмж нэгтгэх зохицуулалт байхгүй улмаас онолд суурилсан бодлого хэрэгжихгүй байгаа нь “хулгайлах” гэмт хэргийн гаралтыг өсгөсөн байх боломжтой байна.

[1] Г.Ганбаатар. “Эрүүгийн хуулийн шинэчлэл “төсөл”-д зааснаар хязгаарлагдахгүй”  
<http://www.judcouncil.mn/inder/8155--.html>

[2] Ronald L. Akers, Christine S.Sellers, Wesley G.Jennings (2017), Criminology Theory номны 14-16 хуудас

[3] BBC-ийн мэдээ: Яагаад хорих ял ийм удаан хугацаатай байдаг вэ? <https://www.bbc.com/news/blogs-magazine-monitor-23495284>

[4] Урт хугацааны туршид хорих ял оногдуулах нь илүү үр дүнтэй байгааг шинэ судалгаагаар тогтоов <https://www.mirror.co.uk/news/uk-news/longer-prison-sentences-are-more-effective-127826>

[5] Хууль сахиулах сургууль 2019

[6] Яагаад шүүгч нар бүх насаар нь хорих ял оноосон мөртлөө дээр нь нэмж 1000 жилийн хорих ял нэмэгдүүлж оноож байна вэ? <https://www.quora.com/Why-do-judges-sometimes-add-plus-1000-years-on-a-life-sentence>

[7] Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он

## ТОГЛООМЫН ОНОЛ БА ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН: АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Д.Бадамцэцэе  
ХСИС-ийн ЭЗНУС-ийн ЭЗОТ-ийн ахлах багш,  
цагдаагийн хошууч  
С.Оюунчимэе

ХСИС-ийн ЭЗНУС-ийн ЭЗОТ-ийн ахлах багш, ахмад

**Товч агуулга:** Хууль зүйн шинжлэх ухаанд тоглоомын онол, түүний арга зүйг хэрэглэснээр эрх зүйн үнэт зүйлийг танин мэдэх, шударга ёсыг хангах, хууль зүйн судалгааны үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой.

**Түлхүүр үг:** тоглоом, зөрчилдөөн, хууль зүйн шинжлэх ухаан, онол.

### Нэг. Оршил

Дэлхий нийтийн даяаршил, шинжлэх ухаан технологийн хөгжлийг даган шинжлэх ухаан<sup>19</sup> бүр өөр хоорондоо ижилсэх, нутагших, тодорхой шинжлэх ухааны арга зүйг өөртөө ашиглах, түүнийг хэрэглэх үйл ажиллагаа идэвхитэй өрнөж байна. Энэ хирээрээ тухайн салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход бусад шинжлэх ухааны мэдлэг, арга зүйг өргөнөөр ашиглах шаардлага бий болжээ.

Үүний нэг илрэл бол хууль зүйн шинжлэх ухаанд математикийн шинжлэх ухааны томоохон чиглэл болох тоглоомын онолыг ашиглаж эхэлж байна.

### Хоёр. Тоглоомын онол, түүний арга зүй

Германы хуульч профессор Р.Иерэнгийн хэлсэнчлэн байгальд шалтгаангүй үр дагавар гэж байхгүйн нэгэн адил нийгэмд зорилгогүй үйлдэл гэж үгүй<sup>20</sup>. Хүн материаллаг бус ашиг сонирхолын үүднээс тодорхой зорилгод хүрэхийн тулд үйлдэл хийдэг. Ашиг сонирхолд олон үйлдлээс аль нэгийг сонгох болоход эсрэг тэсрэг зөрчилдөөнтэй талууд оролцож байх нөхцөл байдал байнга үүсч байдаг. Ялангуяа эрх зүйн процессын буюу байцаан шийтгэх ажиллагаанд энэ байдал түгээмэл байдаг. Тухайлбал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч ба гэмт хэрэгтэн, шүүгч ба шүүгдэгч, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч хариуцагч, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зөрчил үйлдэгч ба төрийн байгууллага гэх мэт. Эдгээр оролцогч бүрт эрх зүйн хэм хэмжээний актаар олгосон эрх, үүрэг буюу зан үйлийн хэм хязгаар байдаг ба түүний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг. Ийм нөхцөл байдлыг зөрчилдөөн гэж нэрлэдэг.

Дээр дурьдсанчлан тухайн оролцогч бүрт олгосон зан үйлийн хэм хязгаар нь зөрчилдөөний нөхцөлд шийдвэр гаргагч зөвхөн өөрийн зорилго, ашиг сонирголоос гадна эсрэг талын ашиг сонирхлыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай болохыг илэрхийлж байдаг. Гэвч хууль тогтоомжийг хэрэглэх явцад эсрэг талын зорилго шийдвэр тодорхой бус байдаг. Тухайлбал иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн эсрэг хариуцагчаас ямар сөрөг нэхэмжлэл<sup>21</sup> гаргахыг нэхэмжлэгч шүүгчийн хэн ч мэдэхгүй, эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд шүүгдэгч<sup>22</sup> шинээр ямар нотлох баримт гаргаж ирэхийг шүүгч мэдэхгүй боломжгүй билээ.

<sup>19</sup> Шинжлэх ухааныг 2 үндсэн том бүлэгт хувааж болно.

1. Байгалийн шинжлэх ухаан - энэ нь байгалийн аливаа юмс үзэгдлийг судладаг бүх төрлийн шинжлэх ухаанууд,  
2. Нийгмийн шинжлэх ухаан - энэ нь хүн болон нийгмийн юмс үзэгдлүүдийг судладаг шинжлэх ухаанууд юм.

Зарим тохиолдолд Математикийг 3 дахь бүлэг болох хийсвэр шинжлэх ухаан (formal science) болгон ялгах нь байдаг. Учир нь математик нь дээр дурьдсан байгалийн болон нийгмийн шинжлэх ухаануудын аль алинтай нь төстэй болон ялгаатай талуудыг агуулсан байдаг байна. Хийсвэр шинжлэх ухаанд статистик, логикийн шинжлэх ухаанууд багтана. Хийсвэр шинжлэх ухаанд гарсан томоохон ололтууд нь физик болон биологийн, химийн шинжлэх ухаанд мөн томоохон дэвшил гарахад нөлөөлнө. Хийсвэр шинжлэх ухаан нь таамаглал, онол, физикийн хуулиудын үндэс болох ба улмаар тэдгээр нь байгалийн болон нийгмийн аливаа үзэгдэлийн мөн чанарыг нээх, илрүүлэх суурь болно. <https://mn.wikipedia.org/wiki>

<sup>20</sup> Нерсесянц В.С "Философия права". М., 1988 стр 577

<sup>21</sup> Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26-р зүйлийн 3-т /26.3/ зааснаар... "Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх эрхтэй." Төрийн мэдээлэл., УБ.2002 №8

<sup>22</sup> Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35-р зүйлийн 6 дахь хэсэг /35.6/-т зааснаар "...6.Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед нэмж мэдүүлэг өгч болно." Төрийн мэдээлэл сэтгүүл.УБ., 2017 он №23.

Ийнхүү зөрчилдөөний явцад оролцогч талууд хамгийн зөв үйлдлийн сонголт хийх нөхцөлд шийдвэр гаргах математик загварчлалыг тоглоомын онол гэдэг<sup>23</sup>.

*Тоглоомын онол (Англи: Game theory; Орос: Теория игр)* нь өнгөрсөн зууны эхний хагсат үүссэн хэрэглээний математикийн том салбар юм. Уг онолд “Тоглоом гэдэг нь төрөл бүрийн зөрчил тэмцэлт байдалд байгаа оролцогчдын, тодорхой дүрэмд захирагдсан, зорилго бүхий үйл хөдлөл бөгөөд эцэстээ ямар нэг хожил авдаг, бодит байдлыг хялбарчилсан загвар” гэж үздэг.

1944 онд Жон фон Нойманн, Оскар Моргенштерн нарын “Тоглоомын онол ба эдийн засгийн үйл ажиллагаа” хэмээх номонд энэхүү онолыг тодорхойлсон гэж үздэг бөгөөд энэ үеэс эхлэн тоглоомын онол нь эрчимтэй хөгжсөн байна. Тус онолыг хэрэглэгддэг стратеги, тэнцвэрт төлөв, хожил хуваах зэрэг ойлголтуудыг аль ч салбарт үүссэн зөрчилдөөнт байдлыг шийдвэрлэхэд хэрэглэж болдог нь тухайн онолын давуу тал юм. Иймд түүний арга зүйг эдийн засгийн шинжлэх ухаанд төдийгүй социологи, улс төр, хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэх болсон байна.

Манай улсын хувьд зөвхөн эдийн засгийн онол<sup>24</sup> д хэрэглэж байсан бөгөөд 2000 оноос тоглоомын онолын талаар бүтээлүүд туурвигдаж эхэлжээ. Хэдийгээр тоглоомын онолын арга зүйг хууль зүйн шинжлэх ухаанд хэрхэн хэрэглэх талаар арга зүйн бие даасан судалгаа байхгүй боловч салбар эрх зүйд тэр дундаа процессын эрх зүйд хуульчилж эхэлсэн байна.

Тоглоомын онол нь математик загварчлалын онол болохын хувьд зөрчилдөөний нөхцөл байдалд анализ хийж шийдвэр гаргах хялбарчилсан зохистой сайн схемийг тодорхойлж өгдөг. Гэхдээ ямар ч загварыг авч үзэхдээ хялбарчлах түвшин нь тодорхой хязгаарыг давж гарах ёсгүй. Давж гарсан тохиолдолд загвар нь өөрийн гол шинжээ алддаг байна. Иймд зохион бүтээж буй загвар нь тоо хэлбэр тэмдэг хэлбэртэй формаль математик арга зүйн анализ бүхий математик загварчлал байдаг байна.

### ***Гурав. Тоглоомын онол ба хууль зүйн шинжлэх ухаан***

Хууль зүйн практикийн олон нөхцөл байдалд тодорхойлох туршлагаар тоглоомын аргуудыг загварчилж болно.

Тоглоомын онолоор тоглогчид оновчтой стратегийг тодорхойлж тоглолт бүрд хожих зорилготой байдаг. Энэ үндсэнд тоглоомонд янз бүрийн зорилгод хүрэхийг эрмэлзсэн 2 ба түүнээс дээш этгээдүүд оролцдог. Тоглоомонд оролцогчид ижил ашиг сонирхлоор нэгдэж хэсэг бүлэг/ өөр ашиг сонирхолтой бусад бүлгээс ялгаатай/ болж болно. Ийм бүлэг тоглоомонд тоглоомонд оролцогчдыг “эвсэл” гэж нэрлэдэг бөгөөд энэ нөхцөлд нэгдсэн оролцогчдыг нэг этгээд /оролцогч тоглогч/ гэж үздэг.

Энд тэмдэглэхэд тоглоомын онолыг гол зарчим нь тоглоомонд оролцогч эсрэг талын этгээдийг зөв үнэлэх явдал юм. Өөрөөр хэлбэл тоглоомонд оролцогч этгээдүүд харилцан бие биенээ ухаантай гэж зөв үнэлж бодит нөхцөл байдлыг зөв ойлгож хамгийн оновчтой стратегийг сонгож байж үр дүнд буюу ялалтанд хүрэх боломжтой юм.

Тоглоомыг оролцогчдын тоогоор нь 2 этгээдтэй ба олон этгээдтэй тоглоом зөрчилдөөний нөхцөл байдлаас шалтгаалан төгсгөлөг ба төгсгөлгүй тоглоом үл эвсэх ба эвсэлдэх тоглоом бүрэн мэдээлэлтэй ба бүрэн бус мэдээлэлтэй тоглоом оролцогчдын хожлоор тэг нийлбэртэй бай тэг биш нийлбэртэй тоглоом гэж ангилдаг. Мөн тоглоомын шинж чанараар нь Детеминистик, Стохаостик, хэлбэрээр нь байршилт ба байршилт бус тоглоом явагдах онцлогоор нь бүрэн ба бүрэн бус тоглоом гэж ангилахаас гадна тоглоомыг хожлийн функцийн хэлбэрээс хамааран матрицан биматрицан тасралтгүй гүдгэр тоглоом гэж ангилдаг.<sup>25</sup>

Эрх зүйн процесс бол бүхэлдээ тоглоомын загварууд юм. Эрх зүйн процесс дахь тоглоом нь хийсвэр загвар байдаг. Үүнд:

- Хэд хэдэн оролцогч байна. /*мөрдөгч ба гэмт хэрэгтэн, гэмт хэргийг хамтран үйлдэгчид, шүүгч шүүгдэгч/*
- Оролцогч бүр нь тодорхой нөхцөлд тус бүрийн зорилгыг биелүүлэх үйлдлийг сонгоно. (*сэжигтэнээр тооцох, яллагдагчаар татах, хариуцагчид нэхэмжлэлийн хувийг гардуулах*)
- Уг үйлдэл нь нөхцөл байдал болон оролцогчдод нөлөөлнө./*сөрөг нэхэмжлэл гаргах, нотлох баримтыг бүрдүүлэх/*

<sup>23</sup> <http://iom.num.edu.mn/enkhat/books/Game%20theory.pdf>

<sup>24</sup> Мөн тэнд

<sup>25</sup> Мөн тэнд



- Оролцогч бүрийн зорилго, сонгох боломж бүхий үйлдлүүдийн төрөл нь математикийн аргаар илэрхийлэгдэх хэлбэртэй байна.
- Энэхүү хийсвэр загвар нь дараах хэлбэрээр дүн шинжилгээ, судалгаанд ашиглагддаг.
- Одоогийн нөхцөл байдлыг загварчилж, энэ нөхцөл байдал дахь боломжит үйлдлүүдийн дундаас хамгийн тохиромжтой арга замыг олох. / Гэмт хэрэгтэн ямар байдлаар мэдүүлэг өгвөл өөрт ашигтай вэ гэдгээ сонгох/
  - Одоогийн нөхцөл байдлыг загварчилж, уг тоглоом нь цааш үргэлжилбэл ямар үр дүн гарах вэ гэдгийг тогтоох.
  - Нөхцөл байдлыг загварчилж, оролцогчид бүгд зөв тоглодог бол ямар үр дүн гарахыг тооцоолох (ямар байдлаар асуултанд хариулбал тухайн гэмт хэргийг үйлдээгүй эсвэл бага ял авах вэ гэдгээ тооцоолж хариулах)

Тухайлбал хамтран хулгайн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хувьд гэмт хэрэгтэнүүд дан дангаараа хэргээ хүлээвэл тэдгээрт оногдуулах санкц ондоо байна, хоёулаа хамтран хүлээвэл санкц мөн өөр, харин хоёулаа хүлээхгүй бол мөн оногдуулах санкц өөр байна.

Тоглоомын онолын арга зүйг хэрхэн хэрэглэх талаар дэлхий нийтээрээ сонгодог жишээ хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн нэгэн жишээгээр тайлбарлая<sup>26</sup>. Хоёр хүн хулгай хийжээ. Удалгүй цагдаа хоёуланг нь барьсан боловч хулгайн гэмт хэрэг үйлдсэн талаар хангалттай нотлох баримт бүрдүүлж чадаагүй байна. Тиймээс дээрхи сэжигтэнгүүдийг байцаахаар тус тусад нь хорьж бие биенээс нь тусгаарлав. Эхний сэжигтэнтэй цагдаагийн ажилтан уулзаж хэрвээ та хоёр хулгай гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрвөл өөрт нь 2 жилийн хорих ял хүлээлгэнэ. Хүлээхгүй бол цагдаа зайлшгүй нэмэлт нотлох баримт цуглуулах ёстой болох бөгөөд магадгүй хангалттай нотлох баримт цуглуулж чадаагүй бол эхний сэжигтэн гэм буруугийд тооцогдон чөлөөлөгдөнө, харин эсрэгээс баримт бүрдвэл 5 жил хоригдох болохыг сануулжээ. Уг цагдаа нөгөө сэжигтэнтэй уулзаад мөн л яг адил зүйл ярьсан байна. Хоёр сэжигтэн мэдээж цагдаагийн байцаалт, үгийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд нотлох баримт олдохгүй бол буруугийд тооцож суллагдахыг мэдэж байгаа. Гэвч тэд хоорондоо холбогдогдож ярилцах боломжгүй бөгөөд нэг нь нөгөөгийнхөө эсрэг юу ярих, яриа нь яаж зөрөхийг аль аль таашгүй юм. Энэхүү хэрэгт сэжиглэгдэж буй хоёр этгээдийн эрсдлүүд болон боломжуудыг доорхи зурагаар харуулжээ. Доорхи зурагаас харахад мэдээж хоёр сэжигтэн хоёулаа цагдаатай хамтран ажиллахгүй буюу хэргээ хүлээхгүй байхад өөрсдөд нь хамгийн ашигтай байхаар байна. Харин хэн нэг нь хэргээ хүлээгээд нөгөө нь хүлээхгүй нөхцөлд хэргээ хүлээсэн н хамгийн муу хувилбар буюу ганцаараа 5 жилийн хорих ял эдлэнэ. Гурав дахь хувилбар буюу хоёулаа хэргээ хүлээвэл аль аль нь 2 жилийн ял авна.

		Сэжигтэн А	
		Хэргээ хүлээвэл	Хэргээ эс хүлээвэл
Сэжигтэн Б	Хэргээ хүлээвэл	2 жил	5 жил
	Хэргээ эс хүлээвэл	2 жил	0 жил

Тоглоомын онолд бүх мэдээлэл нээлттэй гэж тооцогдох ба хоёр тоглогчтой, нэг удаагийн шийдвэр гаргах, гарсан шийдвэрээс хамаарч үр дүн нь шууд мэдэгдэх тоглоом байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл тоглоомын онол нь сэжигтэнүүдэд хамгийн ашигтай боловч хэрэв хэн нэг нь хэргээ дангаараа хүлээвэл хэргээ хүлээлгүй нөгөө нөхөр хамгийн хүнд ялыг нь ганцаараа үүрдэг "ацан шалаа"-ы онол ч гэж нэрлэдэг.<sup>27</sup>

Хууль зүйн практик үйл ажиллагааны явцад тоглоомын стратеги нь хуульчдын зан үйлдийн чиг хандлагаар тодорхойлогдож байж болно. Иймд тоглоомын зорилго стратеги

<sup>26</sup> <https://www.psychologos.ru/articles/view/teoriya-igr.-iskusstvo-strategicheskogo-myshleniya-a.-diksitpt-b.-dzh.-neylbaff>

<sup>27</sup> Мөн тэнд

нөхцлийг хэрэгжүүлэхэд тоглоод оролцогч этгээдийн мэргэжлийн туршлдага ихээхэн ач холбогдолтой.

Хуульч нь онол практикийн өндөр мэдлэгтэй мэргэжлийн сайн ур чадвартай байхын зэрэгцээ зөрчилдөөнт байдлын нөхцөл байдлыг бодитой үнэлж оновчтой стратегийг сонгосноор зохистой үр дүнд буюу хөгжилд хүрэх боломжтой.

Тоглоомын дүрмээр хожил нь тоглогчдын хэрэглэж буй стратегиас шалтгаалж байдаг. Үнэндээ хожил нь тоглогчдын идэвхитэй үр ашигтай үйлдлийн хэмжүүр юм.

Хууль зүйн салбарт зөрчилдөөний нөхцөл байдал тоглоомын хэлбэрээр төсөөлөгдөх явцад тоглоомын дүрэм стратеги нөхцөл байдал эсрэг тоглогч тоглоомын явц үр дүнг зураглан тодорхойлоход хүндэрлүүд гарч ирдэг.<sup>28</sup>

Жишээлбэл: гэмт хэргийн статистикийг тооцон түүнд нийцүүлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээг боловсруулах үед цаг үийн нөхцөл байдал өөрчлөгддөг.<sup>29</sup>

Иймд нөхцөлд байдлыг урьдчилан тогтоож стратеги тусгасан байхад стратегийн хүрээ тоог нэмэгдүүлж өгдөг боловч тоглоомыг шинэчилэн судлахад хүндрэлтэй байдаг тул тоглоомын нөхцөл байдал шийдвэр гаргахад нөлөөлөх хүндрэлүүдэд даван туулах арга замуудыг тоглоомын үндсэн дүрэм элементүүдийг ялгаж нөхцөл байдлыг маш нарийн бодитой тодорхойлох нь ач холбогдолтой юм.

Тоглоомын онолын арга зүйг дараах хууль зүйн шинжлэх ухааны салбаруудад түгээмэл хэрэглэж байна. Үүнд:

1. Эрх зүйн процесс. Эрх зүйн процесс бол эрх зүйн зохицуулалтын баталгааг хангах, үр нөлөөг дээшлүүлэхэд томоохон түлхэц үзүүлдэгээрээ хууль зүйн шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой. Эрх зүйн процесс гэдэг нь эрх зүйн зөрчлийн хэрэг маргаагыг хянан шийдвэрлэхэд чиглэгдсэн эрх бүхий этгээдийн үе шаттайгаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Энэхүү эрх зүйн үйл явцыг хууль зүйн утгаар нь дараах байдлаар ангилдаг билээ. Үүнд:

- 1.1.1.1. Иргэний процесс
- 1.1.1.2. Захиргааны процесс
- 1.1.1.3. Эрүүгийн процесс
- 1.1.1.4. Үндсэн хуулийн процесс

Тухайн салбарын процессын хууль тогтоомжуудад байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод тодорхой эрх үүрэг, түүнийг хэрэгжүүлэх зан үйлийг тусгасан байдаг. Процессын ажиллагаанд оролцож буй этгээдүүд өөрийн эрх үүргийг хэрэгжүүлэхдээ логикийн аргуудыг ашигладаг бөгөөд тэдгээр аргуудыг тоглоомын онолын дүрмийн дагуу ашигладаг. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.7-д зааснаар мөрдөгч хүн, мал, амьтан, цогцос, эд зүйл, тодорхой газар, орон байрыг гэрч, хохирогч, яллагдагчаар таньж олуулж болно.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 74-т зааснаар шүүгч хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 23-т зааснаар Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж болно.

2. Эдийн засгийн эрх зүй. Мөн эдийн засгийн эрх зүйд, эдийн засгийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн үзэл баримталд ихээхэн хэрэглэж байна. Тухайлбал, гэрээний эрх зүйн харилцаа тэр дундаа банкны зээлийн гэрээнд түгээмэл хэрэглэж байна.

Ийнхүү Монгол Улсын хувьд тоглоомын онолыг хууль тогтоомждоо тусгасан хэдий ч уг онолын арга зүйг өөрийн улсын онцлогт нийцүүлэх хөгжүүлэх, цаашлаад эрх зүйн процесс болон материаллаг эрх зүйн хүрээнд хэрхэн ашиглах онолын болон хуулийн үзэл баримтлалыг боловсруулах шаардлагатай байна.

### **Ашигласан эх сурвалж:**

#### ***Нэг. Хууль тогтоомж***

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл

<sup>28</sup> Сэлэнгэ Х. "Эрх зүйн философи: онол-арга зүйн асуудал УБ.,2016 он 127-р тал

<sup>29</sup> Монгол Улсад гэмт хэргийн статистикийн тогтолцоо оновчтой бус, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурор, шүүхийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл, арга зүй уялдаагүй, гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэлийн аргачлал, статистик мэдээний нэгдмэл байдал хангагдахгүйгээс гэмт явдлын тоо бүртгэл бодитой бус байгаа нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод үр дүнтэйгээр нөлөөлж чадахгүй. Мөнхдорж Б. "Гэмт хэргийн онол арга зүйн тулгамдсан асуудал" Шинжлэх ухааны академийн мэдээ. УБ.,2017 №01

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл

**Хоёр. Сурах бичиг, гарын авлага, сэтгүүл**

- Нерсеянц В.С “Философия права”. М.,1988 стр 577
  - Сэлэнгэ Х. “Эрх зүйн философи: онол-арга зүйн асуудал УБ.,2016 он 127-р тал
  - Мөнхдорж Б. “Гэмт хэргийн онол арга зүйн тулгамдсан асуудал” Шинжлэх ухааны академийн мэдээ. УБ.,2017 №01
- Гурав. Цахим эх сурвалж**
- <http://iom.num.edu.mn/enkhbat/books/Game%20theory.pdf>
  - <https://www.psychologos.ru/articles/view/teoriya-igr.-iskusstvo-strategicheskogo-myshleniya-a.-diksitst-b.-dzh.-neylbaff>

## МӨРДӨГЧИЙН МЭДЭГДЭЛ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АРГА ХЭЛБЭР БОЛОХ НЬ

*П.Эрдэнэбаатар  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЭХХШЭЗ-н тэнхимийн багш,  
цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцлийг тогтоож арилгах талаар мөрдөгчөөс хуульд заасан арга, хэлбэрийг ашиглаж явуулж байгаа баримт бичгийн талаар авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** Мөрдөгч, гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, мэдэгдэл, урьдчилан сэргийлэх, хуулийн этгээд.

### Үндсэн хэсэг

Гэмт хэрэгтэй тэмцэх нь зөвхөн гэмт хэргийг шуурхай, гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хязгаарлагдахгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулалттай үр дүнтэй хэрэгжүүлэхийг шаарддаг.


Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч байгаа цогцолбор арга хэмжээг хэлнэ.<sup>30</sup> Гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг судалж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах нэг чухал арга хэлбэр нь мөрдөгчөөс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагад бичиж байгаа мэдэгдэл байдаг.

Мөрдөгчийн мэдэгдэл нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нэг бүрт гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан, нөхцлийг судалж тогтоох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийнхээ гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг арилгуулах, хууль ёсны үндэслэлтэй шийдвэрийг зохих хуулийн этгээдэд өгч биелэлтийг нь хангуулж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийн төрөл гэж үздэг.


Мөрдөгчийн мэдэгдэлд мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг хууль зүйн үндэслэлтэй хэрхэн тусгасан, мэдэгдлийг хүлээн авсан хуулийн этгээд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын удирдах албан тушаалтан хуульд зааснаар гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах талаар хэрхэн үр дүнтэй бүтээлч, идэвх санаачлагтай ажилласнаар тодорхойлогдох ёстой.

Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэрэг бүрт гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцлийг тодорхойлсон мэдэгдэл бичиж, түүнийхээ мөрөөр ажиллах, уг мэдэгдлийг хүлээн авсан хуулийн этгээд аж ахуйн нэгж байгууллага, олон нийтийн газар, удирдах албан тушаалтан гэмт хэрэг гарах болсон шалтгаан нөхцлийг арилгаж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагын статистик мэдээнээс: 2016-2018 оны эхний 10 сарын буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 1061 хүн амиа хорлож, 5731 хүн золгүй байдлаар нас барж, хүнийг санаатай алах гэмт хэрэг 512, болгоомжгүй алах гэмт хэрэг 115, зам тээврийн ослоор нас барсан хүн 1449 бүртгэгджээ. Үүнээс амиа хорлосон үйлдлийн шалтгааныг авч үзэхэд:



<sup>30</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ.,1994



Амиа хорлосон үйлдлийн шалтгааныг авч үзэхэд, гэр бүлийн таарамжгүй харилцаа, хэрүүл маргаан, стресс зэрэг хувь хүний сэтгэл санааны байдалтай холбогдсан шалтгаан эзэлдэг байна. Үүнийг графикаар харуулбал:

Үүнээс золгүй байдлаар нас барсан газруудыг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал<sup>31</sup>:

д/д	Үйлдэгдсэн газар	2016 он	2017 он	2018 оны эхний 10 сар
		Тоо	Тоо	Тоо
1	Төрийн бус байгууллага	33	39	27
2	Төрийн байгууллага	33	38	45
3	Олон нийтийн газар	29	50	64
4	Аж ахуйн нэгж	85	112	148
5	Гудамж талбай	135	264	305
6	Гэр орон сууц	643	1007	1403
7	Автозам	8	22	14
8	Бусад газар	275	431	521

Золгүй тохиолдлоор нас барсан шалтгааныг сүүлийн 3 жилээр харуулбал:

д/д	Хэргийн төрөл	2016 он	2017 он	2018 оны эхний 10 сар
		Тоо	Тоо	Тоо
1	Усанд живсэн	53	70	109
2	Осгосон, хөлдсөн	57	94	79
3	Дээвэр, тагт, цонхноос унасан	19	30	21
4	Архинд гүн хордсон	379	598	749
5	Хүчдэлд цохиулсан	6	8	4
6	Угаартсан	23	22	21
7	Түлэгдсэн	12	11	8
8	Хөдөлмөр хамгаалалын журам зөрчсөн	2	26	27
9	Тоглож байгаад осолдсон	1	3	4
10	Бусад газар	295	304	483

Цагдаагийн байгууллагаас нас баралтын шалтгаан болж байгаа эдгээр нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллага, эрх бүхий албан тушаалтан, мөрдөгчийн зүгээс худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад 2018 онд нийт 2253 мэдэгдэл, зөвлөмж хүргүүлж, 426 мэдэгдлийн хариуг авч, их, дээд сургууль болон коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 11402 багш, оюутан, нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын дунд ахлах ангийн 29833 сурагч, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зэрэг 2503 хүнд ахуйн газ, согтууруулах ундааны хор хөнөөлийн талаар сурталчилгаа явуулж ажилласан талаар тайлан мэдээнд тусгасан байна. Энэ бүх статистикийн тоон мэдээнээс харвал гэмт хэрэгтэй тэмцэх эрх байгууллага, албан тушаалтны зүгээс мөрдөгчийн мэдэгдлийн ач холбогдлыг дээшлүүлэх шийдвэртэй хариуг өгөх, хуулийн хэрэгжилтийг хангах шаардлага тулгарч байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлд...гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд

<sup>31</sup> "Хүний амь нас хохирсон хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь сөвдөвт хэлэлцүүлгийн эмхэтгэл УБ., 2018 20 дах тал

тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж, хуулбарыг хэрэгт нь хавсаргана<sup>32</sup>. Мөн хуульд эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэхдээ...гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг<sup>33</sup> нотолж тогтооно гэж заажээ.

Ийм учраас мөрдөгчийн мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөгөөнд дараах нөхцөл байдлуудыг тогтоон нотлох шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Хэргийг мөрдөн шалгах явцад цуглуулсан баримтат мэдээлэл, материал нь нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг<sup>34</sup> оновчтой бүрэн авхуулах шаардлагыг хангасан байх;

2. Гэмт хэрэг, зөрчил чухам юунаас шалтгаалж үйлдэгдсэн, яагаад тухайн үед нь арилгах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ аваагүй тухай үнэлгээ, дүгнэлт хийх;

3. Гэмт хэрэг үйлдэх, түүнийг хэрэгжүүлэх санаа бодол төрөхөд нөлөөлсөн суурь шалтгаан нөхцлийг илрүүлэн тогтоох;

4. Уг санаа бодол нь цаашид гэмт үйлдэл болон хэрэгжих явдлыг яагаад таслан зогсоож чадаагүйг тогтоох;

5. Сэжигтэн, яллагдагчийн ажиллаж амьдарч байсан газруудын удирдах хүмүүстэй холбоо тогтоох, харилцан зөвлөлдөх, хамтран ажиллах;

6. Үйлдсэн гэмт хэргийн талаар, сэжигтэн, яллагдагчаар өөрөөр нь нарийвлан яриулах;

5. Сэжигтэн, яллагдагчийн амьдралын нөхцөл байдал, хүмүүжлийн онцлог, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрх бүхий албан тушаалнаас тодорхойлолт авах, хувийн байдлыг тогтоох;

6. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөл үзүүлсэн нөхцөл, гэмт хэрэг үйлдэх санаагаа хэрхэн хэрэгжүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн арга, ашигласан багаж хэрэгсэл, гэмт хэрэг үйлдсэн цаг хугацаа, үйлдэх үеийн бие махбодийн болон сэтгэл зүйн байдал /согтууруулах<sup>35</sup> болон мансуурлах бодис хэрэглэсэн байсан эсэх, сэтгэл санаа нь цочирон бачимдсан гэх мэт/ субъектив болон объектив байдлыг тогтоох;

7. Сэжигтэнг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, таслан сэргийлэх арга хэмжээг сонгон хэрэглэж гэмт хэрэг үргэжлүүлэх болон шинээр дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох;

Мөрдөгч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор яллагдагч нэг бүрийн ажиллаж, амьдарч байсан газарт мөрдөгчийн мэдэгдлийг бичихдээ дор дурдсан байдлуудыг анхаарах үзнэ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн, нөлөөлж байгаа зөрчил, хувь хүний ёс суртахууны дутагдал доголдол;

2. Яллагдагчийн нийгэмд харш үзэл, дадал заншил бүрэлдэн тогтооход нөлөөлсөн нөлөөлөл, соёл хүмүүжлийн ажлын дутагдал;

3. Гэмт хэргийг бэлтгэх, үйлдэх, нуун далдлахад нөлөөлсөн албан тушаалтан, хүн, хуулийн этгээд;

4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохад саад болж байгаа бэрхшээл дутагдал, доголдол, ажлын хариуцлага;

5. Илэрсэн дутагдал доголдол, ажлын болон сахилгын харицлага нь хүн, хуулийн этгээдийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой эсэх, эсвэл илэрсэн зөрчил дутагдлыг тухайн байгууллага арилгах боломжтой байсан эсэх;

6. Мөрдөгчийн мэдэгдлийг тухайн хуулийн этгээд, хамт олон хэлэлцэх үед биечлэн оролцох;

7. Мэдэгдлийг гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай зөвлөмжийн хэсгээр дуусгах гэх мэт асуудлыг тусгасан байвал зохино.

Мөрдөн шалгах ажиллагаа эрхлэн гүйцэтгэж байгаа байгууллага, эрх бүхий албан тушаалтны оролцоо, хяналтыг сайжруулах Үүнд:

1. Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын дүнг хэлэлцэх;

<sup>32</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль УБ., 2017

<sup>33</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2

<sup>34</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.1.3

<sup>35</sup> Сogтууруулах ундаа хэрэглэж хэрэг зөрчил гаргасан талаар сүүлийн 3 жилд цагдаагийн байгууллагад ирүүлсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд 34.0 хувь гудамж талбайд, 48 хувь нь орон сууц, ахуйн хүрээнд 18.0 хувь нь баар, караоке, ресторан, зочид буудалд үйлдэгдсэн байна. "Хүний амь нас хохирсон хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга зам, байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах нь сэвдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл УБ., 2018 24 дэх тал

2. Хуулийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиож байгаа ажлын байдлыг шалгах;

3. Хамтарсан сургалт, хууль эрх зүйн зөвлөгөөн хийх, туршлага солилцох;

4. Хуулийн хэрэгжилтийг шалгах, хууль сурталчлах;

5. Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд танилцуулга, санал оруулах;

6. Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тархалт, гэмт хэрэг, зөрчлийн байдал гэмт хэрэгт холбогдогчдын онцлог шинжүүдийг судлах;

7. Гэмт явдалд нөлөөлсөн шалтгаан нөхцөл байдлуудыг арилгах арга хэмжээг системтэй зохион байгуулалттай явуулах;

8. Хуулийн этгээдэд хуулийн хэрэгжилтийг хангах, биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

9. Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, сурталчилгааны зохион байгуулах;

10. Ухуулга сурталчилгаандаа хэвлэл мэдээлэл, радио, телевиз, интернет орчин, кино, соёл урлаг, уран сайхан зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах;

11. Мөрдөгчийн бичсэн мэдэгдлийн агуулга, чанар үр нөлөөг шалгах, хэрэгжилтийг хангах;

12. Мөрдөгчийн нэг бүрчилсэн авсан арга хэмжээг хангалтгүй гэж үзвэл нэмэгдэл арга хэмжээ авахуулах, зааварчлах зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

Практикаас харахад, мөрдөгчийн мэдэгдлийн ач холбогдлыг дутуугаар үнэлж, түүний мөрөөр тодорхой урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй, мэдэгдлийг хүлээн авч, ямар урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, үр дүнг тооцсон талаар хариу мэдэгдэхгүй байдал хэвшмэл байна.

Мөрдөгч мөрдөгчийн мэдэгдлийн ач холбогдлыг дутуу үнэлж, мэдэгдэл бичихгүй байх, бичсэн мэдэгдлийн биелэлтэд хяналт тавьдаггүй дутагдал байна.

Мөрдөгч мэдэгдэл бичихдээ ямар хуулийн этгээд, албан тушаалтанд хандахаа сайтар тунгаах шаардлагатай.

Мөрдөн шалгах ажиллагааны туршлагаас үзэхэд, мөрдөгч мэдэгдэл бичихдээ хууль зүйн болон хэл бичгийн дүрэм, утга найруулгын алдаа гаргах, шат алгасч удирдах дээд байгууллагад бичих, эсвэл биеэ даан гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх зохион байгуулалт, аж ахуй, соёл, хүмүүжлийн оновчтой арга хэмжээ авч чадахгүй байгууллага, албан тушаалтанд бичиж, мөрдөгчийн мэдэгдлийн нэр хүндийг бууруулж байгаа дутагдал байна.

Мөрдөгчийн мэдэгдлийг бичихдээ дээр дурдсан дутагдлыг арилган, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь хуулийн хэрэгжилтийг хангах нэг арга, хэлбэр болно.

## МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Э.Өлзийжаргал  
ХСИС-ийн магистрант

**Товч агуулга:** Энэ өгүүллээр Монгол Улсын гадаад өрийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхийг зорьсон. Монгол Улсын нийт гадаад өр 2013 онд 19.8 тэрбум, 2014 онд 21.8 тэрбум, 2015 онд 22.7 тэрбум, 2016 онд 24.6 тэрбум, 2017 онд 27.5 тэрбум, 2018 онд 28.7 тэрбум ам.долларт /өссөн дүнгээр/ хүрсэн байна. Дэлхийн банкны CPIA буюу улсын бодлого, институцийн үнэлгээгээр манай улс 3.4 үнэлгээ авсан Монгол Улсын Засгийн газрын өрийн тогтворгүй байдал үүсч, сэрэмжлэх түвшинд хүрсэн байна.

**Түлхүүр үг:** Эдийн засаг, эдийн засгийн аюулгүй байдал, өр, гадаад өр, өрийн ангилал.

### **1.Эдийн засгийн аюулгүй байдал ба улсын өрийн хамаарал:**

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гадаад өрийн үзүүлэх сөрөг үр дагаврыг тоон утгаар илэрхийлэхэд хүндрэлтэй хэдий ч төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй, технологийн дэвшил, бүтээмжийн өсөлттэй уялдаагүй гэнэтийн их хэмжээтэй мөнгөний урсгал нь төсөв, мөнгөний бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийг гажуудуулж тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангахад сөрөг үр дагавартай болохыг харуулсан судалгааны ажлууд хөгжиж буй орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хувьд хийгдсэн байдаг.

Бонгард (2001) гадаад өр нь макро эдийн засгийн чухал үзүүлэлтүүд болох валютын ханш, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөөтэй болохыг харуулсан судалгааг хийсэн байна.<sup>36</sup> Олон улсын санхүүгийн нэгдэл болох Девей Валинтен компанийн (Брент Л.Бартлетт, 2002) хийсэн судалгаагаар гадаад өр нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй банк, санхүү болон үнэт цаасны зах зээлд нөлөөлж тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах зорилтыг гажуудуулна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.<sup>37</sup> Түүнчлэн, уг судалгаагаар гадаад өрв зээл тусламжаар бүрдүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг оновчтой тодорхойлохгүй бол авлига болон бусад гэмт хэргийн замаар нөөцийн хуваарилалтыг гажуудуулж бүтээмж багатай хөрөнгө оруулалтууд хийгдэх шалтгаан болж бодит эдийн засгийн секторт сөрөг нөлөө үзүүлнэ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Идоу (2012)-ын хийсэн судалгаагаар гадаад өр нь нийгмийн болон улс төрийн тогтворгүй байдлыг бий болгох сөрөг үр дагавартай гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.<sup>38</sup>

Тиймээс монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн орчин бүрдүүлж ажиллаж байна. Монгол улсын нийт өрийг улсын нийт гадаад өр, засгийн газрын дотоод нийт өр гэж ангилана.

Монгол Улсын хууль тогтоомжид “Өр” гэсэн нэр томъёог дараах байдлаар тодорхойлж байна. Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт “Улсын нийт гадаад өр<sup>39</sup> гэж Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн харьяат бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүрэг” гэж тодорхойлсон бол дэлхийн банкны шинжээчдын дүгнэлтээр “Засгийн газрын болон засгийн газрын нэгжүүд, мөн засгийн газрын бүрэн эрхэт төлөөлөгчидийн урт хугацаанд гадаад улсад төлөхөөр үүрэг хүлээсэн болон Засгийн газрын баталгаа гаргасан хувийн хэвшлийн байгууллагын гадаад улсад төлөхөөр үүрэг хүлээсэн өрийн нийлбэрийг Засгийн газрын гадаад өр”, Олон улсын валютын сангаас “Гадаад өр гэж тухай оронд оршин суугч нь гадаад улсруу шилжүүлэх үүрэг хүлээсэн төлбөрүүдийн нийлбэрийг хэлнэ”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд “улсын өр гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газрын гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг хэлнэ” гэж тус тус тодорхойлжээ.

<sup>36</sup> Bongard, Kai (2001), Wirtschaftsfaktor Geldwäsche: Analyse und Bekämpfung, Wiesbaden 2001.

<sup>37</sup> Brent L. Bartlett, The Negative Effects of Money Laundering on Economic Development, in: Asian Development Bank, Manual on Countering Money Laundering and the Financing of Terrorism, s.l. 2003.

<sup>38</sup> Edouard Pignot Bringing down the house (of Goldman Sachs): Analyzing corrupt forms of trading with Lacan

<sup>39</sup> Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэг



Өрийн хэлбэрүүд	Тайлбар
Гадаад зээл	Хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас авсан зээл
Гадаад зах зээлд гаргасан үнэт цаас буюу бонд	Гадаад зах зээлд ЗГ-аас гаргасан үнэт цаас буюу бонд
Болзошгүй өр төлбөр	Засгийн газрын зүгээс бусад байгууллагуудын гадаад зах зээлд арилжсан үнэт цаас болон гадаад зах зээлээс авсан зээлэнд гаргасан баталгаа
Гадаад улсын хадгаламж	Төв банкинд байршуулсан гадаад улсын хадгаламж

## 2. Монгол Улсын гадаад өрийн өнөөгийн байдал


Монгол Улсын нийт гадаад өр 2013 онд 19.8 тэрбум, 2014 онд 21.8 тэрбум, 2015 онд 22.7 тэрбум, 2016 онд 24.6 тэрбум, 2017 онд 27.5 тэрбум, 2018 онд 28.7 тэрбум ам.долларт /өссөн дүнгээр/ хүрсэн байна.<sup>40</sup>

Хүснэгт №1 Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл /мянган ам.доллар/


Үзүүлэлт	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/30/2016	12/31/2017	12/31/2018
Засгийн газар гадаад бонд	3,534,577	3,500,795	3,759,859	4,868,606	7,320,975	7,182,509
Зээл	1,415,416	1,402,818	1,472,538	2,063,528	3,548,542	2,946,589
Төвбанк Хадгаламжийн байгууллага	2,119,160	2,097,977	2,287,320	2,805,078	3,772,434	4,235,920
Бусад салбарууд Шууд хөрөнгө оруулалт	1,130,456	1,570,355	1,959,643	1,790,751	2,025,079	2,030,222
Нийт гадаад өр	1,375,810	1,762,182	2,128,504	2,417,380	2,194,264	2,220,220
	3,198,699	3,976,579	3,748,947	8,121,485	7,955,844	8,113,613
	10,590,115	11,040,606	11,120,864	7,426,277	7,996,494	9,196,526
	19,829,657	21,850,516	22,717,817	24,624,500	27,492,657	28,743,089

Эх сурвалж: Монгол банк

Монгол Улсын нийт гадаад өр сүүлийн 6 жил тасралтгүй өсч, 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буюу 1250432 мянган ам.доллараар нэмэгджээ.



<sup>40</sup> Сангийн яамны 2018 оны үйл ажиллагааны тайлан, УБ., 2018



2018 оны 12 дугаар сарын 31 байдлаар улсын нийт гадаад өрөнд хамгийн их хувь буюу 32 хувийг шууд хөрөнгө оруулалт эзлэж байхад хамгийн бага 7 хувийг төв банкийн өр байна.

**Гадаад зээл:** Монгол Улсын Засгийн газар хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжилд түлхэц болохуйц төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор 20 орчим гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн үлдэгдэл 2013-2016 онд нийт 2,1-2,8 тэрбум ам.долларын гадаад зээлтэй байсан бол 2018 оны эцэст 4,2 тэрбум ам.долларт хүрсэн байна.

*Хүснэгт №2 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл /мянган ам доллар/*

Улсаар	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31	2017.12.31	2018.12.31
Japan	439,694	442,603	495,467	629,979	1,063,363	1,095,184
Germany	108,411	106,651	98,819	97,510	108,524	106,890
Kuwait	35,571	38,350	42,000	38,865	35,162	30,993
Korea	59,057	54,820	49,317	67,652	79,154	128,329
China	265,764	304,908	359,797	438,344	507,871	690,019
Spain	12,780	10,172	8,133	6,816	6,669	5,340
Finland	34,584	30,008	26,873	24,980	26,520	25,638
Belgium	6,313	5,581	5,018	4,803	5,479	5,258
Poland	410	150	50	0	0	0
Sweden	3,404	2,655	2,354	1,992	1,630	1,444
France	13,698	12,299	15,995	15,623	17,830	16,474
India	26,000	26,250	26,794	27,191	27,411	28,136
UAEmirates	7,582	6,859	6,137	5,415	4,693	3,971
Bulgaria	1,047	0	0	0	0	0
Austria	0	0	27,363	34,541	42,743	53,295
Switzerland	0	0	0	240,000	240,000	216,000
Multilateral	1,104,846	1,056,670	1,123,202	1,171,367	1,605,385	1,828,950
<b>Нийт үлдэгдэл</b>	<b>2,119,160</b>	<b>2,097,977</b>	<b>2,287,320</b>	<b>2,805,078</b>	<b>3,772,434</b>	<b>4,235,920</b>


*Эх сурвалж: Монгол банк*

2018 оны 12 дугаар сарын 31 байдлаар 15 оронд гадаад зээлийн үлдэгдэлтэй байгаагаас хамгийн их хувийг олон талт гэрээ хэлэлцээрээр авсан зээл 43 хувь, хоёрдугаарт Япон улс 26 хувь, гуравдугаарт Хятад улс 16 хувийг тус тус эзэлж байгаа нь графикаас харагдаж байна.

**Гадаад үнэт цаас:** 2012-2016 онд олон улсын зах зээлд нийт 661.2 сая ам.доллар буюу 1,336.3 тэрбум төгрөгийн гадаад үнэт цаас гаргаж, хүүгийн төлбөрт 718.5 тэрбум төгрөгийг төлж, 2018 оны эцэст Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2,95 тэрбум ам.долларт хүрсэн байна.

*Хүснэгт №3 Засгийн газрын 2012-2017оны хооронд гаргасан бондууд /сая ам доллар/*

№	ЕРӨНХИЙ САЙД	НЭР	ГАРГАСАН ОГНОО	ХҮҮ (%)	ХУГАЦАА	АРИЛЖАА ЛСАНДҮН	ХҮҮГИЙН ТӨЛБӨР	НИЙТ ТӨЛБӨР
1	Н.Алтанхуяг	Чингис-500.0	12/5/2012	4.125	5 жил	500.0 сая \$	103.1 сая \$	603.1 сая \$
2	Н.Алтанхуяг	Чингис-1,000.0	12/5/2012	5.125	10 жил	1,000.0 сая	512.5 сая \$	1,512.5 сая
3	Ч.Сайханбилэг	Дим сам	6/30/2015	7.5	3 жил	161.2 сая \$	28.8 сая \$	190.0 сая \$
4	Ч.Сайханбилэг	Мазаалай	4/6/2016	10.875	5 жил	500.0 сая \$	271.9 сая \$	771.9 сая \$
5	Ч.Сайханбилэг	Кредит Свисс	3/15/2016	6.25%+LIB	5 жил	250.0 сая \$	73.8 сая \$	323.8 сая \$
6	Ж.Эрдэнэбат	Хуралдай	3/9/2017	8.75	7 жил	600.0 сая \$	367.5 сая \$	967.5 сая \$



**Засгийн газрын баталгаа:** Монгол Улсын Засгийн газраас аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тэдгээрийн гадаад эх үүсвэрээс авсан өрийн хэрэгсэлд холбогдох хууль, эрхзүйн хүрээнд 2012 оноос 2018 онд нийт Засгийн газрын 11 баталгаа гаргаж, 2018 оны эцэст Монгол Улсын нийт өрийн 5.1 хувь буюу баталгаат зээллэгийн үлдэгдэл **1,560.1** тэрбум төгрөгт хүрсэн байна.

*Хүснэгт №4 Засгийн газрын 2012-2016 онд гаргасан баталгаанууд /сая ам.доллар/*

№	ЕРӨНХИЙ	БАТАЛГАА	БАТАЛГАА	ДҮН	ХҮҮ (%)	ХУГАЦАА
1	С.Батболд	Монгол Улсын Хөгжлийн банк	2012.03.21	\$580 сая	5.75%	5 жил
2	Н.Алтанхуяг	Монгол Иргэний Агаарын Тээвэр	2013.12.24	\$77.5 сая	2.52%	10 жил
3	Н.Алтанхуяг	Монгол Иргэний Агаарын Тээвэр	2013.12.24	\$24.0 сая	5.3%+ (LIBOR)	7 жил
4	Н.Алтанхуяг	Монгол Иргэний Агаарын Тээвэр	2013.12.24	\$20.0 сая	9.38%+ (LIBOR)	5 жил
5	Н.Алтанхуяг	Монгол Улсын Хөгжлийн банк	2014.01.06	¥30 тэрбум	1.52%	10 жил
6	Н.Алтанхуяг	Монгол Улсын Хөгжлийн банк	2014.09.03	\$162.0 сая	6%	8 жил
7	Н.Алтанхуяг	Монгол Улсын Хөгжлийн банк	2014.09.05	\$300.0 сая	4.375%+ (LIBOR)	5 жил
8	Ч.Сайханбилэг	Худалдаа хөгжлийн банк	2015.05.19	\$500.0 сая	9.38%	5 жил
9	Ч.Сайханбилэг	ГБНБ ХХК	2016.05.01	₮2.7 тэрбум	19%	7 сар
10	Ч.Сайханбилэг	Монгол Улсын Хөгжлийн банк	2016.06.15	\$65.4 сая	7.0%+LIBOR 3	6 сар
11	Ч.Сайханбилэг	Эрдэнэс Монгол	2016.04.01	\$35.0 сая	0.6%+ (LIBOR)	15 жил

*Эх сурвалж: Сангийн яам*


Хүснэгт №5 Засгийн газрын 2018 оны жилийн эцсийн баталгаанууд  
/тэр бүм төгрөг/

<b>БАТАЛГАА ГАРГУУЛАГЧ</b>	<b>Дүн /тэрбум ₮/</b>
Монгол Улсын Хөгжлийн банк	1379.3
Эрдэнэс Монгол ХХК	17.2
Монголын иргэний агаарын тээвэр	163.6
<b>НИЙТ ДҮН</b>	<b>1.560.10</b>

Эх сурвалж: Сангийн яам

Эдгээр тоон мэдээллүүдээс харахад Монгол Улсын Засгийн газрын нийт өр нь засгийн газрын гадаад өр дээр засгийн газрын дотоод өрийг нэмэхэд харагдах болно. Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсээр 22,4 их наяд төгрөг болж ДНБ-ий 58,9 хувьтай тэнцэж байна. Үүний 84 хувийг гадаад өр, 10,6 хувийг дотоод өр, 5.1 хувийг өрийн баталгаа эзэлж байна.

Засгийн газрын гадаад өр	18,860,042,128,000.00₮	84.3%
Засгийн газрын дотоод өр	2,370,709,990,000.00₮	10.6%
Өрийн баталгаа	1,130,725,954,000.00₮	5.1%
<b>Нийт Засгийн газрын өр</b>	<b>22,361,478,072,000.00₮</b>	<b>100%</b>



### 3. Монгол Улсын гадаад өрийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ

Төсвийн тогтвортой байдлын тухай 6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх<sup>41</sup>. Монгол Улсын өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.13.“өрийн хязгаар”<sup>42</sup> гэж Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх дээд хэмжээг хувьчлан тогтоосныг мөн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Засгийн газрын өрийн хязгаар Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагад нийцсэн байна. Төсвийн тогтвортой байдлын тухай 6.1.4.Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байна гэж тус тус хуульчилсан.

2018 оны байдлаар монгол улсын өрийн нөхцөл байдлыг авч үзвэл өрийн тогтвортой байдлын 1 индикатор үзүүлэлт (Гадаад өр/ДНБ )-ээс харахад сэрэмжлэх түвшинг давсан байгаа монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

Засгийн газрын гадаад өрийн тогтвортой байдлыг дэлхийн банк болон ОУВС-аас тухайн улсын бодлого болон институцийн чадамжид харгалзах өрийн сэрэмжлэх түвшинг тогтоосон байдаг<sup>43</sup>. CPIA буюу улсын бодлого, институцийн үнэлгээ нь улсуудыг 1-6 оноогоор үнэлдэг ба үнэлгээ өндөр байх нь тухайн улсын бодлого болон институц сайн байгааг илэрхийлдэг.

<sup>41</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай 6.1.4 дэх хэсэг

<sup>42</sup> Монгол Улсын Өрийн Удирдлагын Тухай хуулийн 4.1.13

<sup>43</sup> Бага орлоготой улсуудын өрийн тогтвортой байдлын хүрээг шинжлэх нь, Судалгааны ажил, ОУВС болон Дэлхийн банк

	Улсын бодлого, институцийн үнэлгээ (CPIA)
Сул бодлоготой	CPIA ≤ 3,25
Хэвийн бодлого	3,25 < CPIA ≤ 3,75
Хүчтэй бодлого	CPIA ≥ 3,75

ОУВС, Дэлхийн банкнаас гадаад өрийн тогтвортой байдлыг дүгнэх 5 шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг зөвлөдөг. Өөрөөр хэлбэл, уг 5 үзүүлэлтээр гадаад өрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг хэмждэг юм.

	Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн өрийн эзлэх хувь			Өрийн үйлчилгээний төлбөрийн эзлэх хувь	
	экспорт	ДНБ	ЗГ-н орлого	экспорт	ЗГ-ын орлого
Сул орлоготой	100	30	200	15	18
Хэвийн орлоготой	150	40	250	20	20
Хүчтэй орлоготой	200	50	300	25	22

*Эх сурвалж: Бага орлоготой улсуудын өрийн тогтвортой байдлын хүрээг шинжлэх нь, Судалгааны ажил, ОУВС болон Дэлхийн банк*

Дэлхийн банкны CPIA буюу улсын бодлого, институцийн үнэлгээгээр манай улс 3.4 үнэлгээ авсан ба уг үнэлгээнд харгалзах өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн гадаад өрийн хязгааруудыг дээрх хүснэгтэд харуулав. 2013-2018 оны жилийн эцийн байдлаарх өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг хүснэгт №3-т үзүүлэв. Үүнээс харахад, Монгол Улсын Засгийн газрын өрийн тогтворгүй байдал үүсч сэрэмжлэх түвшинд хүрсэн байна.

*Хүснэгт №1 Өрийн тогтвортой байдлын ДНБ индикатор үзүүлэлт*

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	Сэрэмжлүүлэх түвшин
Гадаад өр/нэрлэсэн ДНБ	27.4	33.2	36.3	53.7	57.0	58.9	40

*Эх сурвалж: Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ, Тэмдэглэл: Хувиар*

**Дүгнэлт:** Манай улс 2016-2018 онуудын байдлаар өрийн тогтвортой байдлын 1 индикатор үзүүлэлт (Гадаад өр/ДНБ)-ийг хангаагүй<sup>44</sup> байгаа нь өрийн удирдлага тогтвортой хэрэгжиж чадаагүй, зохистой түвшин алдагдсан, өрийн дарамтад орох эрсдэлтэй байгааг харуулж байна.

<sup>44</sup> Олон улсын жишгээр 3 нь хангагдаагүй тохиолдолд тухайн улсыг өрийн дарамтад орох эрсдэлтэй гэж үздэг

## МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.Оюунболд  
ХСИС-ийн магистрант

**Товч агуулга:** Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой анхаарч ирсэн.

Энэ өгүүлэлээр мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх талаар хэрэгжүүлж ирсэн 4 үндсэн чиглэлд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно. Үүнд: Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх бодлого, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлого, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх бодлого, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ зэрэг болно. Судалгааны дүнгээс харахад, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно.

**Түлхүүр үг:** Мөнгө угаах, ФАТФ, Терроризмыг санхүүжүүлэх, Санхүүгийн мэдээллийн алба.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна, төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”<sup>45</sup>, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлж эдийн засгийг зохицуулна”, Арван зургаадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэд хувийн аж ахуй эрхлэх” эрхтэй гэж гэсэн заалтын дагуу зах зээлийн эдийн засаг өөрийн дотоод хуулиар хөгжихөд нь төрөөс дэмжин, тэнцвэртэй байдлаа хадгалах, тогтвортой өсөлтийг хангах, хямрал, эрсдэлд өртөхгүй дархлаатай байх нөхцөлүүдийг бүрдүүлэх эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой авч байх төрийн зохицуулалтын механизм, бодлоготой байх шаардлагатай.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлалд бусад хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой анхаарч, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход бодлогын хэмжээнд анхаарч шат дараалсан олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдаг.

### **а) Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх бодлого**

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг Монгол Улс дагаж мөрдөх үүрэг хүлээсэн. Тодруулбал, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц, Авилгалын эсрэг НҮБ-ын 2003 оны конвенц, Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай 1999 оны конвенцид тус тус нэгдэж, мөрдөж байна.<sup>46</sup>

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 7 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ<sup>47</sup>, Авилгалын эсрэг конвенцын 14 дүгээр зүйлд мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тусгайлан заасан<sup>48</sup> бөгөөд эдгээр арга хэмжээг конвенцийн гишүүн орон хэрэгжүүлэх үүрэгтэй.

<sup>45</sup> Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг.

<sup>46</sup> - Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцид 2001.01.25-ны өдөр нэгдэн орж, 2003.06.25-ны өдрөөс,

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенцид 2008.05.16-ны өдөр нэгдэн орж, 2008.06.27-ны өдрөөс эхлэн,

- Авилгалын эсрэг НҮБ-ын 2003 оны конвенцид 2005.10.27-ны өдөр нэгдэж, 2006.01.11-ний өдрөөс,

- Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай 1999 оны конвенцид 2003.12.13-ны өдөр нэгдэж, 2004.2.25-ны өдрөөс эхлэн тус тус мөрдөж байна

Монгол Улсын Гадаад харилцааны яам. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний жагсаалт. 2015 оны 12 дугаар сар [http://www.mfa.gov.mn/?page\\_id=29040#1485132523196-a01c7d09-78b5](http://www.mfa.gov.mn/?page_id=29040#1485132523196-a01c7d09-78b5)

<sup>47</sup> United Nations Convention Against Transnational Organized Crime and the Protocols Thereto <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>

<sup>48</sup> United Nations Convention Against Corruption [https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026\\_E.pdf](https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf)

Үүнээс гадна, НҮБ-ын Гэмт хэргээс сэргийлэх, мансууруулах бодисыг хянах албанаас Олон улсын валютын сантай хамтран 2005 онд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай загвар хууль<sup>49</sup>, 2009 онд нийтлэг эрх зүйн бүлийн орнуудад зориулан мөнгө угаах, террористуудыг санхүүжүүлэх гэмт хэрэг, гэмт хэргээс олсон орлогыг ашиглахаас сэргийлэх арга хэмжээний загвар зүйл, заалтыг бэлтгэж, хүртээл болгосон.<sup>50</sup>

Түүнчлэн, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага буюу ФАТФ-аас 2012 онд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт буюу ФАТФ-ын 40 зөвлөмж гаргасан.<sup>51</sup> Тус зөвлөмжийн 1, 2-т мөнгө угаах гэмт хэргийн талаар тусгасан.

Монгол Улсын хувьд, дээр дурдсан конвенцоор хүлээсэн үүрэг, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын стандартын дагуу “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг 2002 онд, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг 2006, 2013 онд, Авлигын эсрэг хуулийг 2006 онд тус тус баталж, мөрдөж байна. Үүнээс гадна, Эрүүгийн хуульд “мөнгө угаах”, “мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”, “хээл хахууль авах”, “хээл хахууль өгөх”, “хээл хахууль зуучлах”, “хууль бусаар хөрөнгөжих” гэмт хэргийг тус тус хуульчилсан.

Монгол Улсын Их Хурал Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг 2006 онд баталснаар Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үндэс суурь тавигдсан билээ. Тус хуульд Санхүүгийн мэдээллийн албыг “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс Сэжигтэй гүйлгээний тайлан, Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн талаарх мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага” хэмээн тодорхойлсон байдаг бөгөөд тус хуулийн 18.1-д заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

-Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх;

-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэслэлтэй гэж үзвэл мэдээллийг хуульд заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлэх, шилжүүлсэн гүйлгээний талаар мэдээллийн сан бүрдүүлэх;

-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах, сэжигтэй гүйлгээг хянах, илрүүлэх аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг нь зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Ийнхүү СМА нь хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс тайлан хүлээн авч дүн шинжилгээ хийх, дотоодын холбогдох байгууллагуудтай мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр лавлагаа, мэдээлэл солилцох журмаар хамтран ажиллаж эхэлсэн.

МУТСТ тухай хуульд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд 15 байгууллагын төлөөллөөс бүрдсэн Хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулсан. Санхүүгийн мэдээллийн алба нь Дэлхийн Санхүүгийн тагнуулын албадын олон улсын нийгэмлэг (EGMONT буюу Эгмонт)-т 2009 онд элссэнээр гадны улс орны ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой болсон.

1997 онд байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн байгууллага (The Asia/Pacific Group on Money Laundering буюу АНДББ) нь ФАТФ<sup>52</sup>-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах байгууллага билээ.

<sup>49</sup> UNODC and International Monetary Fund, Model Legislation on Money Laundering and Financing of Terrorism (2005) <https://www.unodc.org/documents/money-laundering/2005%20UNODC%20and%20IMF%20Model%20Legislation.pdf>

<sup>50</sup> UNODC, Commonwealth Secretariat and International Monetary Fund, Model Provisions on Money Laundering, Terrorist Financing, Preventive Measures and Proceeds of Crime (for Common Law Systems) (April 2009) [https://www.imolin.org/pdf/imolin/Model\\_Provisions\\_Final.pdf](https://www.imolin.org/pdf/imolin/Model_Provisions_Final.pdf)

<sup>51</sup> FATF (2012-2018), International Standards on Combating Money Laundering and the Financing of Terrorism & Proliferation, FATF, Paris, France, [www.fatf-gafi.org/recommendations.html](http://www.fatf-gafi.org/recommendations.html)

<sup>52</sup> Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. ФАТФ-ын зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгддөг. ФАТФ нь Их долоогийн уулзалтаар 1989 онд байгуулагдсан бөгөөд өнөөдрийн байдлаар 37 гишүүн улс, 3 ажиглагч улс, 9 бүс нутгийн холбоо байгууллага, 23 ажиглагч олон улсын байгууллагаас бүрддэг ба бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн байгууллагын гишүүнээр 2004 онд элссэн бөгөөд 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хууль баталснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлж ФАТФ-ын 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

ФАТФ-аас гаргасан зөвлөмжийг 2012 онд шинэчилсэнтэй холбогдуулан Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэний дагуу 2013 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус шинэчилсэн найруулгаар сэжигтэй гүйлгээг тайлагнах чиг үүргийг илүү боловсронгуй болгож, мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийх хяналт шалгалтыг сайжруулсан төдийгүй хууль, тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг илүү тодорхой болгосон.

Монгол Улсын Их Хурал 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг баталснаар мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүрээг өргөжүүлэн, тэдгээрт хийх хяналт шалгалтыг ФАТФ-ын зөвлөмжид заасны дагуу эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх эрх зүйн үндэсийг тавьсан. Мөн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх болон санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгаж, хүлээх хариуцлагын тогтолцоог сайжруулсан болно.

Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлж Харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг анх Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаар захирамжаар байгуулсан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хуульчилж өгсөн нь Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чухал алхам болсон. Үүнтэй холбогдуулан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 14 дугаартай захирамжаар шинэчлэн баталсан.

ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх, улмаар өөрийн улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулж, чадавхыг бэхжүүлэх замаар санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдлыг хадгалан үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 143 дугаартай тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан болно.

2017 оны 327 дугаар тогтоолоор Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан улс, орон дамнан үйлдэгддэг мөнгө угаах, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг бодлогоор дэмжин ажилласан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (цаашид “ФАТФ” гэх)-ын Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас 2016-2017 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хоёр дахь удаагийн харилцан үнэлгээг хийсэн бөгөөд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 2013-2016 оны хооронд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдийг үнэлж, 2017 оны 9 дүгээр сард үнэлгээний тайланг нийтэлжээ.<sup>53</sup>

#### ***б) Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлого:***

Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 1993-2001 он хүртэл хугацаанд тасралтгүй нэмэлт өөрчлөлт оруулсан. Хэдийгээр энэ мэтээр зарим нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж байсан боловч тухайн үеийн эрүүгийн хуулийн зохицуулалт нь эдийн засаг, банк, санхүү, аж ахуйн хүрээнд гардаг эдийн гэмт хэрэгтэй хийх тэмцлийн чиг хандлагаас хоцорч байсан нь эрүүгийн хуулийг бүхэлд нь шинэчлэх нэг үндэслэл болсон.

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр батлаж, улмаар мөн оны 9-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хуульд шунахайн сэдэлттэй гэмт хэргүүдийг анх удаа “Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг”-гэсэн 7 дугаар хэсэгт хамааруулж, 19, 20 дугаар бүлэг “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т 11 гэмт хэрэг, “Аж ахуйн эсрэг гэмт

<sup>53</sup> Asia/Pacific Group on Money Laundering (APG). Anti-money laundering and counter-terrorist financing measures: Mongolia. Mutual Evaluation Report. September 2017



хэрэг”-т 19 гэмт хэргийг тус тус хуульчилсан нь хууль тогтоогч эдийн засгийн гэмт хэрэг гэсэн ойлголтыг дээрх гэмт хэргүүдээр төлөөлүүлэн авч үзсэн байна<sup>54</sup>. аж ахуйн эсрэг гэмт хэргийн бүлэг, эрүүгийн хуулийн тусгай ангийн 162 дугаар зүйлд байсан мөнгө угаах гэмт хэргийг “Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх нэрээр халхавчлан хууль бус үйл ажиллагаа явуулах” гэмт хэрэг гэж тодорхойлж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Хууль үйлчлэх явцад хийдэл, хэрэглэхэд хүндрэлтэй бусад асуудал байнга гарч түүнийг арилгах зарим хэм хэмжээг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага гардаг нийтлэг зүй тогтлын дагуу Монгол Улсын их хурлаас 2002 оны эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр баталж, тус хуулийн 268<sup>1</sup> дугаар зүйлд “Мөнгө угаах”, 178<sup>2</sup> дугаар зүйлд “Терроризмийг санхүүжүүлэх” үйлдлүүдийг шинээр гэмт хэрэгт тооцсон боловч гэмт хэргийн шинжийг тодорхойлох зарим үйлдлүүдийг орхигдуулсантай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд хүндрэл учирч байсан.

Хууль бусаар олсон бохир орлогоор гэмт бүлэглэлүүд өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс гадна дараа дараагийн гэмт үйлдэлдээ хөрөнгө оруулалт хийдэг нь дэлхий нийтийн жишиг болж байгааг харгалзан 2015 оны эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаын 18.6 дугаар зүйлд “Мөнгө угаах гэмт хэрэг”-ийг олон улсын гэрээ, конвенцийн шаардлагад бүрэн нийцүүлэх байдлаар хуульчилсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрэн бүрдэж мөнгө угаах гэмт хэрэг болон түүний суурь гэмт хэргийг мөрдөн шалгаж шүүхээс шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;

2.2.байнга тогтвортой үйлдэж;

2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхээр заажээ.

#### **в) Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогод өгөх үнэлгээ:**

ФАТФ болон түүнтэй ижил төрлийн бүс нутгийн олон улсын байгууллагууд нь гишүүн улс орнуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлж хянадаг.

Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны анхны Харилцан үнэлгээг 2007 онд зохион хийсэн билээ. Энэ Харилцан үнэлгээний тайланд Монгол Улс ФАТФ-ын 40 үндсэн, 9 тусгай шалгуураас 21 биелүүлээгүй, 15 хэсэгчилэн биелүүлсэн гэсэн үнэлгээ авч байсан. Энэ үр дүнгээс шалтгаалан 2011 онд Олон улсын хамтын ажиллагааг хянах бүлэг (International Cooperation Review Group буюу ОУХАХБ)-ээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог өөрийн хяналтад оруулахаар болж, улмаар 2013 онд Монгол Улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орж байсан. Энэ жагсаалтад орох үед Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлттэй, гадаад нэр хүнд сайн байсан зэрэг шалтгаанаас эдийн засагт учирсан бодит хохирол харьцангуй бага байсан. Монгол Улсын Улсын Их Хурал, Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох журам, зааврыг

<sup>54</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль- Төрийн мэдээлэл, УБ, 2002 он, №5-д нийтлэгдсэн

богино хугацаанд батлуулсны үр дүнд 2014 оны 6 дугаар сард ФАТФ-ын “саарал жагсаалт”-аас гарсан байдаг.

Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас 2016-2017 онд хоёр дахь удаагийн үнэлгээг хийсэн. Энэхүү Харилцан үнэлгээ нь 2012 онд ФАТФ-аас гаргасан 40 Зөвлөмжийн дагуу Техникийн хэрэгжилт (хууль, эрх зүй болон үйл ажиллагааны тогтолцоо) болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны Үр дүнтэй байдлыг (хэрэгжилтийн түвшин) үнэлдэг шинэчилсэн аргачлаал явагдсан болно.

Харилцан үнэлгээгээр Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр 2013-2016 оны хооронд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдийг үнэлж, дүгнэлт өгсөн байгаа. 2017 оны 7 дугаар сард хуралдсан Ази, Номхон далайн бүсийн байгууллагын жилийн чуулганы үеэр хоёр дахь удаагийн Харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж, Монгол Улсыг “эрчимтэй хяналтад” оруулах шийдвэр гаргасан ба 2017 оны 7 дугаар сард Харилцан үнэлгээний тайланг<sup>55</sup> баталж нийтэлсэн болно.

Ази, Номхон далайн бүсийн байгууллага болон Олон улсын валютын сангийн холбогдох албан тушаалтнууд 2017 оны 8 дугаар сард Монгол Улсад айлчлан, ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орохгүй байх, орсон тохиолдолд “саарал жагсаалт”-аас аль болох богино хугацаанд гарахтай холбогдуулан нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж гаргаж өгч, 2018 оны 10 дугаар сараас өмнө хэрэгжүүлэх, явцыг тухай бүр тайлагнахыг үүрэг болгосон. Энэ зөвлөмжийн дагуу СМА-ны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөл болон МУТСТ Үндэсний зөвлөл хамтран “АНДББ-аас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулж, Монгол Улсын Засгийн газраар 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 327 дугаар тогтоолоор батлуулсан. Тус төлөвлөгөө нь:

- Хууль эрх зүйн орчин, зохицуулалтыг сайжруулах
- Ерөнхий зохицуулалт, зохион байгуулалт
- Хууль сахиулах байгууллагуудаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Санхүүгийн мэдээллийн алба болон бусад байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн 5 бүлэгтэй бөгөөд эдгээр бүлэгт багтах 42 төрлийн ажлыг Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, ХАЗ, Үндэсний зөвлөл гээд 22 яам, агентлаг, зөвлөл хамтран ажлын төлөвлөгөөнд заасан хугацаанд нь хийж гүйцэтгэх, явцыг тайлагнах үүрэг хүлээсэн болно.

Монгол банк, ХЗДХЯ болон СМА-ны зүгээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Терроризмтой тэмцэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Шуудангийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг ОУВС-ийн зөвлөхүүдийн саналыг тусгаж боловсруулан, холбогдох байгууллагуудаас санал авч, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, СМА-ны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газарт өргөн барьсан бөгөөд УИХ 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон дээр дурдсан дагалдах хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан.

Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах зорилгоор АНУ-ын Сангийн яамны Техник туслалцааны алба, Австрали Улсын Дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк, ОУВС болон НҮБ зэрэг гадаад улс, олон улсын байгууллагаас техникийн туслалцаа авах, уулзалт, сургалтуудыг зохион байгуулах чиглэлээр тогтмол хамтран ажиллаж байна.

### ***г) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний тогтолцоо, чиг үүрэг:***

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний тогтолцоо дараах байдлаар ажилладаг. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчин, хууль тогтоох ажиллагаа
2. Төрийн хяналт шалгалт /Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах/
3. Зөрчил шалгах ажиллагаа /Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зөрчлийн хуульд

<sup>55</sup> <http://www.fatf-gafi.org/publications/mutualevaluations/documents/mer-mongolia-2017.html>

заасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх/

4.Сэжигтэй гүйлгээ, харилцагчийг таних ажиллагаа

5.Сэжигтэй гүйлгээг мэдээлэх, дотоод хяналт /банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатч/

6.Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний үр дүнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх

7.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих /Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн алба/

8.Мөнгө угаах гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх суурь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах /Тагнуул, Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар/

9.Мөнгө угаах гэмт хэрэг болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх суурь гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт

10.Мөнгө угаах гэмт хэрэг болон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх суурь гэмт хэрэг, зөрчлийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа

11.Хамтын ажиллагаа /Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны зөвлөл ажиллана. Тус зөвлөлд гадаад харилцаа, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, прокурорын байгууллага, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, эрх бүхий хууль хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, гаалийн байгууллага, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл багтана.

### **Дүгнэлт**

Мөнгө угаах гэмт хэргийн улс дамнасан шинжээс хамаарч хянан шийдвэрлэх ажиллагаанд өөр улсаас баримт сэлт цуглуулах, авах шаардлага бий болдог. Олон улсын хамтын ажиллагаа нь энэхүү үйл явцын чухал хэсэг боловч уг ажиллагаа нь ихэнх хууль сахиулах байгууллагын ажилтануудын хувьд тулгамдсан асуудал болж байна. Бүх улс орон шаардлагатай гэрээ, хэлэлцээр, конвенцид нэгдэн орохоос гадна доорх зүйлийг анхаарч үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Дотоодын хууль тогтоомж, үйл ажиллагааны уян хатан байдлыг хангаж, мөрдөн байцаах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн харилцан туслалцааг хамгийн өргөн хүрээнд үзүүлж, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүлээн авахаас татгалзах үндэслэлийг хязгаарлах шаардлагатай;
- Улс орнуудын хооронд албан ба албан бус хамтын ажиллагааг хөнгөвчлөх сүлжээний талаар хууль сахиулах байгууллагын ажилтануудад мэдээлэл өгөх, тэднийг гишүүнээр элсэхэд нь туслалцаа үзүүлэх;
- Эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт боловсруулах ажлын чанарыг сайжруулах зорилгын хүрээнд хууль сахиулах байгууллагын ажилтануудад эрх зүйн харилцан туслалцааны тухай зааварчилгаа өгөх, сургалтанд хамруулах.

## ХУВЬ ХҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ө.Жавхлан

ХСИС-ийн магистрант, цагдаагийн ахмад

**Товч агуулга:** Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын Монгол Улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнд үндэслэн хувь мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга замын талаар санал, зөвлөмж боловсруулсан.

**Түлхүүр үг:** Мэдээллийн аюулгүй байдал, хувь хүн, аюулгүй байдал, мэдээлэл.

### Оршил

Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн үзэж байсан бол аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томъёолж оршин тогтнохуйн аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хүний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал гэсэн зургаан чиглэлээр цогц хэлбэрээр харилцан уялдаатай хангах гол арга замуудыг тодорхойлсон юм.

Мэдээллийн аюулгүй байдал бүх улс оронд үндэсний аюулгүй байдлынх нь хэмжээнд яригддаг. Ялангуяа, иргэдийнх нь талаарх мэдээлэл асар их үнэ цэнэтэй. Улс орон, иргэдийн мэдээллийг хадгалж байгаа газар халдлагын гол объект болчихдог. Тэгэхээр ажиллаж эхэлсэн цагаасаа л эрсдэл дунд байна гэсэн үг. Сүүлийн жилүүдэд манай улсад цахим засаглал, цахим эдийн засаг, цахим банк, дижитал шилжилт хэмээх мэдээллийн технологийн хөгжил ихээхэн амжилттай нэвтэрч эхэлсэн. Эдгээр шинэ нэр томъёо нь бидэнд аль хэдийн танил болсон ч мэдээллийн эрин зуунд өдрөөр биш цагаар хувьсан өөрчлөгдөж буй техник технологи, сүлжээ, программ хангамж, цахим тооцоолол, дижитал технологийн үйл ажиллагаанд шилжихэд төр болон хувийн хэвшил бэлэн үү? гэсэн асуулт урган гарна.

Дээрх үйл ажиллагаанд мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар хууль эрх зүйн орчинг тодорхой болгох шаардлагатай.

Орчин үед хувь хүний нууцыг (privacy) өндөрт тавьдаг болсон нь хүний эрхийг дээдлэхээс гадна хувь хүний нууц, байгууллагын үйл ажиллагаа төдийгүй үндэсний аюулгүй (national security) байдалд нөлөөлдөгт оршино хэмээн үзжээ.

Хүмүүс мэдээллийн харилцаа, холбооны салбарын хөгжил хүчээ авсан энэ үед, асар богино хугацаанд маш их мэдээлэл, мөнгө алдаж болох нөхцөл бүрдснээр энэ асуудал улам бүр хурцаар тавигдаж байна<sup>56</sup>.

Өнөөдрийн байдлаар үүрэн холбооны компанид бид утасны дугаар авахдаа өөрийн мэдээллээ өгч бүртгүүлдэг. Мөн банк, санхүүгийн болон даатгал, эрүүл мэндийн байгууллагуудад хувь хүмүүсийн бүхий л мэдээлэл төвлөрдөг.

Эндээс үзэхэд хүний хувийн шинж чанартай мэдээллүүдийг олон байгууллага эзэмшээд эхэлсэн. Нэг ёсондоо олон байгууллага, хувийн хэвшилд иргэдийн маш хэмжээний мэдээллийн бөөгнөрөл бий болсон. Гэтэл “тэд мэдээллийн баазаа алдвал яах вэ?”, энэ талаар ямар хариуцлага хүлээх нь тодорхойгүй байгаа<sup>57</sup>.

Өнөөдөр өгөгдлийн сандаа байгаа бүх харилцагчдынхаа мэдээллийг алдчихвал хариуцлага хүлээх тогтолцоо алга. Иймд үүнийг хууль эрх зүйн хүрээнд цэгцэлж тодорхой болгох шаардлагатай юм. Энэ бол яах аргагүй тулгамдсан асуудал болсон учир энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд хувийн мэдээллээ бусдад алдахаас сэргийлж утас болон компьютертоо үргэлж нууц үг хийж байхыг зөвлөдөг.

Бидний амьдарч буй өнөөгийн нийгэм компьютерээс “төгс” хамааралтай болсон гэхэд бараг л хилсдэхгүй. Үүнийгээ дагаад сайн бас сөрөг тал ч гарч ирсээр байгааг анхаарах цаг нэгэнт иржээ. Өдгөө 8 настай балчираас 80 настай буурлууд хүртэл компьютерийн хүрээнд зарим үйлдлийг хийсээр байна. Гэвч ямар үйлдлээсээ үл хамаарч цахим гэмт хэргийн золиос болж магадгүй байдал бий болчихоод байгааг анхааруулах нь зүйтэй.

<sup>56</sup> (Гантулга.Ё.Австрали улс.<http://qantulga.wordpress.com>)

<sup>57</sup> (Чинзориг.Г.Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Шинэлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын даргатай хийсэн ярилцлага.УБ. <http://www.assa.mn>)

Хүмүүсийн аюулгүй байдлаа хамгаалж ирсэн түүхэн туршлага, мэдлэг нь он цагийн явцад аюулгүй байдлын бие даасан шинжлэх ухаан болон хөгжиж иржээ.

Хувь хүн, байгууллагад “тодорхой” хэмжээгээр нууц байх шаардлагатайн адилаар аливаа тусгаар тогтносон Улс орон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс төрийн зарим хэргийг нууцлах зайлшгүй шаардлага гардаг.

Америкийн нэгдсэн улсын Оксфордын судлаачдын үзсэнээр нэг хувь хүний орчинд 128 мега байт дата өгөгдөл байдаг бөгөөд тэдгээр өгөгдлийг цуглуулдаг, хадгаладаг төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дата бааз тогмтол халдлагад өртдөг талаар дурьдсан байна.

Сүүлийн үед интернэт, гар утас хөгжихийн хэрээр тус улсад хувийн мэдээлэл алдагдах, буруугаар ашиглагдах магадлал улам бүр өсч байдаг учир иргэд өөрсдийн хувийн мэдээллийг цахим халдлагаас хамгаалах зорилгоор төрөл бүрийн хамгаалалтын апп болон хамгаалалтын системийг нэвтрүүлж байна.

## **1.ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМГААЛАЛТЫН ОНОЛ**

Аюулгүй байдлын онолын тухай ойлголт нь хувь хүний аюулгүй байдлын тухай ойлголттой салшгүй холбоотой бөгөөд энэхүү салбар шинжлэх ухааныг судлахын өмнө аюулгүй байдал гэсэн өргөн ойлголтоос хувь хүний аюулгүй байдал гэж юу болох, аюулгүй байдал судлалын уламжлалт сэтгэлгээ, эрдэмтэн судлаачдын онол дээр тулгуурлан хувийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар авч үзэх нь зүйтэй юм.

Хүн төрөлхтний үүсэл хөгжлийн бүхий л үе шатанд хувь хүн, нийгэм, улс орон, бүс нутгийн үйл ажиллагаа, амьдралын явцад тэдгээрийн салшгүй дагуул нь аюул занал байсаар ирсэн. Аюулгүй байдлын асуудалд төдийлөн анхаарал тавьж байгаагүйгээс өрх гэр, хамтын амьдрал, компани, нийгэм, улс орон бутран сөнөж, дайн самуун дэгдэж, гай гамшиг тарьж байв.

Өргөн утгаараа аюулгүй байдал гэсэн ойлголт нь аливаа нийгмийн хүрээнд иргэдэд өөрийгөө илэрхийлэх, хөгжих, соёлжсон ертөнцөд амьдрах нөхцлийг бүрдүүлж өгөхөд оршиж байна. Энэ үзэл баримтлал, үзэл санааг судлаачдын ихэнх нь дэмждэг бөгөөд аюулгүй байдал гэдэг нь нийгмийн янз бүрийн систем болон хувь хүн өөрийгөө эрчимтэй үр дүнтэй, үр ашигтай хөгжүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хүчин зүйл, нөхцөл шалтгааны цогц бүрэлдэхүүн гэж үзсэн. Эндээс нэгтгэн дүгнэхэд, аюулгүй байдал гэдгийг төр, нийгэм, бие хүний (иргэний) аюулгүй байдал гэж томъёолон “тэдгээрийн түүхэн тодорхой нөхцөлд гадаад, дотоодын бодит байдал болон болзошгүй аюулаас үндэсний язгуур эрх ашиг найдвартай хамгаалагдсан байх явдал юм” гэж тодорхойлж болох юм.

Хүний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдалтай нягт уялдаатай түүнийг бэхжүүлэн баталгаажуулж, хүний хөгжлийг сайжруулж, хүний эрхийг дээдлэн өргөжүүлэхэд оршино. Хүний аюулгүй байдлыг хүний амьдралын бүхий л хэрэгцээ, эрх чөлөөг хангах амин чухал үндсийг хамгаалах явдал мөн<sup>58</sup> гэж тодорхойлж болох юм.

Хувь хүний аюулгүй байдал гэж амьдрал, эрүүл мэнд, эд хөрөнгийнхөө төлөө өөрийгөө аюул, заналаас халхлах, чөлөөлөх, тэрчлэн иргэн хүний суурь үнэт зүйл болох хуульчилсан эрх, эрх чөлөөг хамгаалах улс, нийгэм, бие хүний чадвар бэлэн байдал юм.

*XXI зуун бол мэдээллийн эрин зуун. Хэнд мэдээлэл байна, тэр хүнд давуу тал байна. Хэн мэдээллээ алдана, тэр давуу талаа алдаж байна. Тэгвэл бид мэдээлэл гэдгээс гадна аюулгүй байдал гэж юу болох талаар судлах шаардлага бий болно.*

Мэдээллийн эрин зуун, мэдээлэл бол хаан гэх үгс өнөө цагийнх. Мэдээлэлтэй хүн хүчтэй гэдэг шиг мэдээлэлтэй хувь хүн, компани зах зээл, нийгэмд илүү давуу байр суурь эзлэх боломж бүрддэг. Мэдээллийн аюулгүй байдал гэхээр ихэнх иргэд хакердуулах, халдлагад өртөх гэх мэт гадаад хүчин зүйлсийг хамгийн эхэнд боддог. Энэ нь зүй ёсны хэрэг боловч мэдээллийн урсгал гаднаас дотогш, дотроос гадагш гэсэн хоёр үндсэн урсгалтайг хэзээ ч мартаж болохгүй.

**Хувийн мэдээлэл гэдэг нь** тодорхой эсвэл тодорхойлогдох боломжтой бодит хүмүүсийн хувийн мэдээлэл юм. Жишээ нь: Таны нэр, хаяг, дансны дугаар, иргэний үнэмлэхний дугаар, утасны дугаар, машины аралын дугаар, и-мэйл хаяг, эсвэл IP дугаар гэх зэрэг мэдээллүүд юм. Харин хувийн бус мэдээлэлд гэдэгт тухайн өгөгдлөөр таныг тодорхойлох боломжгүй мэдээллийг хэлнэ. Үүнд та ямар хүйсийн хүн болох, ямар хөтөч програм ашиглаж байгаа, эсвэл аль хувилбарыг ашиглаж буй гэх мэт ерөнхий мэдээлэл орно.

<sup>58</sup> (Улаанхүү.Ч Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016)

Эндээс хувийн мэдээллийг хамгаалах анхдагч эх сурвалж нь мэдээлэл өөрөө нууц байх явдал юм. Тэгвэл бид хувийн нууц гэх ойлголтыг авч үзэх хэрэгтэй болно.

Хувь хүн нь өөртөө аливаа төрлийн мэдээллийг агуулж байдаг бөгөөд тэдгээр мэдээллийн үнэ цэнэ, цар хүрээгээс шалтгаалж мэдээллийг хамгаалах хамгийн энгийн буюу анхдагч хамгаалалтын нэг төрөл нь хувь хүн мэдээллээ нууцлах явдал юм. Бид өдөр тутамдаа өөрийн виза карт, цахим банк, ухаалаг утас ашиглах явцдаа мэдээллийн аюулгүй байдлаа хангахыг тулд аюулгүй байдлыг сайжруулах бусад аргуудыг ашигладаг. Нууц үг болон банк, вебсайтуудаас тавьдаг аюулгүйн асуултууд зэргийг зөв хэрэглэж чадах юм бол нэмэлт хамгаалалт болж чадна.

**Хувийн аюулгүй байдал:** Хувь хүний сэтгэл санаа болон бие махбодын хүчирхийлэл, гэмт хэрэг, терроризм, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг хамтад нь авч үздэг.

Мэдээлэл буюу /data/ бол дан ганц мэдээлэл технологийн үнэт зүйл биш юм, мэдээлэл бол байгууллагын гол стратегийн үнэт зүйл бөгөөд зарим төрлийн мэдээллүүд бусдаасаа илүү их үнэ цэнэтэй байдаг. Бизнесийн нууцын зэрэглэлтэй мэдээллүүд, компаний санхүүтэй холбогдох мэдээлэл зэрэг стратегитэй эн тэнцүү үнэ цэнэтэй. Бизнесийн болон хувь хүний нууц зэрэглэлтэй мэдээллүүдийн 57 % хувь нь гадагш задрах магадлалтай, хамгаалалт маш сул байдаг бол удаах байруудад албан тушаалтнуудын хэрэглэгчийн мэдээллийн 52%, хувь хүний мэдээллүүдийн 49% нь ямар нэгэн хамгаалалтгүй байдаг гэсэн үр дүн гарсан нь ихээхэн сонирхол татаж байна.

Мэдээллийн аюулгүй байдал гэхээр ихэнх хүн зөвхөн IT-тэй холбож ойлгодог. Гэтэл энэ нь маш өргөн хүрээний ойлголт юм.

Мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтнүүдэд кибер халдлагуудыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах зэрэг онцгой үүрэг хариуцлага оногддог. Учир нь итгэл даасан, тодорхой албан тушаалтай ажилтнууд байгууллагын мэдээллийг санаатайгаар гадагш гаргах тохиолдлууд улам бүр нэмэгдсээр байгаа. Ихэнх тохиолдлуудад ажилтнуудыг өөрсдийн үүрэгт ажлаа хийж байна уу гэдгийг тодорхойлоход хэцүү байдаг. Доорх судалгаагаар энгийн ажилтнуудын 56 %, мэдээллийн технологийн инженерүүдийн 55 %, гэрээт байгууллагуудын 42 % нь байгууллагын чухал мэдээллүүдийг гадагш задруулах эрсдэлтэй гэж гарсан байна.

Энэ дэлхий даяар хэрэгждэг мэдээллийн аюулгүй байдлын стандартаар бол мэдээллийг 100 хувь хамгаалах боломжгүй гэсэн дүгнэлт юм.

Олон улсын стандарчлалын байгууллагаас мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO27001 стандартыг батлан гаргасан. Энэ стандартын үзэл баримтлалаар мэдээллийн аюулгүй байдал нь хоорондоо уялдаа бүхий гурван цөм ойлголтын дунд бий болдог.

- Мэдээллийн нууцлал (confidentiality),
- Хүртээмжтэй байдал (availability),
- Үнэн зөв бодитой байх (integrity) гэсэн гурван хүчин зүйл бүрдэж байж сая мэдээллийн аюулгүй байдал хангагдах гэж үзэх юм.

**Хувийн мэдээллийг хамгаалах:** Тухайн мэдээллийг үндэслэн тодорхой хүнтэй (хувийн өгөгдлийн субъект) холбоотой мэдээллийг хамгаалахад чиглэсэн техникийн, зохион байгуулалт, зохион байгуулалтын-техникийн арга хэмжээний багц.

## **2. Монгол Улсад хувийн мэдээллийг хамгаалж байгаа өнөөгийн байдал:**

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Сүүлийн жилүүдэд манай улсад хувь хүний нууцыг задруулах замаар доромжилсон, бодит баримтад тулгуурлахгүйгээр хүнийг буруутгасан, гүтгэсэн тохиолдол ихээр бүртгэгдэх болсон.

Хувь хүний талаар буруу ташаа мэдээлсэн, хүний хувийн амьдралтай холбоотой асуудлаар мэдээлэл хийх нь түгээмэл болж энэ байдал нь даамжирсаар Эрүүгийн хэрэгт тооцогдохгүй, зөрчлийн шинжтэй асуудал болж хувирсан нь манай улсын хувьд энэ салбарын хуулийн хамгаалалт ямар сул байгааг харуулж байна.

Ихэнх тохиолдолд хувийн мэдээлэл задруулагч нь тухайн хүний эсрэг чиглэсэн түүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой идэвхитэй үйлдэл байдаг бол санамсаргүй байдлаасаа болж хувь хүний мэдээллийг гадагш нь задруулах тохиолдол ч байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал<sup>59</sup>-ын 3.6-д “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс” гэж, 3.6.1.5-д “Мэдээллийн аюулгүй байдлын үндэсний хэмжээний бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоог бий болгож, нийгэм дэх ойлголт, мэдлэгийг төлөвшүүлнэ” гэж, 3.6.1.11-д “Кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, аливаа гэмт хэргийг илрүүлэх, нотлоход тооцоолох хэрэгслийн криминалистик техникийн шинжилгээ ашиглах үндэсний чадавхийг бий болгоно”, 3.6.1.1-т. “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх, кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэж тодорхойлсон. Монгол Улсын Засгийн 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 266-д “Цахим засаглал” хэмээх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нэгдүгээр зорилтын хүрээнд “цахим аюулгүй байдлын эрх зүйн орчинг бүрдүүлэх, техник хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц байдлын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Манай улсад мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр батлагдан хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүд.

- “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” 2010.06.02-ны өдрийн 141 дүгээр тогтоол
- “Цахим засаг үндэсний хөтөлбөр” 2012.04.04-ний өдрийн 101 дүгээр тогтоол
- “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 2011.11.09-ний өдрийн 312 дугаар тогтоол
- “Төрийн албаны интернетийн зохистой хэрэглээг бий болгох тухай” 2012.08.25-ны өдрийн 5 дугаар тогтоол
- “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” 2017.02.08-ны өдрийн 47 дугаар тогтоол зэрэг батлагдсан бөгөөд одоогийн байдлаар “Цахим гарын үсгийн тухай”, “Өгөгдөл хамгаалах тухай”, Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулиудын төсөл боловсруулагдаж хэлэлцүүлэгийн шатандаа явж байна.

Манай улсад хувь хүний нууцыг хамгаалах тухай хууль байдаг ч өнөөдрийн нийгмийн шаардлагыг хангахгүй байна гэж хууль санаачлагчид үзэж байна.

Монгол улсад Хувь хүний нууцын тухай хууль нь 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр батлагдаж, 1995 оны 07 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.


Тус хуулийн гол зорилго бол хувь хүний нууцыг тогтоох, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хувь хүний нууц гэдэг нь Монгол улсын болон гадаадын иргэн харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

Хувь хүний нууц нь дараах 5-н төрөлтэй:

1. Захидал харилцааны нууц ;
2. Эрүүл мэндийн нууц;
3. Хөрөнгийн нууц;
4. Гэр бүлийн нууц;
5. Хуулиар тогтоосон бусад нууц

**Зураг 1. Монгол Улсын хүн амын өнөөгийн нөхцөл байдлын зураглал**




<sup>59</sup> (Монгол Улсын Их Хурлын 48 дугаар тогтоол, 2010)

20 хувь хамгаалалт шаардлагатай



Манай улсын нийт хүн амын 80.6 хувь нь интернет хэрэглэгч, 99.7 хувь нь гар утас хэрэглэгчид байна. Монгол Улсын олонх сумд өргөн зурвасын интернет болон улс орон даяар 3G/4G гар утасны сүлжээнд холбогдсоноор мэдээлэл харилцааны суурь бүтэц нь тоон хэлбэрт бүрэн шилжээд байна. Интернет нь өнөөдрийн Монгол Улсын хот, хөдөөгийн бүс нутагт хамгийн их хэрэглэгддэг мэдээлэл харилцааны хэрэгсэл болсон байна.



Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар цахим ертөнцийн аюулгүй байдал ихээхэн алдагдаж тэр дундаа интернэтийн сүлжээнд үйлдэгддэг гэмт хэрэг өссөн байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн харьяат иргэн “А” 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдөр фэйсбүүкээр Англи улсын харьяат гэх хуурамч хаягтай хэрэглэгчтэй харилцаа тогтоожээ. Улмаар гэмт этгээд “Англи хэлийг чинь сайжруулж өгье” гэх халхавчаар хохирогчтой дотносч, бэлэг явуулах тухай яриа гаргасан байна. Ингээд хэд хоногийн дараа Малайз улсын холбогдох албанаас хэмээн утсаар ярьж, таны нэр дээр Англи улсаас илгээж байгаа ачаанд их хэмжээний бэлэн мөнгө илэрсэн, та үүнийг авахын тулд ийм хэмжээний төлбөрийн төлнө үү гэх зэргээр хууран мэхэлж, 7850 ам.долларыг шилжүүлж авсан байна.

2017 оны 11 дүгээр сарын 19-ний байдлаар нийт 31 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахим луйвар, залилах гэмт хэргийн хохирогч болсон. Тэдний нийт хохирлын хэмжээ ойролцоогоор 1.8 тэрбум төгрөгт хүрээд байна. 2018 оны эхний 6 дугаар сарын байдлаар нийт 15 иргэн секс сүрдүүлэгийн гэмт хэргийн хохирогч болж Цагдаагийн Ерөнхий газрын ЭЦА-ны Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст бүртгэгдээд байна. Мөн 2015 оны Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 5 гэмт хэрэг бүртгэгдсэн бол 2016 оны байдлаар 11 гэмт хэрэг, 2017 онд 36, 2018 онд 44 болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Иргэд сүүлийн жилүүдэд төр, хувийн хэвшлийн байгууллагаас үйлчилгээ авахад хувийн мэдээллийг гаргаж өгөхийг шаарддаг. Тухайлбал, гар утасны дугаар авахын тулд үүрэн холбооны компанид регистрийн дугаараа өгч, төлбөр төлөх, авахын тулд банкны дансны болон картын дугаараа өгөх нь бий.

Үүнээс гадна, тэдгээр байгууллагууд мэдээллийн нууцлалыг задруулбал бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахуйц баримт бичиг, мэдээллийг цахим шуудангаар илгээдэг. 2015 оны байдлаар дэлхий даяар өдөр бүр 205 гаруй тэрбум мэйлийг илгээж, хүлээн



авсан байх бөгөөд 2016 онд энэ тоо 215 тэрбум болж өөрчлөгдсөн байна. Харин хувь хүний хувьд авч үзвэл, 2015 онд дунджаар нэг өдөрт ажил хэргийн нийт 122 мэйлийг илгээж, хүлээн авсан байх бөгөөд үүнээс 14 нь спам и-мэйл байна.<sup>60</sup>

Цахим гэмт хэрэг нь нуугдмал гэмт хэрэг гэж бодитойгоор үйлдэгддэг боловч Монгол Улсад бүртгэгдсэн 1 гэмт хэргийн ард 50 гаруй хэрэг нуугдмал хэвээр үлддэг. Энэ байдал нь Монгол Улс өнөөдрийн байдлаар цахим ертөнцийн аюулгүй байдлыг хангаж чадахгүй байна.

Учир нь төрийн байгууллага, иргэдийн мэдээлэл эрсдэлтэй түвшинд гэж үзээд цаашид дараах зүйлсийг анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.

1. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох
2. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх чадварыг нэмэгдүүлэх
3. Хууль сахиулах байгууллага хоорондын мэдээлэл солилцоо
4. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа
5. Олон улсын хамтын ажиллагаа зэрэг эрх зүй зохион байгуулалты арга хэмжээ юм.

### **3. Гадаадын зарим орнуудын хувийн мэдээллийг хангаж буй байдал:**

Сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж буй салбар бол мэдээлэл технологийн салбар. Уг салбарын хурдацтай өсөлтийг дагаад мэдээллийн аюулгүй байдлын тухай асуудал дэлхий дахинаа тулгамдаж байгаа билээ. Хамгаалалт буюу хувь хүний эрх ашгийг хөндсөн асуудал, бүрэн бүтэн байдал буюу өгөгдөл мэдээллийн бүрэн бүтэн байдал нь чухал нь. Мөн нэг хүнээс нөгөө хүнд дамжуулах мэдээ мэдээлэл гадны нөлөөлөлгүй, үнэн зөв дамжих ёстой. Энэ тал дээр америк, англи, герман тэргүүтэй өрнөдийн хөгжингүй орнууд кибер мэдээлэл үнэн зөв дамжигдах нөхцөлд анхаарч, ихээхэн хүч хөрөнгө зарсаар иржээ<sup>61</sup>.

Эрчимтэй хөгжин буй цахим эрин биднээс аюулгүй байдлын дараа үеийн технологийг ухаалаг шийдэлтэй хамт шаардах болсон. Security Transformation – буюу хамгаалалтын шийдэл, Digital Transformation цахим шилжилтийг бид яаж хийх ёстой вэ? Одоо хэрэглэгч бүр өөр өөрсдийн Devise /гар утас/, цахим мөнгө хэрэглэж эхлэсэн. Гэмт этгээдүүд өртөг багатайгаар кибер халдлага хийх боломжийг технологи олгож байна<sup>62</sup>.

Үүнийг дагаад гол хүчин зүйл бол хууль дүрэм өөрчлөгдөж байна жишээ нь АНУ-д 2017 онд цахим мэдээлэл, хувийн мэдээлэлтэй холбоотой хууль өөрчлөгдөж батлагдсан. Мөн тус улсад ганцхан жилийн дотор мэдээллийн аюулгүй байдлын 240 хуулийн төсөл шинээр хэрэгжүүлэхээр боловсруулагдаж байгаа ба АНУ-д гэхэд мэдээллийн аюулгүй байдалд зориулагдсан 500 гаруй акт байдаг<sup>63</sup>.

Дээр дурдсан хуультай ижил дараагийн хууль бол Европын холбооны батласан<sup>64</sup> “Хувь хүний мэдээлэл хамгаалах” хууль нь 2018 оны 5 дугаар сарын 24-нөөс хэрэгжээд эхэлчихсэн. Энэ хуулийн зарим гол заалтыг нь харах юм бол хувийн мэдээллийг байгууллагууд ашиглаж болно гэхдээ энэ мэдээллийг ямар нэг байдлаар алдах, тухайн хувь хүнд ямар нэг байдлаар хохирол учруулах юм бол тухай хүний хохиролыг заавал барагдуулахаар хуульд заасан бөгөөд ингэхдээ доод нь тал нь 20 орчим сая ам.долл (америк доллар) нөхөн төлбөр буюу тухайн байгууллагын жилийн орлогын 4 орчим хувийг торгуульд төлөхөөр ийм заалт орсон. Энэ хууль нь зөвхөн европын холбоонд дотороо хэрэгжих бус европын холбоонд байгаа улс, иргэдийн амьдарч байгаа газар нутаг дээр мөн хэрэгжинэ. Иймэрхүү хуулийг зөвхөн европийн холбоо бус бусад улс орнууд мөн адил хэрэгжүүлнэ.

Манай улс ч гэсэн энэхүү хуулийг хэрэгжүүлээд эхлэх нь ойлгомжтой энийг дагаад Монгол Улс мэдээллийн аюулгүй байдлынхаа бодлого шийдвэрийг эргэн харах, шийдлийг өөрөөр харахаас өөр сонголтгүй болгож байна.

Англи улсад анх Data Protection Act United Kingdom, UK Data Protection Act 1998 USA, Uniform Trade Secret Act Англи улсын 1998 онд батлагдсан Өгөгдлийг хамгаалах тухай актыг жишиг болгох хэрэгтэй. Бусад улс орнууд энэхүү актын жишиг болгодог нь судлагааны явцад ажиглагдсан. Data Protection Act 1998-нь<sup>65</sup>. Төрийн ба төрийн бус байгууллагын хувийн болоод үйлчлүүлэгч харилцагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зориулсан хууль зүйн акт юм<sup>66</sup>.

<sup>60</sup> Email Statistics Report, 2015-2019. The Radicati Group, Inc. <http://www.radicati.com/wp/wpcontent/uploads/2015/02/Email-Statistics-Report-2015-2019-Executive-Summary.pdf>

<sup>61</sup> (Ганбат, 2017, х. 6)

<sup>62</sup> („Цээсүрэн, Адъяа, 2018, SECURITY TRANSFORMATION” форум)

<sup>63</sup> (Харилцаа холбоо, технологийн газар, 2015, х. 3)

<sup>64</sup> (Worldwide, data protection laws are appearing in 2018 Brief about GDPR Art.82 GDPR Right to compensation and liability)

<sup>65</sup> Data Protection Act- UK:1998

<sup>66</sup> <http://ncsc.gov.mn/> - Монголын Кибер аюулгүй байдлын газар

Манай улсын хувьд 2015 оноос эхлэн “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан иргэдийн хувийн мэдээллийг хамгаалах тухай мэдлэг ойлголтыг тандан судлах зорилгоор Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас судалгааг явуулж байгаа хэдий ч хууль одоогоор батлагдан мөрдөгдөөгүй байна. Улс орнууд өгөгдөл хамгаалах хуулийг батлан хэрэгжүүлснээр хувь хүн, аж ахуйн нэгжийн өгөгдлийг боловсруулах, бүртгэх, ашиглах хадгалах, дамжуулах зэргээр мэдээллийн эргэлтэд оруулахтай холбоотой үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэхээс гадна түүнд мэдээллээ хуваалцах эрх болон түүний хамгаалалт нууцлах талаар тусгаж өгсөн байна.

Хувийн мэдээллийг хамгаалж байгаа байгууллагын нууцад багтах мэдээ мэдээлэл гэсэн 2 төрөл байна. Энэ ангилалд гадны хандалт, халдлагаас хамгаалагдсан тухайн байгууллагын “Нууцын журам” аль эсвэл дотоод журамд заагдсан мэдээллүүд хамаарна. Байгууллага дотроо нууцлагдсан, гадны хандалт, хандах эрхгүй хүмүүсээс хамгаалагдсан тодорхой тооны эрх бүхий хүмүүс үзэж болох мэдээллүүд байдаг. “Нууц мэдээ” гэдэгт юу хамаарч байна вэ? Мэдээ гэдэг нь ямар нэгэн зүйл эсвэл хэн нэгний тухай мэдэгдэж буй факт юм хэмээсэн толорхойлолтыг Оксфордын тайлбар тольноос харж болно. Нууц хэмээн тодотгосон нь бусдад буюу олонд үзүүлж, харуулж болохгүй, далдалбал зохих зүйл гэсэн утгатай. Орчин үеийн бизнесийн байгууллагуудад харилцагчдын хувийн мэдээлэл (утас, хаяг, регистрийн дугаар, цахим шуудангийн хаяг г.м.) мөн түүнчлэн ажилтнуудын хувийн мэдээлэл (анкет дээр тусгагдсан хувийн бүх мэдээллүүд) нь тухайн байгууллагын дотоод сүлжээгээр зөвхөн дамжихаа больж Cloud (үүлэн тооцоолол) руу орох Mobile (гар утсаар) аар дамжиж байна. Тэгэхээр энэ нь хүн бүхэн devise (төхөөрөмж)-д холбогдоод ирэхээр шинэ технологи руу бид орох хэрэгтэй гэдгийг сануулж байна.

Өнөөдөр бид IT Security болоод Physical Security аль алинийг нь дангаар нь ярихгүйгээр нэгтгэсэн цогц аюулгүй байдлыг хангах системийг хамгаалж чадах тийм шийдлүүдийг олж харах хэрэгтэй.

Мэдээллийг хамгаална гэдэг бол хүний хүчээр бүтдэг ажил биш. Өөрөөр хэлбэл, танк, хуягт, автомат буутай армиар манах ажил биш гэсэн үг. Хамгаалдаг арга технологи, төхөөрөмж, тэднийг ажиллуулдаг мэргэжилтнүүд байна. Шулуухан хэлэхэд, мэдээллийг “мөнгөөр” л хамгаална. Хамгаалалтын арга хэрэгсэл, төхөөрөмжүүд технологи хөгжихийн хэрээр маш амархан хуучирч байдаг. Хамгийн сүүлийн үеийн хамгийн сайныг нь тавьж байж мэдээллээ хамгаална. “Цоорхой” гарах л юм бол хэрэггүй болдог учраас дахиад л өөр арга хайх гээд маш их зардал гарч байдаг. Ялангуяа, банкууд дээр мэдээллийн аюулгүй байдлыг өндөр хэмжээнд ярих ёстой. Нэг гүйлгээ алдагдахад юу болохыг төсөөлшгүй. Тухайлбал, АНУ-ын томоохон банк мэдээллийн аюулгүй байдалдаа жилд 100 сая ам.доллар зарцуулдаг талаар мэдээллэдэг.

Тиймээс мэдээллийн аюулгүй байдлыг хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, мэргэжилтэн гурваар л шийднэ. Мэдээж сайн мэргэжилтэн өндөр хөлстэй. Энэ бол манай бүх төрийн байгууллагуудад тулгарч байгаа асуудал. Эхнээсээ мэдээлэл нь алдагдаж, хохирол учирсан кейсүүд гарч байна.

Санаатай, санамсаргүй халдлага өдөрт хэдэн мянгаараа гарч байдаг. Хакерын бот программууд байнга ажиллаж байна. Тиймээс мэдээллийн аюулгүй байдлаа хангамаар байгаа бол хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, мэргэжилтнүүдээ бэлтгээд хамгийн сайн тоног төхөөрөмжийг авч өгөх хэрэгтэй. Түүнээс багажийг нь авч өгөхгүй мөртлөө мэдээллийн аюулгүй байдал шаардах нь буу өгөхгүйгээр байлд гэдэгтэй л адил.

Харин эрсдэлийг яаж багасгах вэ гэдгийг л бодох хэрэгтэй. Үүний тулд дээр дурдсанчлан тусгай мэргэжилтнүүдийг бэлтгэж, орчин нөхцөл, тоног төхөөрөмжөөр нь хангаж өгөх хэрэгтэй. Мэдээлэл бол секундийг хэдэн сая хуваасантай адил хугацаанд хувь заяа нь шийдэгдэж байдаг учраас үнэ цэнэтэй мэдээлэл хамгаалж байгаа техник төхөөрөмж нь маш үнэтэй байдаг. Зөвхөн халдлага зогсоох шүүлтүүрийн программ гэхэд л хэдэн зуун мянга цаашилбал олон сая ам.долларын үнэтэй.

Одоогийн байдлаар манай улсад хэдэн иргэн хувийн мэдээллээ алдсан, хичнээн төгрөгийн хохирол учирсан талаар нарийвчилсан судалгаа хийгдээгүй байгаа нь эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Дижитал шилжилт илүү хурдтай өрнөж буй нөхцөлд өгөгдөл төвлөрсөн байгууллагууд дараа үеийн ERP, Block chain, Devise Locker зэрэг технологийн шийдлүүдийг ашиглан, байгууллагын болоод хувь хүний мэдээллийг аюулгүй байдлыг 360 градуст бүрхэн хамгаалах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Өнгөрсөн хугацаанд манай улсын нийгэм, эдийн засаг, хууль зүйн салбарт гарсан өөрчлөлт, шинэчлэл, мэдээллийн технологийн хөгжил, гадаад орнуудын мэдээллийг аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн нийтлэг чиг хандлага зэрэг нь манай улсад мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, зохицуулалтыг бий болгохыг шаардаж байна.

### **Дүгнэлт**

Эрх зүй, зохион байгуулалтын эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд иргэний болон хувийн эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлага урган гарна.

Мөн олон улсын эрх зүйн зохицуулалт, туршлагаас үндэслэн дараах дүгнэлт хийж болохоор байна. Үүнд:

Дээрх улс орнууд хүний эрхийг хангахад онцгой анхаарсан болох нь хамгаалалтын шийдэл, эрх зүйн зохицуулалт, хувийн хэвшлийн компаний өгөгдөл алдагдах эрсдлийг бууруулсан, халдлагаас хамгаалах үндэсний "CERT" сүлжээ бий болгож чаджээ.

Манай улсы хувьд Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх болон хөндлөнгийн хяналт хийх тусгай зөвшөөрөл олгогдсон эрх бүхий бүхий байгууллага байхгүй, өнөөдрийн байдлаар хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь хувийн мэдээллийг аюулгүй байдалд учирах эрсдэл ямагт байх болно гэдгийг илтгэж байна.

Тиймээс улс орны хэмжээнд хувийн мэдээллийг ангилах, өгөгдөл хамгаалах хуультай болох, мэдээллийн цахим сангуудыг нэгдсэн нэг баазад нэгтгэх, хадлага илрүүлэх системийг бий болгох, мэдээллийг кодчлох, хувь хүний мэдээлэл, байгууллагын мэдээлэл алдагдсанаас үүсэх зардал, санхүүгийн алдагдлыг тооцох зэрэг чухал харилцааг орхигдуулсан нь энэ салбарыг цаашид хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Иймд хувийн мэдээллийг хамгаалалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

### **Санал**

1. Мэдээллийн аюулгүй байдлын бие даасан хуультай болох
  - Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэн батлуулах
  - Мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичиг батлах
2. Мэдээллийн цахим сангуудын нэгдсэн нэг бааз бий болгох
  - Халдлага илрүүлэх үндэсний "CERT" сүлжээг бий болгох
  - Мэдээллийг ангилах, кодчилох
  - Эрсдэлийн үнэлгээ хийлгэх
  - Байгууллагын сүлжээний эмзэг байдлыг тодорхойлох
3. Зардал
  - Улсын төсөвт тодорхой хэмжээний мөнгийг төвлөрүүлэх
  - Дээрх зардлаар мэдээллээ алдсан байгууллага, хувь хүнд нөхөн төлбөр олгох, хохирол барагдуулах
  - Мэргэшсэн ажилтанг бэлтгэх, сурган дадлагажуулах
  - Эрсдлээс урьдчилан сэргийлэх
4. Мэдээллийн аюулгүй байдлын рх зүйг онолын түвшинд хөгжүүлэх.
  - Үүнд мэдээллийн эрх зүйгээс салбарлан мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйг бие даан хөгжүүлэхэд судлаач, эрдэмтэдийн анхаарлыг хандуулах
  - Энэ талаарх төсөл, судалгааны ажлыг хэрэгжүүлэх
  - Иргэд өөрсдийн мэдээллийг хамгаалах чадвар эзэмшүүлэх

## ОЛОН НИЙТЭД ХҮРГЭЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

*Б.Цэцэгмаа  
ХСИС-ийн магистрант, ахлах дэслэгч*

**Товч агуулга:** Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрч буй мэдээ, мэдээллийн агуулга иргэдийн сэтгэл зүйд хэрхэн нөлөөлөх, хэвлэл мэдээлэлд хэрхэн итгэл үнэмшилтэй байдаг дүн шинжилгээ хийх, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсон.

**Түлхүүр үг:** Хэвлэл мэдээллийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, өдөр тутмын сонин, олон нийт, хууль, дүрэм, журам.

Монгол Улс 1992 онд баталсан Үндсэн хуулиараа хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, олж авах эрх чөлөөг тунхаглан, 1998 оны “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулиар улам баталгаажуулсан билээ.

Улмаар 2005 онд “Олон нийтийн радио телевизийн тухай” хуулийг батлан, төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг олон нийтийн радио телевизийн статустай болгосон. Үүний зэрэгцээ 2011 оны “Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай” хуулиар төрийн байгууллагаас олон нийтийн ашиг сонирхолд хамаарал бүхий мэдээлэл авах иргэдийн эрхийг өмнөх хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилан хуульчилсан юм. Ингэснээр Монгол Улсад хэвлэл мэдээллийн ил тод байдал, улс төрөөс хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөө, мэдээлэл хайх, олж авах иргэдийн эрх чөлөөний талаар олон улсын жишиг, стандартад бүрэн нийцсэн эрх зүйн орчин бүрдсэн.

Харин сүүлийн жилүүдэд “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийг өөрчлөх замаар өмнөх хуулиар баталгаажуулсан эрх зүйн орчинг дордуулах, олсон ололт амжилтаас ухрах, зарим талаар хэвлэлийн эрх чөлөөг боомилох гэсэн оролдлого хэд хэдэн удаа бүтэлгүйтэж, 2016 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хууль санаачлагчдад нь буцаасан нь зөв алхам болсон юм.

2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, бусдыг гүтгэх, доромжлох үйлдэлд эрүүгийн хуулиар бус, Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр болсон нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн ил тод байдлыг дээдэлсэн, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн чухал алхам болсон билээ.

Монголын хэвлэл мэдээллийн салбарт өмнөх тогтолцооны үед төрийн мэдээллийн хэрэгсэл ноёрхож байсан хэдий ч 1990 оноос хойш маш богино хугацаанд зах зээлийн жам ёсоор хувийн хэвшлийн телевиз радио, сонин, сэтгүүл, мэдээллийн цахим сайт олноор байгуулагдаж, бүр томоохон медиа группууд үүсэн бий болоод байна.

Монголын Хэвлэлийн хүрээлэнгээс жил бүр эмхэтгэн гаргадаг “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” тайланд мэдээлснээр, 2017 оны байдлаар 334 мэдээллийн хэрэгсэл ажиллаж байгаа бөгөөд үүнд 99 мэдээллийн цахим сайт багтаж буй юм. Түүнчлэн, 88 сонин, үүнээс өдөр тутмын 9 сонин гарч байна. Мөн 45 радио, 127 телевиз үйл ажиллагаа явуулж байна.<sup>67</sup>

Хууль тогтоомжийн хувьд хэвлэлийн эрх чөлөөг боломжийн түвшинд хуульчилсан хэдий ч, бодит байдалд бүрэн хэрэгжихгүй, хэвлэлийн эрх чөлөө хязгаарагдмал хэвээр байна.

Иргэдийн мэдээлэл хайх эрхийг зөрчих, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулах, заналхийлэх, гэмт халдлагад өртөх, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөөг хязгаарлах явдал цөөнгүй гарсаар байна.

Иймд хэвлэлийн эрх чөлөө зөрчигдөж, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, хяналтгүй, үнэн худал нь мэдэгдэхгүй тэнцвэргүй мэдээлэл цацагдсанаар нийгмийн сэтгэл зүйд муугаар нөлөөлөх, олон нийт сөрөг мэдээлэл авах, хувь хүн, байгууллагын нэр хүндэд халдах, цаашлаад улс орны аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрээд байна. Тухайлбал, цагдаагийн байгууллагын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээлэл цацагдсанаар тус байгууллагын нэр хүнд унах, олон нийтийн дунд түүнд итгэх итгэл алдрах, цаашлаад тодорхой гэмт хэргийн шийдвэрлэлтэд хөндлөнгөөс нөлөөлөх, хэргийг улс төржүүлэх, хувь хүн, байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг талтай.

“Мэдээллийн аюулгүй байдал” гэдгийг өнөөдөр “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан,

<sup>67</sup> “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” тайлан 2017 он

хүртээмжтэй байдлыг баталгаажуулах”, “мэдээлэл, түүний орчинг иргэн, байгууллага, төрийн ашиг сонирхолд нийцүүлэн хамгаалсан байдал”<sup>68</sup> зэргээр томъёолсон байдаг.

Иргэний нийгмийг бүрэлдэн төлөвших, мэдээллээр хангагдах үйл явцын гол зэвсэг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж үздэг. Хэвлэл мэдээлэл чөлөөтэй байх нэг гол нөхцөл нь хууль эрхзүйн таатай орчин. Бас нэг чухал хүчин зүйл нь санхүүгийн хараат бус байдал. Гэхдээ эдгээр эрх чөлөөгөөр хангагдсан ч гэсэн хэвлэл мэдээллийнхэн бодит үнэнийг олон нийтэд түгээх эрх чөлөөгөө хязгаарлуулж мэдэх дам хүчин зүйлүүд бас гарч ирдгийн нэг нь мэдээллийн аюулгүй байдал юм.

“Шинэ зуунд мэдээллийн орон зай дайны хамгийн халуун цэг, гол талбар болон хувирч байна. Өөрөөр хэлбэл хүн төрөлхтөний түүхэнд байгаагүй өргөн цар хүрээтэй мэдээллийн дайны гал дэлхий ертөнц даяар дүрэлзэж, дэлхийн хүн ам бараг тэр чигээрээ шахам энэ дайны оролцогч, ялагч болж байна. Ийм тохиолдолд үндэсний аюулгүй байдлын асуудал нь дан ганц төр хариуцах ёстой улс төр, цэрэг дайны заналхийлэлтэй холбоотой асуудал биш болж, байгууллага, иргэдийн тэр дундаа хэвлэл мэдээллийн салбарынхны үүрэг оролцоо эрс нэмэгдэж байна. Мэдээлэл өнөөдөр зэвсэг, мөнгө, эрх мэдэл, аюул занал, эрсдэл, хөг жил дэвшлийн эх үүсвэр, мөн хамгаалалтын хүчирхэг хэрэгсэл болон хувирч байна”<sup>69</sup>.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл XXI зуунд хамгийн хүчтэй зэвсэг болон хувирсныг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дэлхий нийтэд өрнөж буй өнгөт хувьсгалууд бүрэн гэрчилнэ.

Египетэд өрнөсөн “Арабын хавар” хэмээх өнгөт хувьсгал эхлэхийн өмнө чухамдаа хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр, ялангуяа цахим сүлжээгээр олон нийтийн дунд хэлэлцүүлэг, маргаан өрнөж, өдөөн хатгасан, гүтгэсэн шинжтэй мэдээлэл ихээхэн цацагдсан юм. Энэ бүхэн “мэдээллийн бөмбөг” болон хувирч гэнэт тэсэрснээр иргэд гудамжинд гарч ирсэн. Энэ нь яван явсаар Египет орныг бүхэлд нь хамарсан иргэний дайн болон хувирч, үүний уршгаар олон мянган хүний амь нас, эрүүл мэнд хохирч, улмаар эдийн засаг, нийгмийг хамарсан хямрал нүүрлэсэн билээ.

Дээрх болон үүнтэй төстэй байдлаар өрнөсөн олон үйл явдлууд нь мэдээллийн аюулгүй байдлын асуудал өөрөө амар хялбар бус бөгөөд ямар их аюул, занал, эрсдэлийг агуулж буйг бэлхнээ харуулж байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.1. “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах”, 3.6.1.1. “Үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орны хөгжлийг дэмжих, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, нийгмийн оюун санааг төлөвшүүлэхэд мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой” гэж заасан байдаг. Мөн 3.6.1.2. “Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг хязгаарлана. Дайсагнал, ялгаварлан гадуурхах үзэл, үзэн ядалтыг сурталчилсан, дэмжсэн сурталчилгаа, мэдээллийг таслан зогсоох, саармагжуулах чадавхыг бий болгож, үл зөвшөөрөх сэтгэхүйг нийгэмд төлөвшүүлнэ”, 3.6.1.4. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл мэдээллийн хэрэгсэл үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх бөгөөд үйл ажиллагаа нь бодитой, тэнцвэртэй, хариуцлагатай байна. Мэдээллийн хэрэгслээр үндэсний үнэт зүйлийг түлхүү нийтлэх, сурталчлахыг дэмжиж, гадны шашин, соёл, төрийн бодлогыг сурталчилсан агуулгатай мэдээллийг зохистой түвшинд хязгаарлана” гэсэн заалтуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж байх шаардлагатай гэдгийн онцолж байна. Тухайлбал, өдөр тутмын солиноор сөрөг мэдээллийг дамжуулахад нийгэмд хүчтэй нөлөө үзүүлдэг. Тэрхүү сонин үзүүлэх нөлөө нь түүний хэвлэгдэх хувиар хэмжигдэнэ.

**Сонин судалгаа, тоо баримттай, эх сурвалжтай, бодит мэдээлэл түгээдэг гэсэн итгэл үнэмшил одоо ч хүчтэй хэвээр байна.** Өнөөдөр манай улсад өдөр тутам дугаар хэвлэн уншигчдад түгээж буй 9 сонин байна. Хүн амынхаа тоотой харьцуулбал энэ бага биш тоо. Энэхүү тоо жил тутамд чөөрсөөр, чанартай, бодитой мэдээлэл түгээгчид нь ялгаран үлдсээр байгааг тодотгож байгаа юм.

Үндэсний эрх ашиг, эх орон, үндэс угсаа, түүх соёлоо дээдлэх явдлыг гол үнэт зүйлээ болгосон нийгмийн сэтгэл зүйг бий болгох, төлөвшүүлэх бодлогыг төр, олон нийттэйгээ хамтран хэрэгжүүлэх нь хэвлэл мэдээллийн салбарынхны чухал үүрэг юм.

<sup>68</sup> Б.Галаарид “Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал” Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт ЭШХ-ын эмхтгэл. УБ., 2016. 33 дахь тал.

<sup>69</sup> Б.Галаарид “Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал” Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт ЭШХ-ын эмхтгэл. УБ., 2016. 34 дахь тал

### **Дүгнэлт**

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр аливаа нэг асуудлын талаар хэт нэг талыг барьсан, тэнцвэргүй эсвэл зохиомлоор хурцатгасан байр суурийг баримталбал олон нийтийн санаа бодлыг тогтворгүйжүүлэх, нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэх талтай. Мөн эдгээр олон тооны хэвлэл мэдээллийн хэрэгслийн бэлтгэж, хүргэж буй мэдээлүүдээс авч үзэхэд хэдэн хувийг эерэг, сөрөг мэдээлэл эзлэж байгаа олон нийтийн санаа бодол ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн харилцан нөлөөллийн асуудлыг нарийн судлаж боловсруулах хэрэгтэй байна.

### **Санал**

1. Хэвлэл мэдээлэлд олон нийт хэрхэн итгэдэг, ямар төрлийн мэдээ, мэдээллийг илүү уншиж байгаа талаар судалгаа хийх
2. Хэвлэл мэдээллийн байгууллагууд иргэдийн санаа бодлыг нээлттэй сонсож, үйл ажиллагаандаа тусгах, харилцан хамтран ажиллах
3. Хэвлэл мэдээллийн байгууллагууд сөрөг мэдээлэл иргэдийн болон улс орны аюулгүй байдалд хэрхэн нөлөөлдгийг авч үзэж судлах
4. Хэвлэл мэдээллийн байгууллагууд үзэгч, сонсогчдын талаар судалгаа хийх.

### **Ном зүй**

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992
- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль. УБ., 1998
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ.2010

Ном зохиол

- Монголын хэвлэлийн хүрээлэн “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” тайлан 2017
- Б.Галаарид. “Хэвлэл мэдээллийн салбар ба мэдээллийн аюулгүй байдал” Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт ЭШХ-ын эмхтгэл. УБ., 2016

# ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦААНЫ УЧИР ХОЛБОГДОЛ

Ц.Цэлмэ  
“Их засаг” ОУИС-ийн проректор,  
доктор (Ph.D), профессор

**Товч агуулга:** Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаар гадаадын зарим орны Эрүүгийн хууль тогтоомжийн онцлог, олон улсын гэрээ, конвенц, Монголын хууль цаазын түүхэн уламжлал, мөрдөн байцаалт, шүүхийн практикийг судалсаны үндсэн дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолох, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэхэд хууль хэрэглээний хүндрэл учирч байгааг тодорхойлж хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар саналаа илэрхийлсэн болно.

**Түлхүүр үг:** Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа. (Срок давности, limitation period)

Хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож гэмт этгээдэд ял завшуулах явдал Монгол улсад цөөнгүй гарч иргэдийн шүүх, хуулийн байгууллагад итгэх итгэлийг сулруулж байгаа, нөгөө талаас Эрүүгийн материаллаг болон процессийн хуулийн зөрчлөөс шалтгаалж шийдвэр гаргахад хүндрэлтэй асуудал үүсээд байна.

2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “..гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй” гэж заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр блох хүртэл тоолно” гэж заалтууд зөрчилдөж байгаа, хөнгөн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаанаас ч багаар буюу 1 жилээр тогтоосон,<sup>70</sup> гэмт хэрэгт холбогдсон хуулийн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрхэн тооцох талаар Эрүүгийн хуульд заагаагүйгээс болоод хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учирч байгаа, хөөн хэлэлцэх хугацааг зориуд дуусгаж хохирогч гомдолтой, хохирлыг төлөөгүй байхад эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгодог зэрэг хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд саналаа нэмэрлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгон судаллаа.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно”, 7 дахь хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно гэж заасан атлаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж заасан нь гэмт этгээд ял завших нэг шалтгаан болж байна.

Өөрөөр хэлбэл эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсаны дараа ч хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоохгүй байхаар хуульчилсан атлаа хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй гэж заасан нь буруу болжээ.

Эрүүгийн эрх зүйн институт болох хөөн хэлэлцэх хугацаа гэж хэрэв шүүн таслах ажиллагаанаас зайлсхийгээгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацааг хэлнэ<sup>71</sup> гэж академич, доктор (Sc.D), профессор С.Нарангэрэл үзсэн бол нэрт соён гэгээрүүлэгч Ч.Беккариа “Гэмт хэрэг ба ялын тухай” номондоо “...нотлох баримт цугларч гэмт хэрэг үйлдэгдсэн нь нотлогдмогц яллагдагч өөрийгөө өмгөөлөх цаг боломжоор хангагдах учиртай, олгогдсон хугацаа нь ялын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй, ял хойшуулшгүй зарчимд нөлөөлхүйц удаан үргэлжилж болохгүй<sup>72</sup> гэж үзжээ.

<sup>70</sup> [www.legal.info.mn](http://www.legal.info.mn). Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт хүнд 10000-20000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш 2 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон байхад Эрүүгийн хуулийн 1.10-р зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан гэмт хэргүүдэд 1 жилийн хугацаа байхаар тогтоожээ.

<sup>71</sup> С.Нарангэрэл. Монголын эрх зүйн эх толь бичиг. 4 дэх хэвлэл, 2015 он, 516 дахь талд

<sup>72</sup> Ч.Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орчуулсан Г.Эрдэнэбат. УБ хот, 2009 он, 93 дахь талд

Хугацаа тогтоох нь яллагагчийг өөрийгөө өмгөөлөх боломж олгох, нөгөө талаас буруутгах нотлох баримтыг цуглуулах хязгаар тавих учиртай, хүнд гэмт хэрэг хүмүүсийн оюун санаанд удаан хадгалагддаг учир хөөн хэлэлцэх хугацаа нь урт байх ёстой, харин хөнгөн гэмт хэргийн хувьд хэрэгтэнд засарч хүмүүжих боломж олгох үүднээс тэр хэргийг хурдан мартах, нийгэмд учирсан хохирол нь арилсан байдаг учир богино хугацаа тогтоох хэрэгтэй” гэж хөндөн тавьжээ<sup>73</sup>.

Эрүүгийн эрх зүйд хөөн хэлэлцэх хугацаа үйлдсэн гэмт хэрэг ба ногдуулах ялын хүнд хөнгөний байдлаас шалтгаална, тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөнөөр эрүүгийн хариуцлага ба ялаас чөлөөлөхөд а) гэм буруутай этгээд энэ хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдээгүй байх; б) гэм буруутай этгээд шүүхийн өмнөх ба шүүхийн шатнаас оргон зайлаагүй байх гэсэн шаардлага хангасан байхыг шаарддаг.

Монгол Улсын хувьд анхны эрүүгийн төрөлжсөн хууль 1926 онд “Шүүх цаазын бичиг” нэртэйгээр батлагдсанаас хойш 1929, 1934, 1942, 1961, 1986, 2002, 2015 (шинэчилэн найруулсан) онуудад батлагдан гарсан<sup>74</sup> бөгөөд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны талаар 1961 оноос өмнөх Эрүүгийн хууль тогтоомжид тусгайлан заагаагүй.

1961 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлд “...эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа” гэдгийг тодорхойлохдоо гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнээс хойш тодорхой хугацаа өнгөрвөл эрүүгийн хариуцлагад татаж болохгүй,<sup>75</sup> хорих ял оногдуулж болохгүй хэрэг үйлдсэнээс хойш 2 жил өнгөрсөн, 2 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч 3 жил өнгөрсөн, хуульд 2-5 жилээс дээшгүй хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн, хуульд 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох байсан боловч гэмт хэрэг үйлдсэнээс хойш 8 жил өнгөрсөн гэж тус тус заажээ. Хэрэв уг этгээд хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад 2 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болох гэмт хэрэг шинээр үйлдвэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдал тасрах бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг шинээр үйлдсэн өдрөөс эхлэн тоолно, хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаалт ба шүүхээс оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацааг тоолох явдлыг зогсоох ба уг этгээдийг албадан саатуулсан буюу хэргээ илчлэн ирсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тооцно.

Гэмт хэрэг үйлдсэнээс хойш 10 жил өнгөрсөн, хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол эрүүгийн хариуцлагад татаж болохгүй, цаазаар авах ял оногдуулж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ, хэрэв шүүх хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэж үзвэл цаазаар авах ял оногдуулж болохгүй түүнийг хорих ялаар солино<sup>76</sup>. 37 дугаар зүйлд “Ял шийтгэлийг хөөн эдлүүлж болохгүй хугацаа”-ны талаар хуульчлахдаа “...ял шийтгэсэн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелэгдээгүй 1-8 жилийн хугацаа өнгөрсөн бол биелүүлэх явдалгүй” гэжээ.<sup>77</sup> Тэгэхдээ шийтгэх тогтоол гарсанаас хойш 10 жил өнгөрсөн бөгөөд гэмт хэрэг шинээр үйлдэж хөөн хэлэлцэх хугацаа тасраагүй бол уг тогтоолыг биелүүлж болохгүй.

1986 оны шинэчилсэн найруулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 44 дүгээр зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа”, 45 дугаар зүйлд “Таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй хугацаа”-ны талаар<sup>78</sup> 1961 оны Эрүүгийн хуулиас зарчмын зөрүүгүй байдлаар хуульчилжээ. Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаа гэж гэмт хэргийг үйлдсэн цагаас хойш хуульд заасан нөхцөлтэйгөөр гэмт этгээдийг хариуцлагад таталгүй тодорхой хугацаа өнгөрсөн байхыг хэлнэ. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш ял шийтгэх хүртэл хоорондын хугацаа нь хэдий чинээ богино байх тусам ялын үр нөлөө төдий чинээ ашигтай байдаг.<sup>79</sup>

Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөнөөр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хугацааг тогтоохдоо тухайн улсын парламент нь үйлдэгдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанарыг харгалзан тусгай ангийн зүйлд заасан тодорхой гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээтэй харьцуулан параллель байдлаар заах учиртай.<sup>80</sup> Өөрөөр хэлбэл, 8 жилийн хорих ял оногдуулах санкцтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа нь 8 жилээс

<sup>73</sup> Мөн тэнд

<sup>74</sup> Монгол Улсын эрүүгийн эрх зүйн удиртгал. Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган нар. УБ хот, 2004 он, 74 дэх талд

<sup>75</sup> БНМАУ-ын хуулиуд. 1 дүгээр боть. УБ., 1980 он, БНМАУ-ын Эрүүгийн хууль. 76 дахь талд.

<sup>76</sup> БНМАУ-ын хуулиуд. 1 дүгээр боть. УБ., 1980 он, БНМАУ-ын Эрүүгийн хууль. 78 дахь талд

<sup>77</sup> Мөн тэнд

<sup>78</sup> БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1992 он, 64 дэх талд

<sup>79</sup> Ц.Цэлмэг. Эрүүгийн эрх зүй /онол, практик/ УБ хот, 2004 он, 56 дахь талд

<sup>80</sup> Мөн тэнд үзэх



багагүй байхаар тогтоох ёстой атал 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт 2-8 жилийн хорих ялтай гэмт хэрэгт хорих ялын дээд хэмжээ 8 жил байхад 5 жилийн хөөн хэлэлцэх хугацаа байхаар тогтоосон нь алдаатай учир засах шаардлагатай.

Эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацааг хуульд заасан ялтай харьцуулан тоолохдоо тухайн этгээдийн үйлдсэн хэргийг зүйлчлэн ангилах ёстой зүйл ангид заасан ялын хамгийн хүнд хэлбэрийг сонгон аваад түүний дээд хэмжээгээр харьцуулан тогтоодог жишиг эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад тогтсон байдаг.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх аль ч шатанд чухал нөлөөтэй.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2391 дүгээр тогтоолоор 1968.11.26-нд батлаж 1970.11.11-нд хүчин төгөлдөр болсон “Дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үл хэрэглэх тухай” конвенцид Монгол Улс (тухайн үеийн нэршил нь БНМАУ) нь 1969.01.31-нд гарын үсэг зурж 1969.05.21-нд соёрхон баталсаны дагуу<sup>81</sup> 2002 оны болон 2015 оны Эрүүгийн хуульд хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй гэж заасан нь цаг үеэ олсон зөв алхам байжээ.

Түүнчлэн, 2002 оны Эрүүгийн хуулийн 72.4 дүгээр зүйлд “...цаазаар авах ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ” гэж заасан<sup>82</sup> бол 2015 оны Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “бүх насаар хорих ял оногдуулахаар заасан хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа толохгүй<sup>83</sup>” хэмээн шүүгдэгчийн эрх зүйн байдлыг зарим талаар дордуулжээ.

2015 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргүүдийн дийлэнх нь 5 жил хүртэл хорих ялтай, цөөн тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүн нь 2-8 жилийн хорих ялтай байгаа нь 1.10 дугаар зүйлд зааснаар 1 ба 5 жилийн хөөн хэлэлцэх хугацаа тооцохоор байгаа нь авлигын гэмт хэрэгтнийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр ял завшуулах боломжийг нээсэн.

Тоо баримт дурьдахад 2015 онд манай улсад авлига, албан тушаалын 169 гэмт хэргийг шалгах явцад 25 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон бол 2016 онд 137 хэрэг мөрдсөнөөс 16 хэргийг, 2017 онд 167 хэрэг мөрдсөнөөс 27 авлигын хэргийг<sup>84</sup> буюу нийт мөрдсөн авлигын гэмт хэргийн 20 орчим хувийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

Авлигатай амжилттай тэмцэж байгаа улс орнуудад авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй буюу хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэж байхаар тогтоодог нь авлигачдыг ял завшуулахгүй байх боломж олгодог.

Авлигач этгээдүүд халдашгүй эрхтэй байх тохиолдол олон учир бүрэн эрхийн хугацаа нь дуусах хүртэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учирдаг, бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа хэргийг мөрдөн шалгаж эхлэх үед хөөн хэлэлцэх хугацаа дуусаж холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдол гарсаар л.

Хөөн хэлэлцэх хугацааг зөв тогтоохын тулд гэмт хэрэг үйлдсэн он, сар, өдөр, цагийг нарийвчлан тогтоовол зохих бөгөөд гэмт хэрэг үйлдэж дууссан цаг хугацаа, тухайлбал:

- ✓ Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.7.1 дүгээр зүйлд заасан нөхцлийг бүрдүүлсэн, гэмт үйлдэл таслан зогсоогдсон;
- ✓ Гэмт хэрэг үйлдэхээр завдсан тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээр чиглэсэн үйлдэл, эс үйлдэхгүйг санаатай хийсэн, эсхүл бүрэн хийсэн гэж гэмт этгээд ойлгосон;
- ✓ Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд Эрүүгийн хуульд заасан хамгийн хүнд ялтай гэмт хэргийг үйлдэж дууссан үеэс;
- ✓ Үргэлжилсэн үйлдлээр гэмт хэрэг үйлдсэн бол хамгийн сүүлчийн үйлдэл хийж дууссан үеэс;
- ✓ Удааширсан үйлдэлтэй гэмт хэргийн тухайд гэмт үйлдлээ дуусгавар болгосон өдрөөс эсхүл тухайн үйлдлийг илрүүлж таслан зогсоосон үеэс тус тус тоолно.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татахаар шийдвэрлэсэн атлаа хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаар тусгаагүй, хуулийн тэгээдэд хорих ял оногдуулахгүй учир ЭХЕА-н 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай байна, хэт богино хугацаа нь эрүүгийн хэргийг мөрдөн шалгах явцад дуусаж байгаа нь хуулийн

<sup>81</sup> Монгол Улсын олон улсын гэрээ. IY боть. УБ хот, 2006 он, 134 дэх талд

<sup>82</sup> [www.Legal.info.mn](http://www.Legal.info.mn) Монгол улсын Эрүүгийн хууль. 2002 он.

<sup>83</sup> мөн тэнд

<sup>84</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. УБ хот, 2017 он.

этгээдийг эрүүгийн хариуцлагад татах тухай заалтыг Эрүүгийн хуульд оруулсан ач холбогдлыг үгүй болгож байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлд заасан “татвар төлөхөөс зайслхийх” гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулах учир хөөн хэлэлцэх хугацаа 1 жил байна, татвараас зайлсхийсэн хэргийг татварын тайлан гаргаж дууссаны дараагаас эхлэн шалгаж эхэлдэг бөгөөд татварын тайлан, аудит, хяналт гээд процессийн урт хугацаа шаарддаг, ингээд хэргийг шүүхэд шилжүүлэх үед 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаа ихэнхдээ өнгөрсөн байдаг.

Гэтэл татвараас зайлсхийх зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа 2 жил байдаг, зөрчлийг шалгаж эхэлмэгц хөөн хэлэлцэх хугацаа зогсдог нь зөрчлийн шийтгэл гарцаагүй байх зарчмыг хангаж байгаа учир татвараас зайлсхийгч этгээд, тэдний өмгөөлөгч нар зөрчлийн хэрэг бус эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж өгөх хүсэлт гаргадаг болов.

ЭХТА-н 18.3 дугаар зүйлд хуулийн этгээдэд оногдуулах ялыг хуульчлаагүй учир байгааг нэмэлт өөрчлөлтөөр залруулж “татвараас зайлсхийх гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг 20.000-120.000 нэгжээр торгох ял шийтгэнэ” гэж хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох хоёр үндсэн хувилбар дэлхийн улс орнуудад үйлчилж байгаа бөгөөд эхнийх нь гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэх хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолох хувилбар юм.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой олонх орон, ХБНГУ, Франц зэрэг улсуудад гэмт хэргийг илрүүлэн шалгаж эхэлмэгц хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоодог<sup>85</sup> бол харин пост-социалист улсууд, Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн Эрүүгийн загвар хууль<sup>86</sup> болон ОХУ (ОХУ-ын ЭХЕА-н 78 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) зэрэг улсын Эрүүгийн хуульд “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн үеэс шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл” тоолдог жишгийг манай улс 1961 оноос хойш одоог хүртэл хэрэгжүүлж байгаа нь ял завших үүд хаалгыг нээсээр л.

2017.05.18-нд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн<sup>87</sup> 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” тохиолдолд **эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй, 32.5 дугаар зүйлийн** 1.5-д “гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол хэрэгсэхгүй болгох”-оор, шүүхийн шатанд шилжсэн хэргийг мөн хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар мөн л хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол хэрэгсэхгүй болгохоор заасан нь дээрх заалтуудыг хэрэглэж шийдвэр гаргахад хүндрэл үүсгэж байна.

2015 оны Эрүүгийн хуулийн эхний үзэл баримтлалаар “хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолно” гэсэн байсныг 2017 онд өөрчилж “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж өөрчлөн баталсантай холбоотой бөгөөд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтөө Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 болон 34.19 дүгээр зүйлүүдэд тусгалгүй үлдээсэнээс хууль хэрэглэхэд хүндрэл учирч байна.

Дээрх зөрчлийг арилгахын тулд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “..хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж өөрчилбөл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 болон 34.19 дүгээр зүйлүүдийг өөрчлөх шаардлагагүй болно, харин Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөх шаардлагагүй гэж үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 болон 34.19 дүгээр зүйлүүдийг “...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэж өөрчлөн найруулах шаардлага үүсэж байна. Дээрх нөхцөл байдлуудад дүгнэлт хийгээд дараах шинэлэг санааг судлаачийн зүгээс дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1 болон 2 дахь заалтууд үзэл баримтлалын зөрчилтэй учир нэг талд нь шийдвэр гаргах шаардлагатай. Хэрэв яллагдагчаар татсанаар хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох нь зүйтэй гэж УИХ үзвэл<sup>88</sup> гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл тоолно гэж ЭХЕА-ийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг өөрчлөн найруулах шаардлагатай.

<sup>85</sup> <https://constitutions.ru/> Уголовный кодекс федеративной республики германия.общая часть. 78 b.

<sup>86</sup> [www.docs.cntd.ru /document/ 901781490](http://www.docs.cntd.ru/document/901781490). Модельный Уголовный кодекс (с изменениями на 16 ноября 2006 года)

<sup>87</sup> [www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.

<sup>88</sup> ХЗДХЯ-наас Эрүүгийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-д өргөн барихаар бэлтгээд байна. Ц.Ц.

Энэ тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 болон 34.19 дүгээр зүйлүүдийг өөрчлөх шаардлагагүй болж хууль хоорондын зөрчил арилна.

Хэрэв ЭХЕА-ийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг өөрчлөх шаардлагагүй гэж үзвэл тус зүйлийн 1 дэх хэсгийг "...хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол эрүүгийн хэрэгсэхгүй болгоно" гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 болон 34.19 дүгээр зүйлүүдийг "...гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан" гэж өөрчлөн найруулах шаардлага үүснэ.

Хоёр.ЭХЕА-ийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан "...энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн" гэснийг 8 жил өнгөрсөн бол гэж өөрчлөх;

Гурав. Хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан зааж өгөх шаардлагатай. Хуулийн этгээдэд оногдуулах торгуулийн хэмжээнээс хамаарч хуулийн этгээдийн хувьд гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн 3-10 жил хүртэл хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Татвараас зайлсхийх гэмт хэргийн тухайд хувь хүнийг хорих ял оногдуулах боломжийг нээх, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгах нь зүйтэй.

Дөрөв. Дэлхийн олонх оронд хөөн хэлэлцэх хугацаа гэдэгт эрүүгийн хариуцлагад татаж болохгүй хугацаанаас гадна ял шийтгэлийг нөхөн эдлүүлж болохгүй хугацаа гэж байдгийг Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмж оруулах шаардлагатай байна. Жишээ нь нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан байхад төрийн байгууллагын уялдаа холбоо муу, ажлын байр олдоогүй зэрэг шалтгааны улмаас ялыг эдлүүлэгүй тодорхой хугацаа (2-3 жил г.м) өнгөрсөн тохиолдолд тухайн этгээд ял эдлэхээс зайлсхийгээгүй бол ялыг нөхөн эдлүүлж болохгүй гэсэн нийтлэг жишгийг манай улс дагах учиртай.

Тав. Авлигын гэмт хэрэгт үйлдсэн этгээдэд хөөн хэлэлцэх хугацааг хэтэрхий багаар /дээд тал нь 5 жил/ тогтоосон нь тэднийг ял завшуулж байгааг анхаарч энэ төрлийн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байх, эсвэл хөөн хэлэлцэх хугацаа тоолох эсэхийг шүүх шийдвэрлэдэг байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

Эцэст нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дуусна гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд төрийн албадлага хэрэглэхгүй, эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа болохоос биш гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлөх үүргээс чөлөөлөх учиргүй, иймээс хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хохирлыг нь нөхөн төлүүлэх шаардлагатай гэдгийг хууль хэрэглэгч субъектууд анхаарч ажиллах ёстой.

## 2002 ба 2015 ОНЫ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ЭМНЭЛГИЙН НЭР ТОМЪЕОНЫ ХАРЬЦУУЛАЛТ

П.Ариунболд<sup>1</sup>, М.Цэрэнбат<sup>2</sup>, Ж.Эрдэнэбулган<sup>3</sup>  
<sup>1</sup>МУИС-ийн ХЗС, <sup>2</sup>АШУУИС-БАС, <sup>3</sup>МУИС-ийн ХЗС

**Товч агуулга:** Эрүүгийн эрх зүйд одоо хэрэглэгдэж байгаа ерөнхий ангийн нэр томъёонуудыг хууль болон бусад хэм хэмжээнд хэрхэн тайлбарласан, энэ нь анагаах ухааны үндсэн ойлголттойгоо хэрхэн уялдаж байгааг судлахын зэрэгцээ анагаах ухааны тодорхойлолт, агуулгыг нь гаргаж тайлбарлахад чиглэсэн болно.

**Түлхүүр үг:** Бэлгийн чиг баримжаа, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, сэтгэл.

### Оршил

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь эрүүгийн хуулийн түүхэн уламжлал, хөгжлийн чиг хандлага, гэмт хэрэг, ялын тухай, эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал зэрэг өргөн ойлголтыг өөртөө багтаахын зэрэгцээ эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологи, криминалистик, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, иргэн, хөдөлмөр, эдийн засгийн г.м салбар эрх зүйн болон бусад шинжлэх ухаантай нягт холбоотой хөгжиж ирсэн юм<sup>89</sup>. Одоо мөрдөгдөж буй шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2002 оны Эрүүгийн хуулийг ерөнхий ангийн хүрээнд хэм хэмжээг харьцуулан судалж үзвэл урьд хэрэглэгдэж байгаагүй үг хэллэг, утга, агуулга бүхий анагаахын цөөнгүй нэр томъёог одоо үйлчилж буй Эрүүгийн хуульд хуульчилжээ. Энэхүү судалгаагаар доорх нэр томъёог түүвэрлэн авч, хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсныг, анагаахын ойлголт, нэр томъёоны тайлбаруудтай харьцуулан судалж, анализ хийж үзэн, санал дэвшүүлэв.

### Үндсэн хэсэг

**I. “Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээлтэй” гэх нэр томъёонуудын тухайд**

2002 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангид огт тусгагдаж байгаагүй бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй гэсэн ойлголтыг одоо үйлчилж буй Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1 дүгээр зүйлийн 1.3.1-д дараах байдлаар хуульчилжээ.

2002 оны Эрүүгийн хууль	Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль
5.1. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	1.3.2. Гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.

**A. “Бэлгийн чиг баримжаа” гэх ойлголтын тайлбар:**

*Хууль зүйн талаас:* “Хүний бэлгийн амьдрал ба бэлгийн чиг баримжаа бэлгийн дур сонирхол, хүсэл шохоорхлын талаарх ойлголт юм. Өөрөөр хэлбэл та бэлгийн дур хүслийн хувьд ямар хүйсний хүнд татагдах болохыг авч үздэг”<sup>90</sup>.

Бэлгийн чиг баримжааг дотор нь “*Гетеросекс* - эсрэг хүйсийн хүнд, *Гомосекс* - ижил хүйсийн хүнд татагдах гей, лесби, *Бисекс* - ижил болон эсрэг хүйсийн хүмүүсийн хоёуланд нь татагдаж, дурлаж, сонирхон тэдэнтэй бэлгийн хавьталд ордог хүнийг хэлнэ. Үндсэн гурваас гадна хэд хэд ангилна<sup>91</sup> гэж тодорхойлсон.

*Анагаах ухааны талаас:* Дээрх тодорхойлолтыг Монголын Анагаах ухааны үндэсний нэвтэрхий тольд “...тухайн хүн ижил хүйсний болон эсрэг хүйсийн хүн эсвэл аль алинтай нь

<sup>89</sup> Эрдэнэбулган.Ж, “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 99 дэх тал

<sup>90</sup> Эрүүл мэндийн сайдын 2013 оны 485 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

<sup>91</sup> Эрүүл мэндийн сайдын 2013 оны 485 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

бэлгийн хавьталд орох зуршил ба бие махбод, хайр дурлал, зүрх сэтгэлийн хувьд аль нэг, эсвэл аль аль хүйсийн хүмүүст татагдах “*төрөлхийн үзэгдэл*” гээд ямар хүйсийнхээ хүмүүст чиглэсэн чиг баримжааг дээрхийн адил 3 хэсэгт ангилсан<sup>92</sup> байна. Бэлгийн аль хүйсдээ чиглэсэн гол хандлагыг “*бэлгийн объект*”-оор сэтгэц, бэлгийн чиг баримжааг /анагаахын нэршил/ тодорхойлдог. “Хувь хүн бэлгийн харилцаанд орж бэлгийн дураа хөдөлгөж бэлгийн хөөрөлд автаж бэлгийн таашаал хүртэхийн тулд ашиглаж байгаа тэрхүү зүйлийг буюу бэлгийн дураа хангах зүйлээ сонгож авах”<sup>93</sup>-ыг бэлгийн объект гэнэ. Орчин үед өмнө дурдсан гурван бэлгийн чиг баримжааг сэтгэц бэлгийн “*хэвийн хөгжил*” буюу сэтгэц бэлгийн хэвийн чиг баримжаа гэж үнэлээд аль ч чиг баримжааг дангаар эмгэг хэмээн анагаах ухаанд тооцдоггүй байна.

Анагаахын шинжлэх ухаанд бэлгийн цөөнхийн бэлгийн чиг баримжааг эмгэг хэмээн үзэхгүй байгаа тул хуульд бэлгийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй байх гэж оруулж өгөх шаардлагагагүй, эсхүл “*бэлгийн чиг баримжааг эмгэг гэж үзэхгүй*” гэсэн анагаах ухааны тайлбарыг оруулж өгөх.

## **Б. “Хүйсийн чиг баримжаа” гэх ойлголтын тайлбар:**

*Хууль зүйн талаас:* “Хүйсийн чиг баримжаа - хүн өөрийн хүйсийг төрөлх хүйсээсээ өөрөөр мэдрэх төрөлхийн мэдрэмж бөгөөд энэ нь эрэгтэй төрсөн ч эмэгтэйдгээр, эмэгтэй төрсөн эрэгтэйдгээр эсвэл эрэгтэй, эмэгтэй аль ч бишээр тодорхойлохыг хэлнэ”<sup>94</sup>.

*Анагаах ухааны талаас:* Хүйсийн чиг баримжааг ойлгохын тулд эхлээд бэлгийн хөгжил буюу хүйс ялгаран хөгжих онцлогийг заавал мэдэх шаардлагатай юм. Монголын Анагаах ухааны үндэсний нэвтэрхий тольд “Бэлгийн хөгжил “онтогенез хөгжлийн” өргөн үеийг хамарсан ойлголт бөгөөд ургийн хөгжлийн үеийн анхдагч бэлгийн булчирхай ба хоёрдогч шинжүүд бүрэн боловсорч дуусахыг хэлнэ. Бэлгийн хөгжил нь хүйс ялгаран хөгжих үйл явц юм. Хүний хөгжлийн явцад 3 төрлийн хүйс ялгаран хөгждөг. *Удамшлын хүйс*-энэ хүйс нь эр, эм бэлгийн эс үр тогтох үед ялгаран хөгжих бөгөөд ХУ хромосом бүхий гетерогамет үүсвэл эр хүний хүйс, ХХ хромосом бүхий гомогамет үүсвэл эм хүйс хэмээн үзнэ. *Морфологийн хүйс*-удамшлын хүйсний суурин дээр морфологийн хүйс ялгаран хөгжинэ. Энэ нь дотор, гадна бэлэг эрхтнүүд хөгжих үйл явц юм. Үр хөврөлийн эхний үед бэлгийн тогтолцооны эх үүсвэр адилхан байна. Харин үр хөврөлийн 6-8 долоо хоногтойгоос эхлэн У хромосомын нөлөөгөөр үрийн хоолой, эр бэлгийн булчирхай бий болж андроген даавар ялгаруулж эхэлнэ. Х хромосомын нөлөөгөөр эм бэлгийн булчирхайны эх үүсвэр тавигдаж, арай хожуу өндгөн эс бий болж, эм бэлгийн даавар ялгаруулна. Үр хөврөлийн 8-10 долоо хоногтойд дотор бэлэг эрхтэнүүд, 20 долоо хоногтойд гадна бэлэг эрхтэнүүд хөгжиж морфологийн хүйс бий болно. *Дааврын хүйс*-анхан бий болсон удамшлын хүйстэй холбоотойгоор цаашид хөгжих үйл явцдаа эр, эм бэлгийн булчирхайнуудаас эр, эм бэлгийн дааврууд ялгарах болсноор морфологийн хүйсний ялгаа улам тодрох биохимийн үндэс тавигдана”<sup>95</sup>. Өөрөөр хэлбэл, тухайн хүйсийн дааврын тогтолцоогоо дагаж хүйс эрэгтэй, эмэгтэй гэж тодордог. Хүйсийн чиг баримжаа гэх нэр томъёо нь *сэтгэц судлал* болон *морфологийн* түвшинд судлагддаг.

Сэтгэц судлалын үүднээс үзвэл: “хүйсийн сэтгэлзүйн ижилсүүлэлт, биологийн хүйс хоёр тохироогүй байдлаас болж өөрийгөө эсрэг хүйстэн хэмээн мэдэрч, эсрэг хүйстэн хэмээн итгэн үнэмшиж, эсрэг хүйстэний төрх үйлдэл гаргаж, өөрийгөө эсрэг хүйстэнд хамааруулан тооцдог хувь хүний сэтгэц бэлгийн эмгэгийг хүйсээ ижилсүүлэх эмгэг”<sup>96</sup> бөгөөд транссексуал буюу трансжендэр хүн гэнэ.

Тодруулбал, хүйсийн “*сэтгэлзүйн ижилсүүлэлт*” гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүн сэтгэл зүйн хувьд өөрийгөө аль нэгэн хүйст хамааруулан мэдрэх мэдрэмжийг хэлнэ. Хүнд төрөхөд заяасан хүйсийг “*биологийн хүйс*” гэнэ. “Сэтгэц бэлгийн хэвийн хөгжилтэй хүмүүсийн биологийн болон хүйсийн сэтгэл зүйн ижилсүүлэлт хоёр хоорондоо тохирдог”<sup>97</sup>. Үүнээс гадна хүйсийн мэдрэмж, хүйсийн үүрэг гэдгийг хамтад нь авч үзэж байж хүйсийн чиг баримжааг тодорхойлно. “Хүн өөрийгөө би эмэгтэй, би эрэгтэй хэмээн ухамсарласан, тууштай итгэл үнэмшлийг “*хүйсийн мэдрэмж*” гэх”<sup>98</sup> ба хүйсийн мэдрэмж нь биологийн хүйстэйгээ тохирч байвал “*сэтгэц бэлгийн хөгжил хэвийн*”-д тооцдог. “Эрэгтэй, эмэгтэй хүйс талаасаа нийгэмд

<sup>92</sup> Лхагвасүрэн.Ц нар, Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. I боть. УБ., 2012, 330 дахь тал

<sup>93</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 647 дахь тал

<sup>94</sup> Эрүүл мэндийн сайдын 2013 оны 485 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

<sup>95</sup> Лхагвасүрэн.Ц нар, Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. I боть. УБ., 2012, 330 дахь тал

<sup>96</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 666 дахь тал

<sup>97</sup> Мөн тэнд 665 дахь тал

<sup>98</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 666 дахь тал

гүйцэтгэх үүрэг, нийгэмд эзлэх байр суурь, бие авч явах ёс болон нийгмийн бусад хэм хэмжээг баримтлахыг “хүйсийн үүрэг” гэж үздэг<sup>99</sup>. Хүйсийн үүрэг нь гадаад төрх үйлийн илрэл бөгөөд трансвестизм буюу трансвестит хүмүүс. “Хувь хүний сэтгэц бэлгийн чиг баримжаа нь байгалиас заяасан, хэвийн, эрүүл зүйл юм. Хувь хүн сэтгэц бэлгийн чиг баримжаагаа /хандлагаа/ өөрөө сонгох буюу өөрөө өөрчлөх ямар ч боломжгүй”<sup>100</sup> юм.

Морфологийн хүрээнд: хүйсийн чиг баримжаа нь гадна бэлэг эрхтэнээр тодорхойлогдохгүй, төрөлхийн эмгэг байдалтай хүмүүс цөөнгүй. Энэ нь шүүх практикт хүйс тогтоох шүүх эмнэлэгийн магадлан шинжилгээгээр илэрдэг. “Үр хөврөлийн шатанд бэлэг эрхтэний янз бүрийн гажиг (үтрээ битүү, бэлгийн их бага уруул нийлсэн, гадна бэлэг эрхтний хуйхнагтай нийлэлт, наалдалт г.м) үүсч бэлэг эрхтний хөгжлийн дээрх гажгуудын улмаас хүйсний маргаантай асуудал гарч ирдэг. Манин /гермафродитизм/ - эр ба эм хүйсний гаж хөгжил юм”<sup>101</sup>. Дотор нь жинхэнэ манин болон хуурамч манин гэж ангилдаг. Хуурамч манин аль нэг хүйснийг тодорхойлох бэлгийн булчирхайтай боловч гадна бэлэг эрхтэний хөгжил нь эсрэг хүйсийн чиг хандлагатайгаар хөгжиж байдгийг үндэслэн эмэгтэй, эрэгтэй хуурамч манин гэж хоёр хуваан үздэг.

Бэлгийн болон хүйсийн чиг баримжааны анагаах ухааны тайлбарыг хуульд оруулж өгөх.

## **В. “Хөгжлийн бэрхшээлтэй” гэх ойлголтын тайлбар:**

*Хууль зүйн талаас:* Эрх зүйн эх толь бичигт тодорхойлсноор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүн”<sup>102</sup>.

2006 онд батлагдсан НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенцийг Монгол Улс 2008 онд соёрхон баталсан бөгөөд “хөгжлийн бэрхшээл гэдэг нь өөрчлөгдөн хувьсаж байдаг ойлголт бөгөөд нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн чөлөөтэй оролцоход саад тотгор учруулахуйц бие эрхтэний согог, нийгмийн хандлагын болон орчны хязгаарлалтаас үүдэн бий болж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх”<sup>103</sup> гэжээ. Харин “Хөгжлийн бэрхшээлтэй хүн - бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ”<sup>104</sup> гэж тодорхойлсон.

Олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд УИХ-аас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд баталсан. Хуулийн 4.1.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүн<sup>105</sup> гэдгийг өмнөхийн адил тодорхойлсон бол Эрүүл мэндийн сайдын А/512 тоот тушаалын хавсралтанд “...бие махбодь, оюун санаа, сэтгэц, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай хавсарсны улмаас нийгмийн амьдралд бусдын адил бүрэн гүйцэд, үр дүнтэй оролцох боломж хязгаарлагдсан хүнийг” ойлгоно гэжээ. ДЭМБ-аас гаргасан тодорхойлолтоор “...бие бялдар, оюун санааны чадавх нь төрөлхийн болон олдмол шалтгаанаар дутмаг болсны улмаас нийгмийн болон хувийн амьдралын хэвийн шаардлагаа бие дааж хангаж чадахгүй хүнийг”<sup>106</sup> хэлнэ.

Хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн ба олдмол гэсэн төрлөөр тодорхойлсон. “Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг “төрөлхийн”, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг “олдмол” гэж төрөлжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар”<sup>107</sup> авч үзэж байна.

*Анагаах ухааны талаас:* “Хөгжлийн бэрхшээл хүний ердийн хийж гүйцэтгэдэг үйл ажиллагаа эсхүл ердийн гэж үзэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд саад болох аливаа

<sup>99</sup> Мөн тэнд 665 дахь тал

<sup>100</sup> Мөн тэнд 665 дахь тал

<sup>101</sup> Э.Ганбат, Э. Цэрэнбат, М. Шүүх эмнэлэг. УБ., 2015, 102 дахь тал

<sup>102</sup> Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. гурав дахь хэвлэл. УБ., 2011, 536 дахь тал

<sup>103</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, УБ., 2008

<sup>104</sup> Мөн тэнд

<sup>105</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016. 4.1.1 дэх заалт. хөгжлийн бэрхшээлтэй хүн - бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг

<sup>106</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаархи МУ-ын анхдугаар илтгэл, УБ., 2011, 27 дахь тал

<sup>107</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах. УБ., 2017. 6 дахь тал

хязгаарлалт, эсхүл гүйцэтгэх чадваргүй (согогийн улмаас) байх<sup>108</sup> - ыг хэлнэ. Өөрөөр хэлбэл тахир дутуу гэх ойлголт хэрэглэгддэг. “Тахир дутуу - өвчин эмгэг, гэмтлийн улмаас хүний бие махбодийн үйл ажиллагаа удаан хугацаагаар буюу бүрэн алдагдах. Тахир дутуу болох гэдэгт осол гэмтэл, архаг өвчнөөр өвчилсөний улмаас юмуу, бие эрхтэний үйл ажиллагаа гэмтэж байнга, эсвэл удаан хугацаагаар тодорхой мэргэжлийн ажил хийх чадвараа бүрэн буюу түр алдахыг хэлнэ. Төрөлхийн гажиг, бие эрхтэний дутуу хөгжил, эрхтэний согог үүнд орно. Монголд хөдөлмөрийн чадвар алдсан хэмжээнээс хамааран тахир дутуугийн зэрэг тогтоодог. Тахир дутуу болоход улсаас тэтгэвэр өгөхөөс гадна захиргаа, ажлын газар нь тахир дутуу хүмүүст тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох, тэдний ажлын цагийг хорогдуулах, гэрээр ажиллуулах зэргээр хөдөлмөрийн нөхцөлийг нь хөнгөлөх, халамж үзүүлэх үүрэгтэй<sup>109</sup>.

Хөгжлийн бэрхшээлтэй гэх ойлголтыг нэг мөр болгож, тайлбарт тахир дутуугийн ойлголтыг оруулж өгөх.

## II. “Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан” гэх нэр томъёоны тухайд

2002 оны Эрүүгийн хуульд хөдөлмөрийн чадваргүй этгээдэд бүрэн болон хэсэгчилсэн чадвар алдалтаас гадна хөдөлмөр эрхэлж болохгүй бусад шалтгааныг хамруулах боломжтой байв. 2015 оны Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.5-д зааснаар зөвхөн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд гэж зүйлчилсэн нь энэ заалтын хэрэглэгдэх цар хүрээг хязгаарласан гэж үзэж байна.

2002 оны Эрүүгийн хууль	Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль
50.4. Хөдөлмөрийн чадваргүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг, түүнчлэн тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, цэргийн жинхэнэ хугацаат алба хааж байгаа этгээдэд албадан ажил хийлгэх ял оногдуулахгүй.	5.4.5. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мөндөд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

### “Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан” гэх ойлголтын тайлбар:

Хууль зүйн талаас: Эрх зүйн эх толь бичигт “Хөдөлмөрийн чадвар хөдөлмөрлөх үйл ажиллагааны чадвар. Хүний гүйцэтгэж болох ажлын шинж чанараас шалтгаалан хөдөлмөрийн чадварыг *ерөнхий* (өөрөөр хэлбэл, хэвийн нөхцөлд ямар нэгэн гүйцэтгэх чадвар) *мэргэжлийн* (өөрөөр хэлбэл, тодорхой мэргэжлийн ажил гүйцэтгэх чадвар) ба *тусгай* ( өөрөөр хэлбэл, тодорхой үйлдвэрлэлийн буюу цаг уурын нөхцөлд буюу газар доорхи буюу усан доорхи ба өндөр уулын буюу говийн бүс зэрэг) гэж ангилна. Хэмжээгээр нь *бүрэн* ба *бус* (хязгаарлагдмал, хэсэгчилсэн зэрэг) хөдөлмөрийн чадвар<sup>110</sup> гэж тодорхойлсон.

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн 111 тоот тогтоолоор баталсан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт гэсэн стандартад “*Чадвар алдалт* гэж биеийн үйл ажиллагааны аливаа үйлдэл хийж чадахгүй болох нөхцөлийг” хэлнэ гэж заажээ. Мөн стандартын 2.22-т “*Хөдөлмөрийн чадвар алдалт* өвчин эмгэг нь архаг удаан явцтай, эрхтэн бие махбодийн тогтоц, үйл ажиллагааг гэмтээж доройтуулсны улмаас үндсэн мэргэжлийнхээ ажлыг гүйцэтгэж чадахгүй болж, хийсэн эмчилгээнд засрахгүй байнгын архаг байдалтай болсныг хөдөлмөрийн чадвар алдалт гэнэ, 2.22.1-д “*хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах*” 70 ба түүнээс дээш хувиар алдах<sup>111</sup>-ыг тус тус хэлнэ гэсэн бол эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн 1.4-д “иргэний хөдөлмөрийн чадвар алдсан шалтгааныг ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас гэж ангилна, 1.5.1-д бүрэн алдсан буюу 70-аас дээш хувиар алдсан<sup>112</sup> гэж тооцохоор заажээ.

<sup>108</sup> Лхагвасүрэн.Ц нар, Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. III боть. УБ., 2012, 1569 дэх тал

<sup>109</sup> Жамбалдорж.Я, Анагаах ухааны танин мэдэхүйн толь. УБ., 2009, 413 дахь тал

<sup>110</sup> Нарангэрэл.С, Эрх зүйн эх толь бичиг. гурав дахь хэвлэл. УБ., 2011, 540 дахь тал

<sup>111</sup> Монгол Улсын стандарт: MNS 4967:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт

<sup>112</sup> Засгийн газрын 2015 оны 11 дүгээр тогтоолын хавсралт

*Анагаах ухааны талаас:* Анагаахын тайлбар тольд “Чадвар мэдлэгийг ашиглан өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэхийг чадвар гэнэ. Чадвар нь аливаа юманд хандах, харилцах, асуудал тодорхойлох, шийдвэр гаргах, эргэцүүлэн сэтгэх, багаар буюу хамтран ажиллах, гардан үйлдлийн гэж хуваагддаг. Чадвар нь аливаа зүйлийг гүйцэтгэх үр дүй, бүтээмжийн түвшинг хэлнэ”<sup>113</sup>.

“*Чадвар алдалт* аливаа зорилготой хөдөлгөөнийг хийж чадахгүй байхыг хэлэх бөгөөд энэ нь биеийн, танин мэдэхүйн, оюун санааны мэдрэхүйн, сэтгэл хөдлөлийн болон хөгжлийн бэрхшээл эсвэл дээрх бүгд хавсарсан гэх мэт олон янз байдаг. Чадвар алдалтад нийгмийн болон хувь хүний хүчин зүйлс ихээхэн нөлөөлдөг”<sup>114</sup>. Шүүх эмнэлэгийн практикт “Хөдөлмөрийн чадвар - ажлыг тодорхой хэмжээ, чанартай гүйцэтгэх биеийн болоод оюуны чадамжийн нийлбэр. Ерөнхий хөдөлмөрийн чадварт өөрөө өөртөө үйлчлэх мэргэжлийн бус чадвар, ерөнхий хөдөлмөрийн чадвар алдахад өөртөө үйлчлэх, энгийн, мэргэжлийн бус чадваргүй болох. Харин мэргэжлийн хөдөлмөрийн чадварт тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, үр чадвар, дадлага туршлагатайг, мэргэжлийн хөдөлмөрийн чадвар алдахад тухайн мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй болно.

*Хөдөлмөрийн чадвар алдалт* өвчин гэмтлийн улмаас түр ба байнга, бүрэн ба хэсэгчлэн ажлыг тодорхой хэмжээ, чанарын түвшинд гүйцэтгэх чадваргүй болох”<sup>115</sup> гэж тус тус тодорхойлсон.

Анагаах ухааны тайлбарт хөдөлмөрийн чадвар бүрэн алдахыг тодорхой хувиар зохицуулаагүй тул хуулийн энэ нэр томъёог нэг мөр болгож анагаах ухааны тайлбараар оруулж өгөх шаардлагатай.

### III. “Сэтгэл засал” гэх нэр томъёоны тухайд

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.9 дэх хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно” гэж заасан.

#### “Сэтгэл засал” гэх ойлголтын тайлбар:

*Хууль зүйн талаас:* Эрүүл мэндийн сайдын А/512 тоот тушаалын хавсралтад “Сэтгэл засал гэж сэтгэцийн эмгэг /түгшүүр, сэтгэл гутрал, гэмтлийн дараах стрессээс үүдэлтэй эмгэг гэх мэт/ болон зан үйлийн эмгэг /түрэмгий байдал, цочмог зан, хор хохирол учруулах үйлдэл гэх мэт/-тэй хүмүүст ярилцлага болон бусад аргаар эмчилгээ хийхийг” хэлнэ. Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журмын 1.2-т “сэтгэлзүйн цочмог хариу урвалууд илэрсэн, сэтгэл зан үйлийн эмгэг /айдсын эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, “*дасан зохицохуйн эмгэг*”, хувирах болон эмгэг, солиорох эмгэг/-т өртсөн хохирогчид сэтгэл заслын тусламж үйлчилгээ”<sup>116</sup> үзүүлнэ. Мөн журмын 1.5-д<sup>117</sup> сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дараах үндсэн зарчмыг баримтлах талаар хуульд зааснаас өөр тайлбар, тодорхойлолт байхгүй байна.

*Анагаах ухааны талаас:* Монголын Анагаах ухааны үндэсний нэвтэрхий толь “Сэтгэл засал (Psychotherapy) сэтгэл зүйн аргуудын тусламжтайгаар сэтгэл зүйн гаралтай бие махбодийн эмгэгүүдийг эмчлэхийг сэтгэл засал гэнэ. Сэтгэл заслын эмчилгээнд ашигладаг сэтгэл зүйн олон аргууд байдаг. Хувь хүний өвчин үүссэн шалтгаан, эмнэл зүйн байдал, хувь хүний сэтгэлзүйн онцлогоос хамааран сэтгэлзүйн эмч сэтгэлзүйн аргуудаас сонгон эмчилгээнд”<sup>118</sup> хэрэглэдэг гэж тодорхойлсон бол “...сэтгэлзүйн (сэтгэлийн) гарал үүсэлтэй биеийн болон сэтгэцийн эмгэгүүдийг эмчлэхийг сэтгэл засал”<sup>119</sup> гэж Монгол Улсын хүний гавьяат эмч, профессор С.Бямбасүрэн “*Сэтгэцийн эмгэг судлал*” бүтээлдээ тодорхойлсон байна. Мөн сэтгэл заслын үндсэн зорилго бол “тухайн хувь хүний хэвийн үйл ажиллагаанд буюу түүний хэвийн хөгжилд саад болж байгаа эмгэг процессыг дарах хийгээд зогсоох, эсхүл

<sup>113</sup> Лхагвасүрэн.Ц, нар, Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. III боть. УБ., 2012, 1730 дахь тал

<sup>114</sup> Мөн тэнд 1731 дэх тал

<sup>115</sup> Ганболд.Ц нар, Шүүх эмнэлгийн нэр томъёоны тайлбар толь, УБ., 2015. 218 дахь тал

<sup>116</sup> Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 тоот тушаалын 2 дугаар хавсралт, 1.2 заалт

<sup>117</sup> Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 тоот тушаалын 2 дугаар хавсралт, 1.5 заалт Сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ-үйлчлүүлэгчийн нэр, төр, эрхийг хүндэтгэн нас, хүйс, яс, үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахгүй байх;-үйлчлүүлэгчийн амь нас эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах;-үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах, нууцыг чандлан хадгалах;-үйлчлүүлэгчидтэй үр дүнтэй харилцаа үүсгэх;-үйлчлүүлэгчийг тэвчээртэй сонсох;-үйлчлүүлэгч бүрийг хувь хүн талаас нь сайн ойлгох;-үйлчлүүлэгчдэд тохирсон зөвлөгөө өгөх;-үйлчлүүлэгчтэй эргэх холбоо үүсгэх дараах үндсэн зарчмыг баримтална

<sup>118</sup> Лхагвасүрэн.Ц нар, Монголын Анагаахын үндэсний нэвтэрхий толь. III боть. УБ., 2012, 1167 дахь тал

<sup>119</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 292 дахь тал



энэхүү эмгэг процесс эсрэг үйлдэл үзүүлэхэд сэтгэц заслын үндсэн зорилго”<sup>120</sup> оршдог бөгөөд сэтгэц заслын арга болон зорилгыг харгалзан дараах ангилал, хэлбэрүүдэд хуваадаг. Үүнд: *“Ятгах, Ухааруулах, Танин мэдэхүйн, Төрх үйлийн, Танин мэдэхүйн-төр үйлийн, Бясалгал, Психоанализын, Экзистенциаль, Хөдлөл зүйн, Жекобсоны аргаар дэс дараалалтайгаар булчин сулруулах, Өөрөөс гаралтай дасгал, Ховсоор эмчлэх, Тоглоомын, Сэтгэц заслын бусад хэлбэр”*<sup>121</sup> гэх мэтээр ялгаж үздэг. Мөн сэтгэц засал *“...оролцож байгаа субъектын тоогоор нь нэг буюу хувьчилсан, олон буюу бүлгийн сэтгэц засал гэсэн хоёр хэлбэрт”*<sup>122</sup> хуваадаг гэсэн байна.

Иймд зөвхөн хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээнд сэтгэл заслын эмчилгээг хэрэглэх бус ялын бусад төрөлтэй хэрхэн хослуулах боломжийг эрж хайх нь зүйтэй байна.

#### **IV. “Өсвөр нас” гэх нэр томъёоны тухайд**

Хууль тогтоогч эрүүгийн хуульд 14-18 насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдвэл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан нь өсвөр нас гэдэгт 14 насанд хүрсэн, 18 хүрээгүй хүмүүсийг хэлсэн. Өсвөр насны ойлголт нь хүн судлалын талаас арай өргөн хүрээнд судлагдах бөгөөд насны үечлэлийг, сэтгэц хөгжилтэй харьцуулан дүгнэлт хийж тодорхойлдог. Одоо мөрдөгдөж буй шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлийг Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл гэж мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д *“Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд энэ бүлэг заасан үндэслэл, журмны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”* гэж заажээ.

##### **“Өсвөр нас” гэх ойлголтын тайлбар:**

*Хууль зүйн талаас:* Эрх зүйн эх толь бичг “өсвөр нас - хүүхэд наснаас нас бие гүйцэхэд шилжих үе буюу 12-18 насны үе”<sup>123</sup> тодорхойлсон. 2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 16 насанд хүрсэн этгээдэд гэсэн ч зарим хүнд гэмт хэрэг 14-16 насанд хүрсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэжээ. Мөн хуулийн ерөнхий ангийн 69 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах талаар хуульчилсан. Өмнө нь хэрэгжиж байсан эрүүгийн болон процесс хуулинд насанд хүрээгүй этгээд гэсэн нэр томъёо хуульчлагдсан байсныг шинэчлэн найруулахдаа өсвөр насны хүн болгон өөрчилсөн.

Гэвч бусад хуулинд насанд хүрээгүй хүн гэх нэр томъёо хэрэглэгдсэн хэвээр байна. Үүнд: Хүүхдийн эрхийн конвенцид *“...18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд”*<sup>124</sup> мөн Хүүхдийн эрхийн тухай хуульд *“Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ”*<sup>125</sup> бас Хүүхэд хамгааллын тухай хуульд *“Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно”*<sup>126</sup> гэсэн бол Иргэний хуулийн 16 дугаар зүйл. *Иргэний эрх зүйн бүрэн бус чадамж гэдэгт 16.1-д “Насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны этгээд ирээний эрх зүйн бүрэн бус чадамжтай” байхаар заасан нь өсвөр насны дээд хязгаарыг 18 насанд хүрээгүй хүн гэх ойлголттой тохирч байгаа боловч насны доод хязгаарыг тодорхойлж чадахгүй байна. Одоогийн үйлчилж байгаа эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.2.3-д “Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж” болно гэснийг харвал 14 нас нь өсвөр нас гэх ойлголтын доод босго нас болж байна.*

*Анагаах ухааны талаас:* Дээрх өсвөр насны хүн гэх ойлголтыг насны ангилал талаас судалбал, Монголын Анагаах ухааны үндэсний нэвтэрхий толь “Өсвөр үе хүүхдийн амьдралын 2 дахь арван жилийг өсвөр үе гэдэг. Дотор нь: эрт өсвөр үе 10-14 нас; дунд өсвөр үе 14-17 нас; Хожуу өсвөр үе 18-19 нас гэж ялгадаг. Өсвөр үе нь хүүхэд наснаас насанд хүрэхийн завсрын онцлог үе бөгөөд хүүхдийн бие бялдар, сэтгэц, оюун, нийгмийн харилцаанд онцлог

<sup>120</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 292 дахь тал

<sup>121</sup> Бямбасүрэн.С, Сэтгэцийн эмгэг судлал, УБ., 2007, 292 дахь тал

<sup>122</sup> Мөн тэнд

<sup>123</sup> Нарангэрэл.С, Эрх зүйн эх толь бичиг. гурав дахь хэвлэл. УБ., 2011, 365 дахь тал

<sup>124</sup> Хүүхдийн эрхийн конвенцид. 1990., 1 дүгээр зүйл

<sup>125</sup> Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016., 3.1 дэх заалт

<sup>126</sup> Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016., 3.3 дахь заалт

өөрчлөлтүүд гарч, бэлгийн бойжилт хүйс ялгавартай явагдаж, бэлгийн хоёрдогч шинжүүд илрэх тул тэдэнд эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ шаардагддаг.

...Дур зориг, ухамсар, ёс зүй боловсрох, сэтгэцийн хөгжлийн хамгийн хүнд үе, ямарваа /сайн, муу/ нөлөөнд автамхай, насанд хүрэгчдийн зан үйлийг дуураймтгай, аливаа зүйлийг туршиж үзэх сонирхолтой байдаг. Энэ үед оюун сэтгэц хөгжин ерөнхий боловсрол эзэмших тул охид, хөвгүүд амьдралын бүх явдлыг эргэцүүлэн дүгнэдэг. ... Өсвөр үеийнхэн хорт зуршилд /архи, тамхи, мансууруулах бодис/ өртөмхий, амиа хорлох оролдлого тохиолдоно"<sup>127</sup>. ДЭМБ-ын гаргасан насны үечлэлийн системээр: өсвөр насны үе (11-20) нас гэж ангилдаг. "Шүүх эмнэлгийн хүрээнд өсвөр насны (14-20) нас гэж ангилж"<sup>128</sup> үзэж байгаа нь хуульд зааснаар 14-18 насанд хүрээгүй хүн гэх тодорхойлсон насны түвшний хүрээнд тохирч байна.

Хууль санаачлагчид өсвөр насны хүн гэдгийг субъектын насны онцлогийг харгалзан тогтоосон бол учир дутагдалтай юм. Сэтгэц судлалын шинжлэх ухаанд өсвөр үеийг судлахдаа насны ангилал, бэлгийн бойжилт, сэтгэцийн хөгжил гэх мэт олон шалгуурыг зэрэгцүүлэн судалж, үнэлэлт, дүгнэлт өгдөг. Өөрөөр хэлбэл хүүхэд насны үеэс насанд хүрэх үе буюу шилжилтийн үе гэж үздэг. Энэ үед бие махбодийн /физиологийн/ нийгмийн болон сэтгэлзүйн хөгжлийн үзүүлэлтүүд өсвөр насны үечлэл бүрт өөр өөр байдаг.

Иймд өсвөр насны хүүхэд гэдэг ойлголтыг хэрэглэхдээ насны ангилал, бэлгийн бойжилт, сэтгэцийн хөгжлийн үечлэлийг нарийн тооцож хэрэглэх нь зүйтэй.

### Санал

- "Эрүүгийн хуульд гэмт хэргийг нь маш оновчтой, тодорхой байдлаар хуульчлах ёстой тул хоёрдмол болон салаа утгагүй, оновчтой нэр томъёог сонгож хэрэглэх:

- Аливаа нэр томъёог зөв сонгох нь хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжлүүлэх үндэс бий болно:

- Хуульд бусад шинжлэх ухааны ойлголт, нэр томъёо хэрэглэхэд тухайн шинжлэх ухааны тайлбарыг жишиг болгох:

- Эрүүгийн хуулийн нэр томъёог боловсронгуй болгох нь зүй ёсны асуудал боловч уламжлалт нэр томъёог хэт үгүйсгэх нь зарим талаар дэвшил биш ухралт болж болзошгүй юм"<sup>129</sup>.

- Энэ бүгдийг нэр томъёо тодорхойлохдоо тусгаж байвал практик хэрэглээнд гаргах алдаа, ойлгомжгүй байдал, хүндрэлээс сэргийлэх боломжтой.

<sup>127</sup> Лхагвасүрэн.Ц, нар, Монголын Анагаахы үндэсний нэвтэрхий толь. II боть. УБ., 2012, 994 дэх тал

<sup>128</sup> Шүүх эмнэлэг, Монгол улсад шүүх эмнэлгийн алба байгуулагдсаны 55 жилийн ойд зориулав. УБ., 2015, 213 дахь тал

<sup>129</sup> Эрдэнэбулган.Ж, "Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ" сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016, 99 дэх тал

## МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХҮН БАРЬЦААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

*Д.Сундуйсүрэн*  
*ХСИС-ийн ХСУА-ийн УУПБ-ийн профессор,*  
*цагдаагийн хурандаа*

**Товч агуулга:** Түүхэн цаг үеийн турш хүн барьцаалах, түүнтэй төстэй гэмт явдлын арга, хэлбэр өөрчлөгдөж, энэ төрлийн гэмт үйлдэлтэй хууль, эрх зүйн аргаар тэмцсээр иржээ.

Сэдвийн хүрээнд хүн барьцаалахтай төстэй гэмт явдалтай тэмцэж ирсэн ардчилсан хувьсгалт хуулийн үе, 1990 оноос хойшхи Монгол Улсын хууль тогтоомжид хүн барьцаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагдсан байдлыг харьцуулан судалсан.

**Түлхүүр үг:** Барьцаа, барьцааны хүн, хүн барьцаалах гэмт хэрэг, эрх, эрх чөлөө, нөхцөл, болзол, цаг үе, шаардлага.

### ОРШИЛ

Монгол төр, эрх зүйн түүхэнд холбогдох нэгэн чухал эх сурвалж нь Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын үеийн буюу 1913-1918 оны хооронд үйлчилж байсан “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” юм. Энэхүү эх сурвалж нь “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” үйлчлэх хүртэлх нийгмийн харилцааг зохицуулж байжээ.

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” хэмээх хууль цаазын эх сурвалжийг зохиолгохоор 1915 онд Богд хааны зарлигаар комисс байгуулж<sup>130</sup>, Манж Чин улсын үеийн “Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны Хууль зүйлийн бичиг” болон бусад хуулийг нягтлан монгол хэлээр орчуулж таван дэвтэрт нэгтгэсэн байна. Ингээд 1918 онд уг хуулийг зохиож, хэлэлцэн батлах үе үндсэндээ дуусаж хэвлэх ажиллагаа эхэлжээ.<sup>131</sup>

Шинэ хууль цаазын эрүүгийн заалтуудыг зөвхөн 1917-1918 онд Улсын дээд, доод хуралд 20 гаруй удаа хянан хэлэлцсэнээс үзвэл “шинэтгэн тогтоох хуулийн эрүүгийн зураг”-ийг засч залруулахад ихээхэн ач холбогдол өгчээ.

### 1. Хүн барьцаалахтай төстэй гэмт явдалтай тэмцэж ирсэн ардчилсан хувьсгалт хуулийн үе ( XX зууны эхэн - II хагас)

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” нь феодалын үеийн бусад хуулийн адил орчин үеийн олон салбар эрхийг өөртөө багтаасан боловч эрүү болон захиргааны эрхийн цаазууд зонхилох суурийг эзэлж байсан. Энэ хуулийн бараг бүх дэвтэрт эрүүгийн эрхийн агуулгатай хэм хэмжээнүүд тохиолддогийн гадна ялангуяа 9 дүгээр дэвтэр нь бүхэлдээ эрүүгийн эрхийн асуудлуудыг тогтоосон юм.<sup>132</sup>

Эл хуулийг хэдийгээр тухайн цаг үеийн хуучин хууль цаазын суурин дээр бүтээсэн боловч туурга тусгаар болсон Монгол улсад нийгмийн бүхий л салбарт шинэлэг харилцааг үүсгэн бий болгох, тэдгээрийг үр нөлөөтэй зохицуулах хэрэгцээнээс урган гарсан, үндэсний онцлогт нийцсэн олон хэм хэмжээг түүхийн ахар богино хугацаанд тогтоон мөрдүүлжээ.

“Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн 55, 58 дугаар дэвтэрт хүн барьцаалахтай төстэй гэмт хэргүүдийг хуульчлан тусгасан байна. Үүнд: Хулгай барих түшмэл цэрэг, сайн хүнийг сүр хүчээр барих, хүлэх нь: Нэгэн зүйл “Хулгай барих түшмэл цэрэг жич, хүчирхэг идэрхэг ард сайн хүнийг сүр хүчээр дарлан барьж уяж хүлэх ба зоригоор гэрт хорих, аргалан жанчих болбоос хор хийсэн үл хийснийг асуухгүй түшмэлийг зургаан ёсон мал торго<sup>133</sup>. Цэрэг ардыг наян ташуур занч”, Монгол гадаад хүн лугаа хоршоолж булааж уулгалах нь: Нэгэн зүйл “Монгол газар уулгалан булаах хэргийн дотор хэрэв монгол гадаадын хүн лугаа нэгнээ хоршоолж уулгалан булаах нь буй бөгөөс халдсан ялыг үзэн гадаад улсын түшмэлийн хамт нийлж хянаа байцаагаад өөр өөрийн хууль бичгийн ёсоор шийтгүүлэгтүн”<sup>134</sup>. Ялт хүнийг булаах нь: Нэгэн зүйл.”Аливаа ялт хүнийг булааваас тэргүүн дэдийг ялгахгүй цөм буудан ал. Гянданд

<sup>130</sup> Амарсанаа Ж., Баярсайхан Б. Чимид Б., Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл II боть (1911-1926). -Уб., 2010. 309 дэх тал

<sup>131</sup> Мөн тэнд. 36 дахь тал

<sup>132</sup> Совд Г. “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” (ерөнхий анги). -Уб., 1973. 48 дахь тал

<sup>133</sup> Амарсанаа Ж., Баярсайхан Б. Чимид Б., Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл II боть (1911-1926). -Уб., 2010. 309 дэх тал

<sup>134</sup> Мөн тэнд. 312 дугаар тал

хорьж хүлээлгэ. Гагцхүү булааваас даруй оноогтүн. Ирэхгүй ялт хүнийг олсныг үзэхгүй хэрэв ялт хүний зоригор хулган тавьж оргуулбаас ялт хүний адил ял. Үхэхэд хүрвээс нэгэн зэрэг хорогдуул”<sup>135</sup> гэж заажээ.

Энэ хууль зүйлийн бичгийн энэхүү заалт нь гэмгүй хүнийг хүч хэрэглэн барьж, хорих, гадаад хүнийг уулгалан булаах, ялт хүнийг булаах, ялт хүнийг хулгайлан тавьж оргуулах, хүний эрх чөлөөг хязгаарлаж барьцаа болгох үйлдлийг уламжлал болгон хориглож, тэргүүн дэдийг ялгалгүй шударгаар шийтгэж, гэмт хэрэгт хамтран оролцсон буюу хамаарч буй этгээдүүдэд ял шийтгэл ялгамжтай оногдуулж иржээ.

Монгол оронд өрнөсөн 1921 оны ардын хувьсгал нь монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авсан түүхэн үйл явдал бөгөөд ард түмний хүсэл зоригийг илэрхийлсэн төрт ёс, эрх зүйн хөгжлийн шинэ үеийг нээсэн юм.

Улсын анхдугаар их хурал 1924.11.08-нд нээгдэж улс орны тулгамдсан олон асуудал шийдвэрлэсний дотор тус улсын анхны Үндсэн хуулийг 1924.11.26-нд санал нэгтгэйгээр батлан гаргаж хувьсгалын ялалтыг хуульчлан бэхжүүлж, ард түмний ардчилсан эрхийг тунхаглан зарлаж өгсөн нь хувьсгалт эрүүгийн эрхийн үндсэн бааз гол эх сурвалж болсон юм.<sup>136</sup>

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн дөрөвдүгээр зүйлд “Улсын шүүн таслах газрууд хэргийг явуулах үүргийн хэмжээ, мөн иргэний ба эрүүгийн хууль зүйг тогтооно” гэж улмаар 1925 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын 2 дугаар их хурлаас шүүхийг шинэчлэн байгуулах тогтоолоор эрүүгийн эрх зүйн үндсэн зорилт, зарчмын суурийг тавьсан гэж үздэг. 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн засгийн газрын нэгдүгээр хурлаар Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг мөн оны 11 дүгээр сард хуралдсан Улсын III дугаар их хурлын 10 дахь өдрийн тогтоолоор тусгай ангитай нь хамтатган баталсан бөгөөд ингэж ерөнхий болон тусгай ангийг баталснаар бүрэн хэмжээний эрүүгийн эрх зүйн эх сурвалж анх удаа бүрэлдсэн болно.<sup>137</sup> Монгол Улсын анхны төрөлжсөн Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 7 бүлэг 40 зүйлтэйгээр, мөн тусгай ангийг 24 бүлэг 187 зүйлтэйгээр батлан гаргаж хэрэгжүүлжээ.

БНМАУ-ын анхны Шүүх цаазын бичгийг боловсруулан баталсан явдал нь шинэ төрийн хууль тогтоох үйл ажиллагаанд гарсан том амжилт, өөрийн орны хууль цаазын үндэсний уламжлал, ардын зан заншил, ардчилсан хувьсгалт төр, нийгмийн хөгжлийн өвөрмөц онцлогийг тусгасан, эрүүгийн эрх зүйн онол хөгжих суурийг тавьсан, эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан хэм хэмжээгээр зохицуулах болсон түүхэн ач холбогдол бүхий үйл явдал гэж үе үеийн эрүүгийн эрхийн судлаач, эрдэмтэд дүгнэсэн байна.<sup>138</sup>

1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд “Энэхүү шүүх цаазын бичгийг зарласан өдрөөс хойш гарсан аливаа гэмт явдал, үйлдсэн хэрэгт журамлан дагаж шийтгэвэл зохино”<sup>139</sup> гэж заасан бөгөөд шүүх цаазын бичгийн тайлбарт “Аливаа цааз хууль дор заасан гэмт явдлыг гэмт хэрэгт тооцвоос зохино” гэж гэмт хэргийн тодорхойлолтыг анх удаа өгсөн байдаг боловч гэмт хэргийн тухай ямар ч хуульд зааж болохоор агуулгатай байгаа нь учир дутагдалтай болжээ.

1926 оны шүүх цаазын бичигт хүн барьцаалах болон түүнтэй төстэй үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт байжээ. БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн тусгай ангийн “Зүй бусаар бусдын эрх чөлөөнд халдах нь” хэмээх 26 дугаар бүлгийн 184 дүгээр зүйл: “Аливаа хүн бусдыг зоргоор барих, хорих аваас 1 жил хүртэл гянданд хорино. Хэрэв хүндэтгэн (хүндрүүлж) үзэх зүйл буй аваас 3 жил хүртэл гянданд хорино.”<sup>140</sup> 185 дугаар зүйл: Аливаа хүн дур зоргоор бусдыг барьж, хорьсон нь: 1) Эцэг эх; 2) Албаны хүмүүс ноогдсон албан тушаалаа гүйцэтгэж буй цаг; 3) Барих, хориход хүний амь биед хорлолтой харгис хатуу арга хэрэглэх зэргээр зовоовоос 1-3 жил хүртэл гяндан хорино<sup>141</sup>, 186 дугаар зүйл: Аливаа хүн ашгийг хичээж ба өших зэргээр муу сэтгэлээр бусдын нялх хүүхдийг булаах, нуух буюу сольж авбаас 1-3 жил хүртэл гяндан хорино<sup>142</sup> гэсэн заалт юм. Эдгээр зүйлүүдэд хүн барьцаалах гэмт хэргийг нарийвчлан зохицуулаагүй боловч хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж бүхий “хүнийг барих, хорих ... булаах зэрэг үйлдэл тусгагдсан бөгөөд тэдгээрийг

<sup>135</sup> Мөн тэнд. 324 дүгээр тал

<sup>136</sup> Совд Г. Дурдсан зохиол. -Уб., 1973. 55 дахь тал

<sup>137</sup> Совд Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. Уб., 1973. 55 дахь тал

<sup>138</sup> Содовсүрэн Б. БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. -Уб., 1971. 42 дахь тал

<sup>139</sup> Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. Уб., 1998. 7 дахь тал

<sup>140</sup> Баярсайхан Б., Жанцан С. нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011. 304 дэх тал

<sup>141</sup> Адъяабазар Д. “Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” -Уб., 1998. 29 дахь тал

<sup>142</sup> Мөн тэнд. 30 дахь тал

анх удаа гэмт хэрэгт тооцсон, тухайн үед хүн барьцаалах үйлдэл гарвал тус зүйлээр зүйлчлэн шийдвэрлэх үндэстэй байжээ.

Мөн хуулийн “Ял үл хэлэлцэх” гэсэн гуравдугаар бүлгийн 19 дүгээр зүйлд “10 нас хүртэлх багачууд хэрэг халдваас ялыг үл хэлэлцэнэ” мөн хуулийн 17 дугаар зүйлд “11 наснаас 14 нас хүртэлх багачууд хөнгөн ял халдваас тэдний эцэг, эх буюу итгэмж бүхий хүмүүс нь хүлээн авсугай, хэмээвээс даруй тушаан өгч сурган хүмүүжүүлж болох ба хэрэв хүнд ял халдваас засан сайжруулах газар тушаан өгч сурган хүмүүжүүлвээс зохихоос гадна 15, 16, 17 насны залуус хэрэгт халдваас бусад ялтнаас тусад нь хорьж шийтгэвэл зохино” гэжээ. Үүнээс үзэхэд энэ хуулиар гэмт хэргийн субъектын насны доод хязгаарыг 10 насаар тогтоож байсан байна. Мөн хуулийн 6 дугаар зүйлд хорих ялын хугацааг нэг өдрөөс 10 жилээр албадан хөдөлмөрлүүлэхтэй хослуулж хэрэглэхээр хуульчилсан ба хэдийгээр энэ хуульд гэмт хэргийн ангиллыг тогтоогоогүй боловч хүн барьцаалахтай төстэй дээрх гэмт хэргүүд хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарахаар байна.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичиг нь Засгийн газрын 1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар хурал, Улсын ХИҮ бага хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулж батлан мөрдөж эхэлснээр 1926 оны шүүх цаазын бичиг хүчингүй болсон байна.

1929 оны Шүүх цаазын бичиг нь 1926 оны Шүүх цаазын бичгийн систем, зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт оруулаагүй боловч хуулийг дахин боловсруулахдаа түүний хэм хэмжээг ойлгож хэрэглэхэд хялбар болгож сайжруулсан нь хуулийг бүхэлд нь шинээр батлах шалтгаан болсон байна.<sup>143</sup>

Тус Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 25 дугаар бүлэгт хүн барьцаалахтай төстэй, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдсан гэмт хэргийг дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулан тусгасан байна. Үүнд: “Зүй бусаар бусдын эрх чөлөөнд халдах нь” 189 дүгээр зүйл: Аливаа хүн бусдын зоргоор барих, хорих аваас 1 жил хүртэл хорино. Хэрэв хүндэтгэх зүйл буй аваас 3 жил хүртэл хорино<sup>144</sup>. гэж заасан нь ял шийтгэлийн хугацааны хувьд өөрчлөлт ороогүй, урьд нь гянданд хорихоор заасан байсныг өөрчилж “хорих” болгон хөнгөрүүлсэн бөгөөд ял эдлүүлэх дэглэмийн хувьд сонгох боломжийг олгосон байна.

1929 оны Шүүх цаазын бичиг батлагдсанаар 1926 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 185 дугаар зүйл (Аливаа хүн бусдыг дур зоргоор барьж, хорьсон нь) хүчингүй болсон бөгөөд шинээр 190 дүгээр зүйлд: Аливаа хүн ашгийг хичээх ба өшөөлөх зэрэг муу сэтгэлээр бусдын нялх хүүхдийг булаах, нуух буюу сольж авбаас 1-3 жил хүртэл хорино<sup>145</sup> гэсэн нэмэлтийг оруулжээ.

Энэ шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 1934 оны 5 дугаар сарын 4-нд Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөн сарын 24-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас 6 бүлэг 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр 1934 оны 8 дугаар сарын 24-нд Сайд нарын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөн оны 10 сарын 8-нд Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн газраас тус тус батлан гаргасанаар 1929 оны Шүүх цаазын бичиг нэмэлт, өөрчлөлтийн хамт хүчингүй болжээ.

1934 оны БНМАУ-ын Шүүх цаазны бичгийн тусгай ангийн “Хүний амь бие ба эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдарт харшлах гэмт хэргүүд” хэмээх 6 дугаар бүлэгт хүн барьцаалахтай төстэй, хүний халдашгүй чөлөөтэй байдалд аюул занал учруулсан гэмт үйлдэлд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг дараах байдлаар хуульчилж өгсөн байна. Энэ нь 127 дугаар зүйл: Барих, хорих зэргээр эрх чөлөөг алдагдуулахдаа хүний амь ба эрүүл мэндэд аюултай арга хэрэглэх буюу хүний бие махбодид зовлон учруулсан бол 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. 128 дугаар зүйл: Ашгийг хичээх ба өш хонзонгоос буюу өөр зүйлүүд, хувийн явдлаас бусдын хүүхдийг хулгайлсан ба нуусан, эсхүл сольсон бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино<sup>146</sup> гэж хуульчилжээ. 1934 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 128 дугаар зүйлд “бусдын хүүхдийг хулгайлсан” бол анх удаа гэмт хэрэгт тооцохоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Мөн шүүх цаазын бичгийн тусгай ангийн 127 дугаар зүйлд хүн барьцаалах гэж томъёолоогүй боловч хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг тусгаж өгөхийг оролдсон бөгөөд тухайн гэмт хэрэгт оноох хорих ялын хугацааг өөрчилсөн байна.

Сайд нарын зөвлөлийн 1939 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Феодалын үлдэгдэл ба ялангуяа үндэс угсааны өшөө хонзон хадгалах явдалтай тэмцэх арга хэмжээний тухай”

<sup>143</sup> Содовсүрэн Б. “БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” -Уб., 1971. 8 дахь тал

<sup>144</sup> Баярсайхан Б., Жанцан С. нар Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011. 337 дахь тал

<sup>145</sup> Адъяабазар Д. Дурдсан бүтээл. 62 дахь тал

<sup>146</sup> Мөн тэнд. 93 дахь тал

тогтоолын заалтыг биелүүлэх үүднээс 1934 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангид нэмэлт, өөрчлөлт оруулснаар олон эхнэр авах, эхнэр авахаар эцэг эх болон төрөл садан, бусад этгээдэд бэлэг сүй хүргэх, авах, эмэгтэйчүүдийг гэрлүүлэхээр албадан хавчих, хүслийн эсрэг гэрлүүлэх, дээр дурдсан зорилгоор эмэгтэйчүүдийг хулгайлах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцжээ.<sup>147</sup>

МАХН-ын Төв Хороо 1939 онд тус улсын Үндсэн хуулийг өөрчлөхөөр Үндсэн хуулийн төсөл боловсруулах удирдамж гарган ажиллаж, БНМАУ-ын 8 дугаар Их Хурлаар хэлэлцүүлэн 1940 оны 6 дугаар сарын 30-нд баталснаар хөрөнгөтний бус хөгжлийн социализм байгуулах зорилготой социалист хэв маягийн анхны Үндсэн хууль болсон.<sup>148</sup>

Ингэснээр шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж байдаг бусад хуулийг өөрчлөх шаардлага зүй ёсоор гарч ирсэн юм. 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас тогтоол гаргаж 1934 оны 5 дугаар сарын 24-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн ерөнхий анги, 1934 оны 10 дугаар сарын 8-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн тусгай анги, энэ хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг хүчингүй болгож БНМАУ-ын Эрүүгийн хууль гэсэн шинэ нэртэйгээр тус хуулийг батлан гаргажээ.<sup>149</sup>

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг 6 бүлэг, 54 зүйлтэйгээр, тусгай ангийг 10 бүлэг, 165 зүйлтэйгээр баталсан бөгөөд энэ хуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг сонирхлыг хамгаалалтад авсан бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулбал тогтолцоо, бүтцийн хувьд илүү боловсронгуй болсон байна.

Тус Эрүүгийн хуульд хүн барьцаалахтай төстэй, хүний хувийн эрх чөлөөнд халдсан гэмт хэргийг дараах байдлаар тусгажээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн VII дугаар бүлэг (Хүний амь бие, эрүүл мэнд ба эрх чөлөө хийгээд нэр алдарт харшлах гэмт хэргүүд)-ийн 158 дугаар зүйлд “Хэн нэгэн хүнийг дур зоригоор барьж, хорих зэргээр эрх чөлөөг алдагдуулсан байвал нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэж шийтгэнэ. Хэрэв барих хорих зэргээр эрх чөлөөг алдагдуулахдаа хүний амь бие ба эрүүл мэндэд аюултай арга хэрэглэх буюу хүний махбодид зовлон учруулсан байвал таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ”<sup>150</sup> гэжээ. Энэ хэргийн үндсэн бүрэлдэхүүнд онцын өөрчлөлт ороогүй боловч хүндрүүлэх бүрэлдэхүүнийг зааж өгсөн, ял шийтгэлийн хугацааг нэмж чангаруулсан байна. Мөн хуулийн 159 дүгээр зүйлд “Бусдын үр хүүхдийг шунахай зорилгоор ба өшөө хонзон буюу бусад хувийн атаа тэмцлээр хулгайлах, нуух ба солих мөн түүнчлэн худалдаалан авч өгөлцөх бол 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ”<sup>151</sup> гэж заажээ. Энэ хуулиар “Бусдын үр хүүхдийг ... худалдаалах” үйлдлийг анх удаа гэмт хэрэгт тооцсон байна.

БНМАУ-ын Их Хурлын дөрөв дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1960 оны 7 дугаар сарын 6-нд манай улсын түүхэн дэх гурав дахь Үндсэн хуулийг батлан гаргав. Энэ суурь хуульдаа Эрүүгийн хуулийг нийцүүлэн боловсруулж 1961 оны 1 дүгээр сарын 31-нд АИХ-ын II чуулганаар баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдсөн түүхтэй. Энэ хуулийн ерөнхий анги 5 бүлэг, 44 зүйлтэй, тусгай анги 11 бүлэг 221 зүйлтэйгээр батлагджээ.<sup>152</sup>

Эрүүгийн хуулийн зорилго гэсэн 1 дүгээр зүйлд тусгаар тогтнол, төрийн бүрэн эрх, нийгмийн болон төрийн байгууламж, социалист өмч, иргэдийн амь бие, эрх, эрх чөлөө, хуулиар тогтоосон хэв журам зэрэг энэ хуулиар хамгаалагдах нийгэм, төр, байгууллага, иргэдийн амин чухал эрх ашиг, сонирхлыг нэрлэн заасан нь шинэлэг юм.

1961 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн материаллаг тодорхойлолтыг төгс утгаар өгч, 1942 оны хуульд байсан эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх заалтыг хүчингүй болгосноор хүний эрхийг дээдлэх хууль ёсыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.<sup>153</sup> “Гэмт хэргийн тухай” гэсэн хоёрдугаар бүлэгт гэм буруугийн санаатай ба болгоомжгүй хэлбэрүүдийн оюун санаа, хүсэл зоригийн шинжүүдийг улам тодорхой болгосон, 14-16 насны хүмүүс субъект болох гэмт хэргүүдийн хүрээг өргөжүүлэн заажээ. 1961 оны Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлгийн хүн барьцаалахтай төстэй, иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба нэр алдарт харшлах гэмт хэргүүд: 82 дугаар зүйл. Хүүхэд хулгайлах буюу солих а) Бусдын хүүхдийг

<sup>147</sup> Содовсүрэн Б. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. -Уб., 1971. 52-56 дахь тал

<sup>148</sup> Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүд (1924-1992). эмх.Батаа Д.Уб., 1998.1 дэх тал

<sup>149</sup> Амарсанаа Ж. Баярсайхан Б. Чимид Б. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл III боть. -Уб., 2010. 43 дэх тал

<sup>4</sup> Баярсайхан Б. Жанцан С. нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011. 391 дэх тал

<sup>151</sup> Баярсайхан Б. Жанцан С. нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011. 391 дэх тал

<sup>152</sup> Баярсайхан Б.,Жанцан С. нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011.102 дахь тал

<sup>153</sup> Мөн тэнд. 103 дахь тал

хулгайлах, нуух буюу санаатайгаар соливол гурван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. б) Энэ гэмт хэргийг шунахай буюу өөр бусад жигшүүрт зорилгоор үйлдсэн бол нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ<sup>154</sup> гэж заажээ. Энэ зүйлийн гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, бүрэлдэхүүний субъектив тал буюу гэм буруугийн “санаатай” хэлбэрийг онцлон зааж, мөн хүндрүүлэх бүрэлдэхүүнд нэмэлт, өөрчлөлт оруулж “шунахай буюу өөр бусад жигшүүрт” зорилгоор үйлдсэн бол гэж хүндрүүлэн заажээ.

1961 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 25 жилийн турш төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл байсан боловч түүний олон хэм хэмжээ гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тухайн үеийн шаардлагад илтэд нийцэхгүй болсон, төр, нийгэм, иргэдийн амин чухал олон эрх ашиг эрүүгийн хуулийн хамгаалалтын гадна үлдсэн учир шинэчлэн батлах шалтгаан болсон байна.

1983 онд социалист хууль ёсыг бэхжүүлэх зорилготой холбогдуулан 1961 оны Эрүүгийн хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж гаргахыг МАХН-ын Төв хорооны Улс Төрийн товчооны 316 дугаар тогтоолоор БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдэд даалгасан байна. Энэ үндсэн дээр БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид 1986 оны 12 дугаар сарын 5-нд “БНМАУ-ын шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийг батлах тухай” зарлиг гарган Эрүүгийн хуулийг 18 бүлэг 301 зүйлтэйгээр баталсан байна.

1986 оны Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зарчмуудыг анх удаа шинээр хуульчлаад тус хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй” гэсэн Үндсэн хуулийн тулгуур заалтыг суулгасан. Гэмт хэргийн нийгмийн хор аюул, ялын байдал хэмжээ, хэлбэр, гэм бурууг харгалзан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилсан нь Эрүүгийн хууль хэрэглэх үйл явцыг боловсронгуй болгов.<sup>155</sup>

## **2.1990 оноос хойшхи Монгол Улсын хууль тогтоомжид хүн барьцаалах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагдсан байдал**

“1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, оршилд нь тунхагласанчлан Монголчууд улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийн үүд хаалгыг албан ёсоор нээж өгсөн билээ” ... Манай оронд 1980-1990-ээд онд бий болсон улс төрийн нөхцөл байдал, хөгжил тэмцлийн үйл явц, үр дүнг тусган бэхжүүлсэн Монголын түүхийн шинэхэн үеийн хууль зүйн гол баримт бичиг мөн гэж хуульч Б.Чимид тодорхойлсон нь туйлын оновчтой байна.<sup>156</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга үзэл санаанд нийцүүлэн бусад хуулийг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай уялдуулан 1995.10.25-ны өдрийн 9/1203 дугаартай албан бичгээр С.Нарангэрэл, Д.Базарсад нарын гишүүд анх удаагаа “хүн барьцаалах”, “хүн хулгайлах” аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцуулахаар хуулийн төслийг УИХ-ын дарга Н.Багабандид өргөн барьсан байна. Хуулийн төслийг өргөн барьсан албан бичигт: “тус улсад гарч буй гэмт явдлын байдал, хандлага, шүүн таслах ажлын практик, эрүүгийн хэргийн талаархи прогноз, сонгогчид, олон түмний санал хүсэлт болон эрүүгийн хуулийг шинээр батлагдсан хуультай нийцүүлэх шаардлага зэргийг үндэслэн Үндсэн хуульд заасан хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж байна”<sup>157</sup> гэжээ.

Эрүүгийн хуульд нэмэлт оруулахаар дараах байдлаар төсөлд тусгажээ.

73<sup>1</sup> дүгээр зүйл. Хүнийг барьцаанд авах

1.Хүнийг барьцаанд авсан бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ хэргийн улмаас хүний амь насыг болгоомжгүй үрэгдүүлсэн буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол долоогоос хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

105<sup>1</sup> дүгээр зүйл. Хүн хулгайлах

1.Хүн хулгайлсан бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

2. Хүнийг

а/ хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж,

<sup>154</sup> Мөн тэнд. 103 дахь тал

<sup>155</sup> Мөн тэнд. 111 дахь тал

<sup>156</sup> Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Тэргүүн дэвтэр. УБ., 2002. 46 дахь тал.

УИХ-ын Тамгын газрын архив. 1996 оны 4 сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг. 1 дэх тал

<sup>157</sup> УИХ-ын Тамгын газрын архив. 1996 оны 4 сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг. 1 дэх тал.

- б/ шунахай, танхай буюу бусад, жигшүүрт сэдэлтээр,
- в/ насанд хүрээгүй хүнийг хулгайлсан,
- г/ урьдчилан тохиролцсон бүлэг этгээд,
- д/ давтан үйлдсэн,
- е/ онц аюултай гэмт хэрэгтэн,

ж/ хүний амь насыг болгоомжгүйгээр үрэгдүүлсэн буюу бусад хүнд хор уршиг учруулсан бол долоогоос арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. гэжээ.

Тухайн үеийн Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат УИХ-ын нэр бүхий гишүүдийн санаачилсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлтэй танилцаж, зарчмын хувьд дэмжиж саналаа 1995.12.19-ний өдрийн 61 дүгээр албан бичгээр илэрхийлжээ. Энэхүү албан бичигт “Эрүүгийн хуулийн 73<sup>1</sup> (Хүн барьцаанд авах), 105<sup>1</sup> (Хүн хулгайлах) зүйлүүдэд хүн хулгайлах, барьцаанд авах хоёрын ялгаа юу болох, хүнийг барьцаанд авах нь хүн хулгайлахаас илүү аюул хөнөөлтэй байдаг байхад хүн хулгайлах гэмт хэрэг үйлдэгсдэд хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдлыг долоон янзаар дэлгэрэнгүй тодорхойлсон атлаа хүн барьцаанд авах хэргийн хариуцлагыг тэгж заахгүй, хоёрхон зүйлээр хязгаарласны учир юу болох, хүнийг хулгайлахаас гадна булаах, дээрэмдэх аргаар авч болох тул ийм тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заах шаардлага бий эсэх”<sup>158</sup> -ийг анхаарч үзэх шийдвэрлэхийг санал болгожээ.

Монгол Улсын Их Хурал 1996 оны 4 сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, “Төрийн эсрэг бусад гэмт хэрэг” гэсэн бүлгийн 1/73<sup>1</sup> дүгээр зүйлд “Хүнийг барьцаалах”, 105<sup>1</sup> дүгээр зүйлд “Хүн хулгайлах” гэмт хэргийг анх удаа гэмт хэрэгт тооцон хуульчилжээ.

73<sup>1</sup> дүгээр зүйл. Хүн барьцаалах

1.Бусад этгээдээс мөнгө хөрөнгө гаргуулахаар болон өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, гүйцэтгэхээс татгалзуулах явдлыг барьцаанд байгаа этгээдийг суллах нөхцөл болгон тавьж уг этгээдийг барьцаалсан бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, түүнчлэн насанд хүрээгүй хүнийг болон жирэмсэн эмэгтэйг, эсхүл хэд хэдэн хүнийг барьцаалсан, барьцаанд байгаа этгээдийн амь насанд заналхийлсэн бол долоогоос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ хэргийн улмаас барьцаанд байгаа этгээдэд хүнд хор уршиг учирсан, эсхүл хохирогчийн амь хохирсон нь хүний амины гэмт хэргийн шинжгүй бол наймаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Үндсэн хуулийн агуулга, үзэл санаа, нийгэм эдийн засгийн шинэ тогтолцооны бодит шаардлагад нийцүүлэн Эрүүгийн шинэ хуулийг 2002 оны 01 сарын 03-ны өдөр ерөнхий ангийг 4 хэсэг 13 бүлэг, 78 зүйлтэйгээр, тусгай ангийг 7 хэсэг 16 бүлэг, 225 зүйлтэйгээр баталжээ.

Энэ хууль батлагдсанаар “хүн хулгайлах”, “хүн барьцаалах”, “хүн худалдаалах” гэмт хэргийн бүрэлдэхүүнд зохих хэмжээний нэмэлт, өөрчлөлт оржээ. Эрүүгийн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг” 16 дугаар бүлэг:

112 дугаар зүйл. Хүнийг барьцаалах

112.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

112.2.Энэ хэргийг:

112.2.1.шунахай сэдэлтээр

112.2.2.онц аюултай гэмт хэрэгтэн

112.2.3 давтан

112.2.4.бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг

112.2.5.барьцаанд байгаа хүний амь биед заналхийлж

112.2.6.зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж

112.2.7.хоёр буюу түүнээс олон хүнийг

112.2.8.насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>158</sup> УИХ-ын Тамгын газрын архив. 1996 оны 4 сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг.73 дэх тал



112.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>159</sup>

Тайлбар: Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

Өмнөх Эрүүгийн хуулийн хүн барьцаалах зүйлийн диспозицид “Бусад этгээдээс мөнгө, хөрөнгө гаргуулахаар” гэснийг тодорхой болгон “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах” гэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнд “шунахай сэдэлтээр”, “бүлэглэж буюу урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг”, “зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж” гэж, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд “зохион байгуулалттай бүлэг”, “гэмт бүлэглэл” гэсэн нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус оруулан хуульчлан заажээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн 113 дугаар зүйлд анх удаа хүн худалдаалах гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцон хуульчилжээ.

Монгол Улсын Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр УИХ-аас хуульчлан баталжээ. Эрүүгийн хуулийн “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг” гэсэн арван гуравдугаар бүлгийн 13.3 дугаар зүйлд:

Хүн барьцаалах

1.Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж

2.2.хоёр, түүнээс олон хүнийг барьцаалж

2.3.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг ялаас чөлөөлнө.

2002 оны оны Эрүүгийн хуулийн хүн барьцаалах зүйлийн диспозицид “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс мөнгө, бусад эд хөрөнгө гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх, эсхүл үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулах болзол тавьж хүнийг барьцаалсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэснийг “ Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...” гэж өөрчилсөн, өмнөх хуульд хүн барьцаалах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний объектив талын шинжийг товч тодорхой томъёолсон бол Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д энэ хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг утга уялдаа муутай, оновчтой биш тодорхойлж, хорих ялын санкцийг чангаруулсан.

Мөн өмнөх хуульд заасан энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээс “...шунахай сэдэлтээр, онц аюултай гэмт хэрэгтэн, давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, барьцаанд байгаа хүний амь биед заналхийлж, зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэж ...” гэснийг хассан. Мөн энэ хэргийг онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд “... зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэснийг “зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчилж, “...гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол ...” гэснийг буюу онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хасч, хүндрүүлэх бүрэлдэхүүнийг өөрчлөн үлдээж, ялын бодлогын хувьд хөнгөрүүлсэн байна.

Энэ зүйлийн тайлбар “Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэснийг “барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг ялаас чөлөөлнө” гэж өөрчилсөн. Өмнөх Эрүүгийн хуулийн энэ хэргийн тайлбар хэсэгт барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй заасан бол Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн мөн хэсэгт энэ хэргийн улмаас

<sup>159</sup> Баярсайхан Б. Жанцан С. нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). -Уб., 2011. 729 дахь тал

барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан бол зөвхөн ялаас чөлөөлөхөөр заасан байна.

### **Дүгнэлт**

Монголын хууль цаазад Хүн барьцаалах гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэж байсан хэм хэмжээ 1996 оноос өмнө байгаагүй ч гэсэн түүхэн уламжлалаас харахад хүн барьцаалах гэмт хэрэгтэй төстэй хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, богтлох барих, хорих, цагдах, булаах, барьцаа болгох зэрэг явдал байсан гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Хүн барьцаалах гэмт хэрэгтэй төстэй үйлдэлд, өөрөөр хэлбэл, гэмгүй хүнийг хүч хэрэглэн хууль бусаар барих, хорих, булаах, хулгайлах хүний эрх чөлөөг хязгаарлаж барьцаа болгох үйлдлийг уламжлал болгон хориглож, тэргүүн дэд зэрэг өндөр цол хэргэмийг ялгалгүй шударгаар шийтгэж, гэмт хэрэгт хамтран оролцсон буюу хамаарч буй этгээдүүдэд ял шийтгэл ялгамжтай оногдуулж байжээ.

Монгол хүн, гадаадын иргэнтэй хамжиж уг хэргийг үйлдэх аваас гадаад улсын түшмэлийн хамт нийлж хянан байцаагаад өөр өөрийн хууль бичгийн ёсоор шийтгэхээр зүйлчилжээ.

БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийг 1924 онд баталж, түүний үзэл санаанд тулгуурлан анхны Шүүх цаазын бичгийг баталсан явдал нь хууль тогтоох үйл ажиллагаанд гарсан том амжилт, хууль цаазын үндэсний уламжлал, зан заншил, ардчилсан хувьсгалт төр, нийгмийн хөгжлийн өвөрмөц онцлогийг тусгасан, эрүүгийн эрх зүйн онол хөгжих гол эх сурвалж, суурь үндсийг тавьсан байна.

Түүнчлэн 1940, 1960 онд шинэчлэн батласан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй Эрүүгийн хуулийг 1942, 1961 онд шинэчлэн боловсруулж, батлан гаргасан, энэ хуулиар тусгаар тогтнол, төрийн бүрэн эрх, нийгмийн болон төрийн байгууламж, социалист өмч, иргэдийн амь бие, эрх, эрх чөлөө нийгэм төр байгууллага, иргэдийн өргөн агуулгатай амин чухал эрх ашиг сонирхлыг хамгаалалтад авсан, өмнөх хуулиудтай харьцуулбал тогтолцоо бүтцийн хувьд илүү боловсронгуй болсон байна. Дээр дурдсан Эрүүгийн хуульд “хүнийг хууль бусаар барих, хорих, нуух, булаах” зэрэг үйлдэл тусгагдсан бөгөөд тухайн үед хүн барьцаалах үйлдэл гарвал тус зүйлээр зүйлчлэн шийдвэрлэх үндэстэй байжээ.

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль нь Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, Монгол Улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх, иргэний ардчилсан нийгэм хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Монгол Улсын Эрүүгийн хуульд 1996 онд “хүн барьцаалах” явдлыг анх удаа гэмт хэрэгт тооцон оруулж, хүн барьцаалах гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх бодит нөхцөл боломж бүрдсэн байна.

Монгол Улсын 2002, 2015 оны Эрүүгийн хуулийн “Хүн барьцаалах” зүйлд зохих хэмжээний нэмэлт өөрчлөлт оруулсан боловч Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 13 дугаар бүлгийн 13.3 дугаар зүйл (Хүн барьцаалах) уг гэмт хэргийг үндсэн бүрэлдэхүүн, хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж, ялын санкцуудыг зөв оновчтой тодорхойлох зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

### **Ашигласан материал**

1. Ж.Амарсанаа, Б.Баярсайхан, Б.Чимид нар. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл II боть УБ., (1911-1926) 2010.
2. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумъяацэрэн нар Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал түүхэн (1911-2009), 2011.
3. Г.Совд “БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс” (ерөнхий анги).УБ.,1973.
4. Г.Совд. Дурдсан зохиол. УБ., 1973.
5. Д.Адъяабазар. Монгол улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1998.
6. Б.Содовсүрэн “БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1971. 7. Д. Адъяабазар. Дурдсан бүтээл.
8. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Тэргүүн дэвтэр. УБ., 2002.
9. УИХ-ын тамгын газрын архив. 1996 оны 4 сарын 1-ний өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг

## АРГАГҮЙ ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ АСУУДАЛ

Л.Бат-Очир

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн хошууч*

XIX зууны эцэс, XX зууны эхэн үеийн эрүүгийн эрх зүйн сонгодог бүтээлүүдэд тусгалаа олсон эрүүгийн эрх зүйн олон тулгуур ойлголтыг XX зууны сүүлээр зарим улс хууль тогтоомжид хэрэглэж эхэлсэн нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан хөгжихөд ихээхэн түлхэц болсон юм.

Дундад зууны үеийн хөрөнгөтөнүүд албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны эсрэг хийсэн хамгаалалтыг хууль бус хэмээн үзэж эрүүгийн ял оногдуулдаг байсан нь аргагүй хамгаалалтын хэм хэмжээ нь чинээлэг, эрх мэдэл бүхий субъектийн эрх ашгийг илүү хамгаалахад чиглэж байжээ гэж пүгнэж болохоор байна. Германы хөрөнгөтний эрүүгийн эрх зүйн онолд аргагүй хамгаалалтыг эрх зүйн бие даасан бус, хавсрага институт, гарцаагүй тохиолдолд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг, хувь хүний үйлдлээр нөхөх тухай асуудал хэмээн үздэг байв. Тиймч учраас хохирогч цагдаагийн алба хаагчын тусламж авч чадахгүй байгаа нөхцөлд, хязгаарлагдмал хүрээнд хамгаалалт хийж болохоор заасан.

Энэ онолд аргагүй хамгаалалтыг хувь хүний субъектив эрх гэж үзэхээс шууд татгалзсан байдаг. Энэ нь тухайн үеийн Францын хувьсгалын дэвшилтэт үзэл санааны эсрэг гарч ирсэн улс төрийн бодлогын илэрхийлэл байлаа. Тухайн үед шашин, ёс суртахууны зарчмууд, тухайн төр улсын нийгэм, эдийн засгийн байгууллын онцлог, хувь хүний эрх зүйн байдал нь хууль тогтоогчийн байр суурийг тодорхойлж байжээ. Ийм учраас аргагүй хамгаалалтын онолын үзэл баримтлал нь нийгмийн хөгжлийн тодорхой өөрчлөлтийн үед тухайн нийгмийн харилцааны онцлогыг илэрхийлэхээс гадна, зохицуулалтын хувьд улам боловсронгуй болж хөгжсөөр байв. Төрөлжсөн хуулийн анхдагч загвар болох Францын 1810 оны эрүүгийн хуульд, хууль ёсны зөвшөөрөгдсөн хамгаалалтыг тусгасанаас хойш аргагүй хамгаалалтыг гэмт хэрэгт тооцохгүй байх зарчим үйлчилж эхэлсэн гэж үзэх үндэстэй.

Дээр дурдсанаас дүгнэж үзэхэд аргагүй хамгаалалтын эрх нь түүхэн цаг хугацааны явцад үүсэж, хөгжих явцдаа жам ёсны эрхүүдийн нэг адил, Үндсэн хуулиар баталгаажуулсан, хувь хүний амьд явах эрх болон бусад хууль ёсны эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах эрүүгийн эрх зүйн гол баталгаа, эрүүгийн хуульд заасан онцгой эрх, иргэдээс өөрийн болон ойр дотны хүний амь бие, эд хөрөнгө, эрүүл мэндийг нийгэмд аюултай халдлагаас хамгаалах онцгой баталгаа, эрх зүйн хэм хэмжээг зөрчих явдалтай эвлэрэшгүй тэмцэхэд нийтийн идэвхийг өрнүүлэх нэг чухал хэрэгсэл юм.<sup>160</sup>

Аргагүй хамгаалалтын агуулга нь аргагүй хамгаалалт хийх нь өөрийгөө хамгаалах жам ёсны эрх ба аргагүй хамгаалалтын хэм хэмжээний мөн чанар нь иргэдийг гэмт явдалтай хийх тэмцэлд татан оролцуулахад бус, харин аргагүй хамгаалалтын эрхийг амьдралд хэрэгжүүлэх, амьд явах эрхийг хангах жинхэнэ баталгааг бий болгоход оршино. Аргагүй хамгаалалтын хууль зүйн үр дагавар нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөд бус харин түүний нийгэмд аюултай шинжийг үгүйсгэх явдал бөгөөд аргагүй хамгаалалтын нөхцөл байдалд нийтийн болон хувийн эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах явдлыг эрүүгийн эрх зүйд иргэн бүрийн хууль ёсны үүрэг гэж үзэхгүй, харин тэдний эрх гэж үзэх нь зүйтэй.

Иймд хуульд заасан аргагүй хамгаалалтын ойлголт түүний дотоод мөн чанарыг нэг мөр ойлгох нь хуулийг нэг мөр дагаж мөрдөх Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах баталгаа төдийгүй, аргагүй хамгаалалтыг хэрэгжүүлж байгаа хүний үйл ажиллагаа, оюун санаа, хүсэл зориг нь нь юуны өмнө хууль ёсны бөгөөд нийгэмд ашигтай, сайн сайхан зүйлд чиглэсэн байдаг тул тухайн үйл явдлын нийгмийн хор аюулыг үгүйсгэдэг энгийн нөхцөл төдий биш гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн улс төр хууль цаазны чухал ойлголт юм.

Эрүүгийн хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан аргагүй хамгаалалтын хэм хэмжээ нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд чухал байр суурь эзэлдэг тулгуур асуудлын нэг бөгөөд юм түүнийг онол-практикийн үүднээс судлах шаардлага зайлшгүй тулгарч байгааг илтгэн харуулж байна. Онол практик нь байгаль, нийгмийг танин мэдэх, хувирган өөрчлөх, хүмүүсийн нийгэм, түүхэн, биет үйл ажиллагааны оюуны хийгээд материаллаг талыг тэмдэглэсэн философийн категориуд бөгөөд онол нь үйл ажиллагааны зорилгыг төлөвшүүлж түүнд хүрэх арга замыг тодорхойлдог оюуны үйлдвэрлэлийн үр дүн гэж үзэж болох ба тухайн ойлголтын хэлбэрээр оршин байдаг. Тэгвэл практик нь нийгмийн харилцааг хөгжүүлж буй хүний амьдралын үндэс

<sup>160</sup> .Эрүүгийн хуулийг тайлбарласан УДШ-ийн бүгд хурлын 30-р тогтоол.УБ.,1980.3 дахь хэсэг.

болсон материаллаг үйлдвэрлэлийн объектив үйл явц, тэдгээрийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааны бусад хэлбэр юм. Танин мэдэхүйд практик нь түүний үндэс, үнэний шалгуур болно. Онол болон практик үйл явцын хоорондох эсрэг тэсрэг байдлыг даван туулах, харшилдуулах объектив нөхцлийг арилгаж, онол практикийг нягт холбохгүй, практик туршлагыг онолоор дүгнэхгүй, шинжлэх ухааны онолыг практикт нэвтрүүлэхгүйгээр тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Орчин үед эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь 1980-аад оны үеэс дэлхий дахинд бий болсон нийгэм, улс төр, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтийн үр нөлөөгөөр ихээхэн шинэчлэгдэж даяарчлагдан шинжтэй болж байна. 1990-ээд оноос эхлэн дэлхийн 50 гаруй улс шинэ эрүүгийн хуультай болж, хуучин социалист улсуудын эрүүгийн хуульд ихээхэн өөрчлөлт орсоны зэрэгцээ, энэрэнгүй ёсны зарчимд суурилсан, шинэ төрлийн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, олон улсын шинжтэй болох зэрэг чиг хандлагатай болж байна. XIX зуунд Европ, Америкт өрнөсөн хөрөнгөтний хувьсгалын нөлөөгөөр эрх зүйн тогтолцооны суурь зарчим нь хүний эрх чөлөө, эрх зүйт төр болж, эрүүгийн эрх зүйн шинж чанарыг тодорхойлох болсон юм<sup>161</sup>.

Аливаа үзэгдлийн түүхэн уламжлалыг судлахгүйгээр, түүний үүсч хөгжсөн зүй тогтол, мөн чанар, агуулгыг зөв танин мэдэх, шинжлэх ухааны үндэстэй үнэлэлт, дүгнэлт өгөх, уг хэмжээний цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжгүй бөгөөд Ардын хувсгалын дараа үеийн эрүүгийн хууль тогтоомжуудад аргагүй хамгаалалтыг хэрхэн хуульчилсан байдлыг авч үзье. Тухайлбал 1921 оны шүүх цаазын бичгийн гуравдугаар бүлгийн /ял үл хэлэлцэх/ 22 дугаар зүйлд **өөрийн буюу бусдын амь биеийг буюу эрх чөлөөг хамгаалахын тулд** үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бол ял үл хэлэлцэнэ<sup>162</sup> гэсэн нь аргагүй хамгаалалтыг нилээд өргөн хүрээнд хэрэглэх, мөн хэр хэмжээтэй байх талаар тусгасан байна. Тэгвэл 1926 оны БНМАУ-ын шүүх цаазын бичигт зарчмын хувьд аргагүй хамгаалалтыг талаар нэмэлт өөрчлөлт ороогүй бөгөөд,<sup>163</sup> 1929 оны шүүх цаазын бичгийн 23 дугаар зүйлд **өөрийн буюу бусдын амь бие, эрх чөлөөг хамгаалах, мөн тэрчлэн эдүүгээгийн улс төрийн амгалан байдал дор холбогдох аливаа зүйлүүдийг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь хэр хэмжээнээс хэтрээгүй бөгөөс ял үл хэлэлцмөй**,<sup>164</sup> гэжээ. Энэ нь улс төрийн байгуулаллыг бэхжүүлэх үйл хэрэг, нам засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийг татан оролцуулах, Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний жам ёсны эрхийн гол баталгааг хүлээн зөвшөөрөх, гэмт хэрэгтэй тэмцэх, идэвхийг өрнүүлэхэд ихээхэн анхаарч байсны илэрхийлэл юм. Дээрх үзэл баримтлал 1934 оны шүүх цаазын бичиг, 1942, 1961, 1986 оны эрүүгийн хуулиуд батлан мөрдөгдөхөд өөрчлөгдөөгүй юм. Монгол улсад зах нийгмийн шинэ харилцаанд шилжсэнээр хууль тогтоомжийг шинэчлэх үйл явц эрчимтэй явагдаж эхэлсэн ба энэ үйл явцын хүрээнд эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын их хурлаас баталсан. Энэ хуулийг батлахад эрүүгийн хуулийн хэм хэмжээг Үндсэн хууль, Монгол улс нэгдэн орсон олон улсын гэрээний агуулга, үзэл санаа хүн төрөлхтөний нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлд бүрэн нийцүүлэх, нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл байдал, хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг эрүүгийн хуулиар хамгаалах явдлыг улам боловсронгуй болгох талаар илүү анхаарч, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг анх удаа бие даасан бүлэг болгон хуульчилж, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны орчин үеийн хөгжлийн чиг хандлага, олон улсын жишигт нийцүүлсэн онцлог хууль болсоныг судлаачид хүлээн зөвшөөрдөг. Эрүүгийн эрх зүйн ном, бүтээлүүдэд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг бие даасан байдлаар хуульчилж тусгайлан институт болгон хуульчлах зайлшгүй шаардлага байгааг 1996 оноос хойш бичиж эхэлсэн хэдий ч зургаан жилийн дараа дээрх хуульд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын таван төрлийг хуульчилсан нь онолын маргаан өрнүүлсэн төдийгүй Монгол улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд эрүүгийн эрх зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэх, эрүүгийн эрх зүйн үйлчлэлд практикийн чухал асуудлуудыг шийдвэрлэхэд нэн чухал алхам болсон төдийгүй эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааныг сонирхон судлагч хэн бүхэнд судалгааны томоохон объект болж байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл. **Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа** энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй. Хүн бүр албан тушаалын байдал, мэргэжил хуулиар

<sup>161</sup> Болдбаатар.Ж.Эрүүгийн эрх зүйн орчин үеийн чиг хандлага.ХЗҮХ.УБ.,2017.Хүндэтгэлийн лекц.6 дугаар тал.

<sup>162</sup> Дашням.И, Далайбаяр.Д.БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл.УБ.,1926.Цуврал №1.8 дугаар тал.

<sup>163</sup> Дашням.И, Далайбаяр.Д.БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхэтгэл.УБ.,1926.Цуврал №1.8 дугаар тал.

<sup>164</sup> .Адъяабазар.Д.Монгол улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт.УБ.,1998.41 дүгээр тал.

хүлээлгэсэн үүрэг, албаны тусгай бэлтгэлээс хамаарахгүйгээр аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Хамгаалагч нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй<sup>165</sup> гэж заасан нь урд урдны эрүүгийн хуулийн зохицуулалтаас илүү дэвшилттэй алхам болсон боловч уг институтын мөн чанарыг бүрэн илэрхийлсэн зохицуулалт болж чадаагүй юм. 2002 оны эрүүгийн хуульд аргагүй хамгаалалтын хэм хэмжээгээр хамгаалж болох ашиг сонирхолыг ийм өргөн хүрээнд тодорхойлсон нь хувь хүний ашиг сонирхолыг нийгмийн ашиг сонирхолтой ямагт холбоотой авч үздэг бөгөөд төр, нийгэм, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагын хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахад иргэдийн идэвхийг дэмжсэн явдал байжээ. Гуравдагч этгээдийн ашиг сонирхолыг гэмт халдлагаас хамгаалахад эрх ашигт нь хохирол учрах байсан тухайн этгээдийн зөвшөөрөл авсан эсэх нь асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлэхгүй. Харин гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, үзлэг, нэгжлэг хийх зэрэг хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулж байгаа үйл ажиллагааны эсрэг аргагүй хамгаалалт хийж болохгүй.

Энэ хуулиар аргагүй хамгаалалтын хэр хэмжээ хэтрүүлэх тухай ойлголтыг халсан бөгөөд уг хамгаалалт нь хууль ёсны эсэхийг тодорхойлох чухал шинж буюу тодорхой гэмт хэргийг үйлдсэн цаг, нөхцөл, довтолгооны шинж, халдлагын нийгмийн хор аюулын хэмжээ хязгаар, хамгаалж буй объектын онцлог зэрэг олон хүчин зүйлийг харгалзан тогтоож байв.

Аргагүй хамгаалалт хийсэн этгээд довтолгоон болон бусад объектив хүчин зүйлээс болоод довтлогч этгээдийн хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, нийгмийн хор аюулыг урьдчилан бүрэн ухамсарлаж аргагүй хамгаалалтын арга хэрэгсэлээ зөв сонгох боломжгүй байх тохиолдол байдаг. Гэмт халдлагаас хамгаалах эрх нь иргэн бүрийн хуулийн хэм хэмжээг биелүүлэх, нийгмийн сөрөг болох гэмт хэрэгтэй тэмцэх үүргийн салшгүй нэг хэсэг бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж байгаа чухал хэлбэр байснаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг саатуулахын тулд иргэдээс хийсэн хориглох саатуулах ажиллагааг аргагүй хамгаалалттай адилтган үзэж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай эрүүгийн хуульд заасан явдлыг бие даасан зүйл болгон өөрчилсөн нь олон нийтийн идэвх оролцоог идэвхжүүлэн өрнүүлэх эрхийг хангаж байгаа чухал заалт байсан юм. Энэ талаар Судлаач Х.Түдэв: Гэмт хэрэгтнийг хууль зүйн дагуу хориглон тогтоосон явдал нь аргагүй хамгаалалтын нэгэн адил нийгэмд ашигтай бөгөөд, иргэдэд хуулиар олгосон эрх мөн учраас гэмт хэрэгт тооцоггүй юм” гэжээ<sup>166</sup>.

Нөгөө талаар аргагүй хамгаалалтын хүрээ, хязгаарыг хэт өргөнөөр тодорхойлох нь түүнийг практикт шинжлэх ухааны үндэслэлтэй зөв ойлгож оновчтой хэрэглэх боломжыг хязгаарлаад зогсохгүй, гэмт этгээдэд ял завших, хүний эрхийг зөрчиж зэрэг сөрөг үр дагавар гарах нөхцөл бүрдэх юм. Тийм учраас уг хэм хэмжээний агуулаг мөн чанарыг онолын түвшинд зөв ойлгож, хэрэглэх зүй ёсны шаардлага тулгарч байна.

Учир нь аргагүй гэдэг үг зайлах боломжгүй, зүй ёсны, маш чухал<sup>167</sup> гэсэн утгатай үг бөгөөд аргагүй байдалд орсон нөхцөлд л гэмт халдлага хийж буй этгээдийн эсрэг хамгаалалт хийх тухай ойлголт юм. Гэтэл хоёр дахь хэсэгт хамгаалагч нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй<sup>168</sup> гэж заасан нь аргагүй хамгаалалтын мөн чанарыг үгүйсгэж, практикт онолын өндөр мэдлэгт тулгуурлан гэмт хэргийг шийдвэрлэх, шүүхийн жишиг, зөвлөмж, тайлбарыг харгалзах нөхцлийг үүсгэх боломжтой.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж, 2017 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба уг хуулийн дөрөвдүгээр бүлэгт гэмт хэргийг үгүйсгэх зургаан нөхцөл байдлыг тусгаж, аргагүй хамгаалалтыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1.Өөрийн, ойр дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

2.Аливаа хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай довтолгооноос зайлсхийх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй.

3.Аргагүй хамгаалалтыг бусдын хууль бус халдлага эхэлсэн, эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хийнэ. Довтолгоо төгссөн хойно хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй.

<sup>165</sup> Эрүүгийн хэрэг.ХЗҮХ./эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/.УБ.,2013.18 дугаар тал.

<sup>166</sup> Х.Түдэв.БНМАУ-ын Эрүүгийн эрх дэх аргагүй хамгаалалтын тухай асуудал.УБ.,1972.31 дэх тал

<sup>167</sup> Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь.УБ.,1985.693 дахь тал

<sup>168</sup> Эрүүгийн хэрэг.ХЗҮХ./эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/.УБ.,2013.18 дахь тал

4.Хуульд заасны дагуу галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх, хэрэг шалган шийдвэрлэх явцдаа, харуул хамгаалалтын албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж хуулийн дагуу хийсэн үйлдлийг эсэргүүцсэн хариу үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй.

Тайлбар: -Энэ хуульд заасан “Ойр дотны хүн” гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно” гэж тус тус заажээ.

Уг хуулиар нэгдүгээрт 2002 оны Эрүүгийн хуулийн зарим дэвшилттэй зүйлээс ухарсан явдал нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны ололт амжилтыг бататгах бус хүний жам ёсны эрхийг үгүйсгэсэн, практикт маргаантай байдал бий болгох нөхцлийг бүрдүүлсэн гэж дүгнэж болно. Хоёрдугаарт зөвхөн өөрийн болон ойр дотны хүний эсрэг хийсэн нийгэмд аюултай довтолгооны эсрэг аргагүй хамгаалалт хийх эрхтэй ба гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд халдсан довтолгооныг таслан зогсоохын тулд хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй ба эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлийн нэг дэх хэсгээр шийдвэрлэж болох юм. Энэ нь сүүлийн үед дэлгэрч байгаа “Аргагүй хамгаалалт нь зөвхөн өөрийгөө хамгаалах зарчим дээр үндэслэж болно”<sup>169</sup> гэж үздэг монизм онолын үзэл баримтлалтай холбоотой.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлд баривчлах, таслан зогсоох үед хэр хэмжээ хэтрүүлэхгүй байх хуулийн нийтлэг шаардлага байгаа нь хууль сахиулагчид, иргэд нэгэн адил үүргийг хүлээлгэсэн явдал бөгөөд энэ нь харилцан адилгүй учир ялгамжтай хандах шаардлагатай.

Практикт өмчийн эсрэг гэмт хэргүүд нийт гэмт хэргийн бүтэцэд 50 орчим хувийг эзэлж байгаа өнөө үед, хүний эрх, эрх чөлөөний баталгаа болсон өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах эрхийг баталгаажуулах бус хассан нь шинжлэх ухааны үндэслэлгүй, Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй өөрчлөлт болсон гэж үзэж байна.

Хэрэв хүний эд хөрөнгийг хууль бусаар хүч хэрэглэж авсан бол амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус довтолгоон хийсэн гэж үзэж аргагүй хамгаалалтаар шийдвэрлэх нь зүйн хэрэг, харин хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар авсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг нь тодорхойгүй байна. Эд хөрөнгийн эсрэг хийсэн хууль бус довтолгооны талаар Франц улсын эрүүгийн хуулийн 122 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг<sup>170</sup> эд хөрөнгийн эсрэг хийсэн довтолгооны үед хүний амь нас хохироохыг хориглоно, БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хуулийн 21 дүгээр зүйлд<sup>171</sup> тодорхой төрлийн гэмт хэргийн хууль бус довтолгооны эсрэг хийсэн үйлдэлд аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэнд тооцохгүй гэж заажээ. Өөрөөр хэлбэл, амь нас, эрүүл мэндийн эсрэг хийсэн довтолгооныг таслан зогсоохын тулд хийсэн үйлдэлд аргагүй хамгаалалтын хэр хэмжээ яригдахгүй харин эд хөрөнгийн эсрэг хийсэн довтолгооныг таслан зогсоох үед аргагүй хамгаалалтын хэр хэмжээ яригдана гэсэн үг юм.

Практикт үйлдэгдсэн аргагүй хамгаалалтын шинжтэй зарим үйлдлийг одоогийн эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр, зөв оновчтой шийдвэрлэх боломжгүй, хууль хэрэглээний хувьд маргаантай нөхцлийг үүсгэхээр байна. Ийм учраас дээрх хэм хэмжээний онолын үндсийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв тодорхойлох, түүнтэй холбоотой эрүүгийн хуулийн хэм хэмжээг хэрэглэж буй мөрдөн шалгах болон шүүн таслах ажиллагааны практикийг судлах, гарч буй хүндрэл бэрхшээлийг арилгах, хууль хэрэглэгчид дээрх хэм хэмжээг нэг мөр ойлгож зөв хэрэглэх нь эрүүгийн эрх зүйн эрдэмтэн судлаач, хэрэглэгч хэн бүхний чухал зорилт болоод байна. Аргагүй хамгаалалт нь өдөр тутам, ахуйн хүрээнд хийгдэж байгааг үгүйсгэх аргагүй ба “хэмнэлттэй”<sup>172</sup> хэрэглэж болохгүй. Иймд Эрүүгийн хуулийн 4.1 болон 4.2 дугаар зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна. Үүнд:

“1.Өөрийн, ойр дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг аргагүй байдалд хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

2. Өөрийн, ойр дотны хүний эд хөрөнгийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг аргагүй байдалд хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохироогүй бол аргагүй хамгаалалтыг хэтрүүлсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

<sup>169</sup> Э.Хилгендорф, Д.Чанцалдулам.Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги.УБ.,2015 он.63 дахь тал.

<sup>170</sup> Л.Бат-Очир.Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлууд болон аргагүй хамгаалалтын асуудал.УБ.,2011.52 дугаар тал.

<sup>171</sup> Б.Батзориг, Э.Зууннасан.БНХАУ-ын эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.,2006.14 дахь тал.

<sup>172</sup> Шүүхийн практикт, улсын хэмжээнд жилдээ аргагүй хамгаалалтаар шийдвэрлэж байгаа хэргийн тоо 10 хүрэхгүй байгаа нь хангалтгүй тоо юм.

3. Гуравдагч хүний хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг аргагүй байдалд хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй бөгөөд эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хамаарна.

2. Аливаа хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай довтолгооноос зайлсхийх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан бол тухайн боломжыг ашиглах ба эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй.

3. Аргагүй хамгаалалтыг бусдын хууль бус халдлага эхэлсэн, эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хийнэ. Довтолгоо төгссөн хойно хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй.

4. Хуульд заасны дагуу галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх, хэрэг шалган шийдвэрлэх явцдаа, харуул хамгаалалтын албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж хуулийн дагуу хийсэн үйлдлийг эсэргүүцсэн хариу үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй.

Тайлбар: -Энэ хуульд заасан “ойр дотны хүн” гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно” гэж нэмж өөрчлөх буюу өөрөөр хэлбэл аргагүй хамгаалалтын зохицуулалтанд амь нас, эрүүл мэндийн эсрэг хийсэн довтолгооны эсрэг хамгаалалт хийх үед хэр хэмжээ яригдахгүй харин, эд хөрөнгийн эсрэг хийсэн довтолгооны эсрэг хийсэн хамгаалалт нь хэр хэмжээнд хийгдэх ёстой гэж өөрчлөн найруулж хуульчлах шаардлагатай байна.

# ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ХАМГААЛАХ ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧАНАР, СТАНДАРТ, АНХААРАХ АСУУДАЛ

Ш.Чулуун

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Албаны тусгай бэлтгэлийн  
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

**Товч агуулга:** Цагдаагийн албаны хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, хамгаалах тусгай хэрэгслийн чанар, олон улсын стандартад нийцэж буй эсэх талаар санал, зөвлөмж боловсруулсан.

**Түлхүүр үг:** Цагдаагийн албан хаагч, хамгаалах тусгай хэрэгсэл, эрх зүйн зохицуулалт, стандарт.

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн<sup>173</sup> гэж холбогдох хуулинд чиг үүргийг нь тодорхой зааж өгчээ.

Ялангуяа гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг бүхий алба хаагчдад хамгаалах тусгай хэрэгслийг тавьж олгодог бөгөөд уул тусгай хэрэгслийг тухайн алба хаагч нь ямар үндэслэл бүхий нөхцөл байдал бий болсон, хэрэгцээ шаардлага, ямар ажиллагаанд оролцож байгаагаас хамааралтайгаар ялгамжтай байдлаар хэрэглэдэг байна. Тухайлбал, Цагдаагийн байгууллага нь баривчлах, саатуулах, эрүүлжүүлэх байранд үүрэг гүйцэтгэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа, гэмт этгээдийг мөрдөх, онц хүнд, хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, хуяглан хүргэх, гэмт хэрэг үйлдсэн сэжигтэй этгээдийг байж болзошгүй газарт нэгжлэг хийх зэрэг эрсдэл бүхий аливаа бусад арга хэмжээнд оролцож байгаа алба хаагчид хамгаалах тусгай хэрэгслийг тухай бүр тавьж олгон улмаар үйл ажиллагаандаа алба хаагч нь ашиглаж байна.

Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрх болон үндэслэл журам, аргачлалыг Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017-12-20-ны өдрийн А/248 тоот тушаалд<sup>174</sup> тус тус тусгайлан зааж өгсөн байна.

Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана. Цагдаагийн алба хаагч биедээ хамгаалах тусгай хэрэгсэл байхгүй тохиолдолд гарцаагүй байдал, аргагүй хамгаалалт, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах шаардлагатай болсон үед гарын доорх эд зүйлийг тусгай хэрэгслийн зориулалтаар ашиглаж болно<sup>175</sup> гэж тусгайлан заалт болгон оруулсан.

Алба хаагчийн хийж гүйцэтгэж байгаа албаны чиг үүргээс шалтгаалан хамгаалах хувцас хэрэгслийг тус журамд дор дурдсан байдлаар дараах нэр томъёонд бүлэглэн ангилсан байна.<sup>176</sup> Үүнд:

**“Хамгаалах тусгай хэрэгсэл”** - Тусгай үүрэгт ажил гүйцэтгэх явцад цагдаагийн алба хаагчийн эрүүл мэндэд учрах аюул, амь насаа алдах, хурц хордлогод орох зэрэг эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хувцас, өмсгөл, хэрэгслийг;

**“Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл”** - Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг;

**“Тусгай хувцас”** - Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгслийг гэж тус тус тодорхойлжээ.

Цагдаагийн алба хаагч шаардлагатай тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүнд албадлагын шинжтэй хүч хэрэглэн халдах эрхтэй байдаг. Энэ эрхийг хэрэглэх нэг механизм нь албанд хэрэглэж байгаа галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч юм.

Харин хамгаалах тусгай хэрэгслийн онцлог нь алба хаагчийн өөрийн амь нас, эрүүл мэндийг гадны гэмт халдлага болон бусад аюултай нөхцөл байдлаас хамгаалж байдаг.

<sup>173</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг

<sup>174</sup> Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам” /ЦБҮАЖ-ын код-918/

<sup>175</sup> Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 5-р бүлгийн 50.3, 50.4 дэх хэсэг

<sup>176</sup> Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам ЦБҮАЖ-ын 918.2 дахь хэсэг



Өөрөөр хэлбэл албаны бусад тусгай хэрэгсэл нь гэмт этгээдийн хөдөлгөөн, учруулж болох хор аюулыг зайлуулахад чиглэгдсэн зорилгыг агуулж байхад хамгаалах тусгай хэрэгсэл нь алба хаагчийн өөрийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байдгаараа онцлог юм.

Цагдаагийн байгууллага нь албандаа дор дурдсан нэр, төрлийн хамгаалалтын хэрэгслүүдийг ашиглаж байна.<sup>177</sup> Үүнд:

а/Төрөл бүрийн дуулга, иж бүрэн өмсгөл (доргилт, тэсрэлтийн нөлөөнөөс хамгаалах, сумнаас хамгаалах, бусад хатуу биетээс хамгаалах мөр, тохой, шуу, эмзэг эрхтэн, гяа, өвдөг, шилбэ, гутлын хамгаалах хэрэгсэл);

б/Бамбай (сум үл нэвтрэх 1, 2, 3 дугаар түвшний хамгаалалтын бамбай, бусад хатуу биетээс хамгаалах 1 дүгээр түвшний хамгаалалтын хуванцар бамбай);

в/Бээлий (хутганаас хамгаалах, бусад);

г/Том, бага оврын тэсрэлтээс хамгаалах зөөврийн чингэлэг (том, бага оврын тэсрэлтээс хамгаалах хуягласан чингэлэг, хуванцар, хийлдэг чингэлэг);

д/Бүтээлэг (хүн, эд зүйл, цогцос, техник хэрэгсэл халхлах, бүтээх зориулалттай бүтээлэг);

е/Галд тэсвэртэй хувцас;

ж/Хорт утаа, биологийн болон химийн бодисоос хамгаалах баг, өмсгөл;

з/Дуу, гэрлийн нөлөөллөөс хамгаалах баг, өмсгөл;

и/Авиралт, буултын хамгаалалтын олс, уналтаас хамгаалах бусад төхөөрөмж (олс, бусад бэхлэх төхөөрөмжүүд, төрөл бүрийн зориулалтын шат);

к/Төрөл бүрийн сум, хутга үл нэвтрүүлэх, гэрэл ойлгогчтой хантааз (1, 2, 3 дугаар түвшний сум үл нэвтрүүлэх хантааз, хутга, тэсрэлт доргилт, цохилтын нөлөөнөөс хамгаалах хантааз);

л/Тусгай зориулалтын гар чийдэн;

м/Тактикийн болон олон зориулалттай хутга;

н/Хамгаалалтын тор, олс, хаалт;

о/Нүдний шил (буудлага, тактик ажиллагааны аюулгүй байдлыг хангах, цас, шороо, шуурганаас хамгаалах) бусад төхөөрөмж гэж тус тус төрөлжүүлэн ангилсан байна.

Ажил мэргэжлийн эрсдэлтэй байдлыг судалсан олон улсын судалгаагаар цагдаагийн ажил нь эрсдэлээрээ эхний дөрөвт бичигдсэн байна. Ийм аюул эрсдэлтэй тул цагдаагийн алба хаагч наад зах нь хөдөлмөр хамгааллын хувцас, албаны зэвсэг, тусгай хэрэгслээр бүрэн хангагдах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Энэ тал дээр сүүлийн үед цагдаагийн төв байгууллага болон удирдлагын түвшинд нэлээд анхаарч ажиллаж байгаа бөгөөд Цагдаагийн албаны тухай хуулинд зааснаар алба хаагч нэг бүр тусгай хэрэгсэл, хамгаалах хувцас буюу хуулийн нэр томъёогоор агсамжийг албан үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэхээр заасан байна. Тодруулбал, Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэх алба хаагчид нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэл, галт зэвсэг олгох бөгөөд алба хаагч нь олгосон тусгай хэрэгсэл, галт зэвсгийг биедээ авч явах эрхтэй<sup>178</sup> гэжээ.

Мөн “Алба хаагч нь амралтын цагаар, эсхүл энгийн хувцастай үүрэг гүйцэтгэх тохиолдолд хамгаалах тусгай хэрэгсэл, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч биедээ авч явж, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэглэж болно.”<sup>179</sup> гэж цагдаагийн албаны тухай хуульд шинээр хэсэг болгон оруулсан нь алба хаагчийн үүргээ биелүүлэх, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахад чухал ач холбогдолтой заалт болсон юм.

Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж явах үедээ эрсдэлд оруулах магадлалыг албаны тусгай хэрэгсэл, тэр тусмаа хамгаалах тусгай хэрэгсэл хангалтгүй байдаг нь эрсдлийг нэмэгдүүлэх шалтгаан нөхцөл болж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд: “Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, цагдаагийн хүрээний болон эргүүл, харуулын дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах”<sup>180</sup>, “Цагдаагийн байгууллагын барилга байгууламж, автомашин, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хувцас, бусад хангамжийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх”<sup>181</sup>, “Цагдаагийн байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг

<sup>177</sup> Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам ЦБҮАЖ-ын 918.3.2 дахь хэсэг

<sup>178</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 60-р зүйлийн 60.3 дахь хэсэг

<sup>179</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 60-р зүйлийн 60.4 дэх хэсэг

<sup>180</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйлийн 21.1.3 дахь хэсэг

<sup>181</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйлийн 21.8 дахь хэсэг

сонирхлыг хамгаалах<sup>182</sup> гэсэн нь Цагдаагийн төв байгууллагын дарга нь алба хаагчийн аюулгүй байдлыг хангах үүргийг хуулинд шинээр тусгаж өгсөн нь эрх зүйн зохицуулалтын хүрээнд шинэлэг болсон бөгөөд алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад нэн чухал ач холбогдолтой заалт болсон юм.

Хамгаалах тусгай хэрэгсэл нь байгууллагын өмч байх бөгөөд алба хаагч нь өмсөж хэрэглэхдээ үйлдвэрлэгчээс гаргасан болон холбогдох зааврын хүрээнд хэрэглэнэ. Цагдаагийн байгууллага алба хаагчдад хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх арга зүйн талаар сургалт зохион байгуулна.<sup>183</sup> Хамгаалах тусгай хэрэгслийг биедээ тохируулан иж бүрэн, цэвэр үзэмжтэй, ариг гамтай эдэлж, албаны бэлэн байдлыг хангаж, шуурхай ашиглахад бэлэн байлгах үүрэгтэй.

Мөн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн чанарын талаар мэргэжлийн байгууллагаар ажил олгогч дүгнэлт гаргуулсан байна. Олон улсын стандартын дагуу үйлдвэрлэсэн, чанарын баталгаа бүхий ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг шууд хэрэглэж болно<sup>184</sup> гэжээ.

Өнөөдөр цагдаагийн албанд ашигладаг хамгаалах болон бусад бүх төрлийн тусгай хэрэгслүүдийг манай улс өөрсдөө үйлвэрлэдэггүй, гадаад орноос импортоор оруулж ирдэг, ирсэн тусгай хэрэгсэл манай орны цаг уур, орчны онцлог нөхцөл байдлаас шалтгаалан чанарын шаардлага хангахгүй, энэ байдлаас улбаалан алба хаагчийн амь нас, аюулгүй байдалд сөрөг үр дагавар гарсаар байна. Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын тусгай хэрэгслийн үйлдвэрээс гол төлөв тусгай хэрэгслүүдийг захиалан авч албанд ашиглаж байна. Учир нь манай 2 орон байгаль, цаг уур, орчны нөхцөл харилцан адилгүй байдаг тул тэдний цэрэг, цагдаагийн албанд ашигладаг тусгай хэрэгслийн чанар стандарт нь манай албаны үйл ажиллагаанд чанарын шаардлага хангахгүй байна.

Иймд цаашид уг сөрөг үр дагаврыг арилгах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамгаалах хэрэгсэл болон бусад техник, тусгай хэрэгслүүдийг Монголын нөхцөлд тохирох эсэх, хамгаалалтын ямар нөхцөлд ашиглах талаар дүгнэлт гаргуулах, үүний тулд туршилт, судалгаа явуулах зайлшгүй шаардлага байна.

Энэхүү үндэслэл бүхий нөхцлийг Цагдаагийн албаны тухай хуульд “Цагдаагийн байгууллага харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж, мэдээлэл нэртгэн боловсруулах, судалгаа, сургалт дадлагын, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лаборатори болон инженер техник, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, санхүү, хангалт, спорт, соён гэгээрүүлэх, мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй байж болно.”<sup>185</sup>

Мөн “Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, газар зүйн байршил, зам харилцааны нөхцөл, бусад онцлогийг харгалзан цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны болон автомашин, тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг Засгийн газар тогтооно”<sup>186</sup> гэж хуульчлан тусгасан нь шинэлэг зүйл болсон бөгөөд энэхүү асуудлын эрх зүйн зохицуулалт болж өгснөөрөө онцлог ач холбогдолтой.

Цаашид олон улсын цагдаагийн байгууллагад ашиглагддаг тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслээр хангагдах, алба хаагчдыг стандартын шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгслээр хангах явдал нэн чухал байна.

2008 оны 7 дугаар сарын 1-нд нийслэлд болсон нийтийн эмх замбараагүй байдлын үйл явдлаас болж цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчид эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон харамсалтай асуудал гарсан билээ.

Иймд энэхүү нөхцөл байдлаас сургамж авч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008-2011 онд утаан гранат, өнгөт утаа гаргагч, хорт утааны баг, сум шидэгч, нулимс асгаруулагч хий, сумнаас хамгаалах бамбай, түрдэг бамбай, хамгаалалтын бамбай, дуулга малгай, иж бүрэн хамгаалалтын хувцас, резинэн бороохой, цахилгаан бороохой, өдрийн дуран, шөнийн дуран, хаалга эвдэгч, цоож эвдэгч буу, авирах буух орс, хамгаалалтын тор, сумнаас хамгаалах хантааз, хутганаас хамгаалах хантааз, "Chey tac" буу, бууны сум, 38 мм-ийн буу, 88 мм-ийн сум, резинэн сум, станцны чихэвч, дохиур мод зэрэг нийт 80 нэр төрлийн 2 тэрбум төгрөгийн галт зэвсэг, хүн нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл авч, цагдаагийн байгууллага, алба хаагчдад хангалт хийсэн юм.

<sup>182</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 21-р зүйлийн 21.9 дэх хэсэг

<sup>183</sup> Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” 2018 он 83 дахь тал

<sup>184</sup> Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” 2018 он 84 дэх тал

<sup>185</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг

<sup>186</sup> Цагдаагийн албаны тухай хуулийн 6-р зүйлийн 6.7 дахь хэсэг

Ингэснээр нийт бие бүрэлдэхүүний нийгмийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг гүйцэтгэх 5684 алба хаагчийн 89.7 хувь нь дуулга малгайгаар, 64.4 хувь нь хамгаалалтын хантаазаар, 66,8 хувь нь тусгай өмсгөлөөр, 15.9 хувь нь хорт утааны багаар, 88.3 хувь нь резинэн бороохойгоор, 79.1 хувь нь бугуйн гаваар, 65.1 хувь нь цахилгаан бороохойгоор, 100 хувь бамбайгаар хангагдсан байна<sup>187</sup> гэсэн судалгаа тоо баримт гарч байжээ.

Хэдийгээр цагдаагийн газар, хэлтэс нь нэг бүрийн/каска-хамгаалалтын малгай, хамгаалалтын бамбай, хамгаалалтын иж бүрэн өмсгөл/ болон бусад хамгаалах тусгай хэрэгслийг авч шаардлагатай үед хэрэглэх зорилгоор бэлтгэл сургуулилт хийж байгаа боловч бидний албан үүргээ гүйцэтгэх үедээ хэрэглэж байгаа хамгаалах хэрэгслүүдийн үзүүлэлт, чанар, стандартыг тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт одоо болтол байхгүй байна.

Иймд цагдаагийн албанд ашигладаг хамгаалах тусгай хэрэгслүүдийн чанар, стандартыг дотооддоо баталж түүнийг албанд мөрдөж ажиллах шаардлагатай байна. Ингэснээр алба хаагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй амар тайван аюулгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэх эерэг нөхцлийг бий болгох юм.

### **Санал**

1. Судалгаа, сургалт дадлагын, албаны зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар стандартыг судлан тогтоох лабораторыг бий болгож үйл ажиллагааг хэвшүүлэх
2. Хамгаалах болон бусад тусгай хэрэгслийн чанар, стандартын талаар дотоодын мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргуулан баталж түүнийг албанд мөрдлөг болгон ашиглах
3. Тусгай хэрэгслийн хангалт, тэдгээрийн эдэлгээний жишиг нормативыг эрх бүхий байгууллагаар тогтоолгох

### **Ном зүй**

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017.02.09
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017.12.20-ны өдрийн А/248 тоот тушаал
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /шинэчлэн баталсан/ 2018.02.25. Код-918 “Хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журам”
- ХЗДХС, УЕП-ын хамтарсан 2017 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А-224/А-102 дугаар тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2018
- ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын тайлан 2011 он

<sup>187</sup> ЦЕГ-ын Санхүү, ар талын газрын тайлан. 2011